- mPR-PZ_{1,2}** Хуримт чулуулаг; хуримт элсэн чулуу, толгойн зонор, кварцит, амфиболт, энгэс, боржин-энгэс

ГАЗРЫН ГАДАРГА ДЭЭРХ УЛ ХӨРСНИЙ БҮРЭЛДЭХҮҮН

ХАДАН УЛ ХӨРС

- +** Хадан
- +** Хайрсаг

СЭВСГЭР УЛ ХӨРС

- Шаваранд, элсэндэр, элсэн дүүрэгтэй бул чулуу ба хайрсаганд
- △** Элсэндэр-шаваранд дүүрэгтэй хэмжээс ба сайр чулуу, хайрсаг
- △** Хайрсаганд
- △** Хайрсаг, сайр чулуу
а) элсэндэр
б) элсэндэр-шаваранд дүүрэгтэй
- △** Элсэндэр, шаваранд, шавар
- △** Элс

ЦЭВДГИЙН БҮС БҮСЛҮҮР

- ▨** Тасалданаг ба урсгалын тархсан олон жилийн цэвдэг чулуулаг; жилийн дундаж температур нь голдуу -3°C-аас доош, зузаан нь 500 м хүртэл;
а) жилийн дундаж температур нь голдуу -1.5°C-аас -3°C хүртэл, зузаан нь 250 м хүртэл
- ▨** Агаар цоог тархсан олон жилийн цэвдэг чулуулаг; жилийн дундаж температур нь голдуу -0.8°C-аас -1.5°C хүртэл, зузаан нь 120 м хүртэл
- ▨** Хөвөр агаар цоог тархсан олон жилийн цэвдэг чулуулаг; жилийн дундаж температур нь голдуу -0.5°C-аас -0.8°C хүртэл, зузаан нь 50 м хүртэл
- ▨** Тасалданаг байдлаар тархсан олон жилийн цэвдэг чулуулаг; жилийн дундаж температур нь голдуу -0.5°C-аас доош, зузаан нь 1.5 м хүртэл
- ▨** Цэвдгийн бүс бүслүүрийн хил

ШИМ ЕРТӨНЦ БҮРЭЛДЭН ТОГТСОН ТҮҮХ

Бүгд Найрамдах Монгол Ард Улс бол эртний амьтан, ургамлын хувьд Ази тивд хамгийн сайн судлагдсан орны нэг юм. Гол бүлэг амьтан, ургамал өнө эртнээс нааших эрин үеүүдэд хэрхэн тархаж байсныг атласын энэ бүлэгт тусган харууллаа. Эрт төрмөлийн эриний зурагт тэнгис далайгаар бүрхэж байсан нутаг, эх газрын муж, мөн тэнгис ба эх газрын нөхцөл дахин давтан солигдож байсан нутгийг харуулсан бол дунд-шинэ төрмөлийн эриний зураг дээр триас-юррийн галавын тэнгисээс гадна нуур-голын хурдас, галт уулын чулуулаг хуримталсан мужууд, элэгдэл эвдрэлийн бүсийг ялган үзүүлсэн юм. Энэ бүлгийн зургийг зохиоходоо БНМАУ-ын ШУА, ЗСБНХУ-ын ШУА-ийн Монгол-Зөвлөлтийн хамтарсан геологи, палеонтологийн экспедицийн судалгааны дүнг үндэс болгосноос гадна эртний амьтан, ургамлын үлдэгдэл олдсон тэмдэглэсэн мэдээ сэлтийг ашиглав.

Тус орны нутаг дахь хамгийн эртний шим үлдэгдэл рифейн үеийн шохойлог чулуулгаас олдсон бөгөөд энэ нь хөх ногоон замгийн амин ажиллагааны бүтээгдэхүүн болсон строматолит, онколит хоёр юм. Вендийн үеийн чулуулагт энэ мэтийн үлдэгдэл онцгой их байдаг нь тэр үед БНМАУ-ын нутаг дэвсгэрийн 75%-иас илүүг гүехэн тэнгис эзэлж байсныг гэрчилж байна. Вендийн үед тэдгээр тэнгист араг ясгүй амьтад оршиж байсан бол дараагийн кембрийн үеэс эхлэн араг ястай (хавтас бүрээстэй) амьтад бий болжээ. Хожуу үед хөвөн биетэн, хорхой, хиолит, төрөл бүрийн зөөлөн биетэн, мөр хөлтөн зэрэг ихээхэн нийтлэг олон бүлэг үүсэн хөгжсөн байна. Үүнээс арай сүүл үед Монгол орны тэнгисийг трилобит, археоциат зэрэг амьтад эзэмшиж ирсэн бөгөөд археоциатууд нь шохойлог бодис ялган гаргагч замгийн хамт риф маягийн хадан цохио үүсгэдэг болжээ. Тэр үед хөндий хэвэлтний анхны араг яст төлөөлөгчид, болох радиациат, хясаа бий болжээ.

Түүрү кембрийн тэнгисийн шим махбодын бүлгэмдлийн шинж байдлыг ажиглахад тус орны нутаг дахь тэр үеийн тэнгис нь Алтай-Саяаны ариат муж, Өвөр Байгал, Хятадын нутагт оршиж байсан тэнгисүүдтэй нягт холбоотой нь илэрхий байдаг юм. Тэдгээр тэнгис бүлээн устай, уур амьсгал дулаан буюу халуун байжээ. Түүрү кембрийн сүүл үеэс тэнгисийн талбай багасжээ.

Монголын хойт хэсгийн ихэнх нутаг ордовикийн галавт хуурай байсан бөгөөд өмнө, баруун талаар нь тэнгис, эх газрын горим дахин давтан солигдож байжээ. Харин тус орны баруун өмнөд захад тогтмолжуу тэнгис оршиж байсан бололтой. Тэнд эрт төрмөлийн эриний эхэн үед гүн устай нөхцөлд тунаж тогтсон хурдас чулуулаг байгаа болов уу гэж таамагладаг юм. Монгол Алтайд байсан ордовикийн тэнгисийн хөгжлийг хоёр үе шатад хувааж үздэг. Анхны үед хожуу кембрийн галавас уламжлан үлдсэн тэнгист граптолит, мөр хөлтөн, трилобит зэрэг жинхэнэ ордовикийн галавын нийтлэг амьтад оршиж байжээ. Дараагийн үед хөвд биетэн, хясаа, анхны ганц нэг хөндий хэвэлтэн бий болсон байна.

Хоёр дахь үе шатны эцсээр тэнгис, одоогийн баруун-Урт хот хүртэл тэлж строматопорат болон хөндий хэвэлтэн тархдаг байжээ. Ордовикийн амьтны аймгийн хам бүрдэл, чулуулгийн найрлагаас үзэхэд тэр үеийн амьтад бүлээн усанд нутагшиж байсан байна. Монголын ордовикийн тэнгис нь түүрү ба дунд ордовикийн зааг дээр шотланд-аппалачийн амьтдын цогцолбор бүхий эртний номхон далайн мужтай холбоотой хэвээр байсан бөгөөд хожуу ордовикийн эхээр тэр тэнгис Сибирийн гүехэн тэнгистэй бас холбоотой болж иржээ.

Ордовикийн үеийн далайн түрэлтийн үр дүнд эртний газарзүйн бусад мужийн амьтны аймаг харилцан нэвтрэлцж строматопорат, мөр хөлтөн, дун, хясаа, толгой хөлтөн, өргөст арьстан, хөвд биетэн, трилобитын дотор газар сайгүй тархаж амьтад олширсон байжээ. Монголын тэнгисийн санг өөртөө багтаасан Төв Азийн муж өвөрмөц шинжээ тодорхой хэмжээгээр хадгалахын хамт силурын галавын туршид Европ, Умард Америкийн мужтай тогтмол холбоотой байсан байна. Силурын галавын далайн амьтад, ёроолд нь шохойлог, шохойлог-хэмхдэст хурдас хуримталсан гүехэн тэнгисийн бүлээн усанд нутагладаг байжээ.

Девоны галавын түүрү ба дунд үед тэнгисийн ай савууд адилдуу хэмжээний талбай эзэлж, тэнд силурын галавас уламжлан үлдсэн, хоорондоо амьтны аймгийн хувьд эрс ялгаатай дотоодын ба гадна талын гүехэн устай хэсэг, мөн харьцангуй гүн устай бүс ялгарчээ. Дотоодын гүехэн устай хэсэгт мөр хөлтөн, гадна талынхад нь табулат, харьцангуй гүн устай бүсэд радиоляри голлож байжээ. Гадна талын гүехэн устай хэсгийн хөндий хэвэлтэн, хөвд биетэн, мөр хөлтөн зэрэг амьтад Алтай-Саяаны мужид нийтлэг байснаас гадна Индигир-Колымын эртний амьтны газарзүйн мужид хамаарах амьтны аймгийн зүйл үзэгдэх болжээ. Евразий дахь девоны түүрү үеийн тэнгисээс Умард Америк, Дорнод Австралийн мужийн амьтны аймгийн зүйл олддог юм.

Девоны дунд үед тэнгисийн ёроолоор оршигч амьтдын дотор зонхилж байсан хөндий хэвэлтэн, мөр хөлтөн, хөвд биетнүүд Алтай-Саяаны мужийн зүйлд голчлон хамаарч байв. Девоны хожуу үед тэнгисийн ай савууд эрс хумигдсан учраас тэр үеийн шим үлдэгдэл ховор бөгөөд тус орны зөвхөн баруун хагасаас л олддог ажээ.

Чулуун нүүрсний галавт Монгол орны нутаг Ази тив ба Эртний Тетис хэмээх асар том тэнгисийн сав газрын зааг дээр байрлаж байсан учраас уг сав газрын захын тэнгисүүд тус орны зүүн өмнөд хэсэгт нэвтрэн орж, энэ галавын туршид тэнд дулаан орны амьтад болох фузулинид, хөвд биетэн, шүр оршиж байжээ. Хангай-Хэнтийн болон Монголын өмнөд хэсгийн геосинклиналийн тэнгисүүд хойт сэрүүн бүсийн усан сантай холбоотой байсан бөгөөд амьтны аймгийн гол бүлэг нь мөр хөлтөн, хөвд биетэн байснаас гадна шүрээс ругоз зонхилж байв. Зөөлөн биетнээс гээж хясаа, хэвэл хөлтөн голлож байжээ. Тэнгисийн сараан цэцэг хааяагүй шигүү уржаг чулуулаг үүсгэгч организм болж байв. Чулуун нүүрсний галавын дунд үеийн хэзэнд Монголын өмнөд хэсгийн геосинклиналийн хөгжил дуусаж тэнгис нь татарсан тул сэрүүн бүсийн амьтан эрс цөөрчээ.

Чулуун нүүрсний галавын Монгол газрын ургамлын бүлгэмдлүүд дулаан орны гаднах Ангарын эртний ургамлын мужид хамаарна. Чулуун нүүрсний галавын түүрү үед хайрст ургамал голлож, үет ишлэн болон оймын төрлийн ургамал бага багаар холилдон уржаж байсан бол уг галавын дунд үеийн эхээр дулаанд зохицсон хайрст ургамлууд сөнөж алга болсны улмаас ургамлын аймаг эрс ядуурчээ. Энэ галавын хөвдугаар хагаст оймон навчтай олон тооны урт ургамал, өйм, мөн кордентууд бий болжээ.

Пермийн галавын эхэн үед Монгол орны биогазарзүйн байдал өмнөх чулуун нүүрсний галавныг үндсэндээ төсөөтэй байсан бөгөөд өмнөд хэсгийн нь усан сан Эртний Тетис тэнгисийн системд багтаж байжээ. Тэнд фузулинид, дөрвөн цацрагт шүр, хөвд биетэн оршин амьдарч, замаг-хөвд биетнээс бүтсэн риф хадан цохио бас үүсэж байжээ. Пермийн галавын түүрү үеийн хөвдугаар хагаст Сэрүүн бүсийн тэнгис ба Эртний Тетис тэнгисийн ай савын холбоо өргөсөж, тэнгис хуурай газар руу өрөнхийдөө түрэн орж, уур амьсгал арай сэрүүдэж ирсний улмаас амьтны аймгийн бүрэлдэхүүнд эрс өөрчлөлт оржээ. Фузулинид болон жинхэнэ дулаан орны шүр, хөвд биетэн алга болж ангиллын хувьд олон янзын бүлэгт багтаж мөр хөлтөн, хөвд биетэн түгээмэл байхын хамт дун, хясаа, далайн сараан цэцэг, жижиг фораминифер ихээхэн дэлгэрч, шүрээс ругоз, табулат зонхилж байжээ. Монголын хойт ба төв хэсгийн тэнгисүүд пермийн галавын сүүл хүртэл хойт Сэрүүн бүсийн усан сантай холбоотой байсан учир тэдгээрт мөр хөлтөн, хөвд биетэн, хясаа, дөрвөн цацрагт шүр, далайн сараан цэцэг оршиж байв. Пермийн галавын сүүлчээр тэнгисийн талбай үлэмж багасжээ.

Пермийн галавт Монгол орны хуурай газрын ихэнх хэсэг нь (Ангарын эртний ургамлын мужид хамаарах) кордентын хөвч ойгоор хучигдаж байжээ. Пермийн түүрү үеийн сүүлчээр ургамлын аймгийн нутаг дэвсгэрийн ялгаа тодорч цаашид улам гүнзгийрчээ. Тухайлбал, Монголын хойт хэсгээр байдаггүй урт ойр өмнөд хэсгийн ургамлын аймагт элбэг байжээ. Пермийн сүүлчээр катазын ургамлын зүйл энд үзэгдэж эхэлсэн нь Эртний Тетис тэнгис ургамлын тархалтад саад болохооргүй нарийхан усан сан болж хувирсныг гэрчилнэ.

Триасын галавын эхэнд Монгол орны нутагт тэнгис бараг бүрэн үгүй болж зөвхөн хойт хэсэгт Байгалын өвөр нутаг руу түрж орсон тэнгисийн нарийхан булан Юрийн эхэн үе хүртэл хадгалагдаж үлдсэн бөгөөд тэр нь хойт Сэрүүн бүсийн тэнгисийн амьтны газарзүйн мужид хамаарна. Уг тэнгисийн амьтадас зөвхөн аммонит, хясаа хоёр олдсон юм. Тэр үеийн эх газрын хурдас одоогоор Монгол орны зүүн хэсэгт л тааралдаж байна. Тэндээс олсон шим үлдэгдлийн ихэнх нь ургамлын зүйл бөгөөд шилмүүст мод, шивлээ хамгийн элбэг, харин урт өйм, цикадофит, гингко болон чекановскийн төрлийн ургамал ховор юм. Чекановскийн төрлийн ургамал Монгол орны зөвхөн хойт хэсгээс олдсон байна. Өмнөд хэсгийн ургамлын аймаг Европ-Синийн мужид, бусад хэсгийн нь Сибирийн ургамлын газарзүйн мужид хамаарна. Монголын нутгаас эх газрын усан санд оршин амьдрагчдын үлдэгдэл болох хавч хэлбэрт конхострак болон казахарт, хоёр нутагт лабиринтодон олдсон юм.

Юрийн галавын эхээр уур амьсгал хүйтэрч Монголын бүх нутаг Сибирийн мужид хамаарах болж, тухайн галавын ихэнх хугацаанд уур амьсгал сэрүүдээр, чийглэг байжээ. Гол мөрний намгархаг уужим хөндий эртний нарс, гингко, чекановскийн төрлийн

моддоос бүрдсэн элдэв олон өйм бүхий ой ургаж, хуурай газрын амьтадас зөвхөн жоом, цох, тэмээлэгэнэ, шүлүүн далавчит мэтийн шавьж байсан нь мэдэгдэж байна. Эх газрын нуур усны амьтад илүү олон янз байснаас дурьдвал хясаа, дун, конхострак, усны шавьжууд юм. Юрийн галавын сүүлчээр уур амьсгал нэлээд дулаан хуурайшиж, биогазарзүйн хил умар зүг рүү түргэн шилжсэн тул тэр үеэс эхлэн дунд төрмөлийн эриний эцэс хүртэл Монголын нутаг дэвсгэр Европ-Синийн арай дулаан мужид хамаарагдах болжээ. Хуурай нөхцөлд дассан шилмүүст ой элбэг тархаж, том том нуур бий болжээ. Тэдгээр нуур, ялангуяа дараагийн цэрдийн галавт бүр түгээмэл шинжтэй болсон байна.

Юрийн сүүлч, цэрдийн галавын эхээр газрын гадаргын хотгор гүдгэрийн ялгаа эрс тэс болж өөрчлөгдөхийн хамт олон газар галт уул оргилж байжээ. Бүлээн устай томоохон нуурт дун, хясаа, хавч хэлбэрт конхострак ба эстракод, усны олон шавьж, загас, яст мэлхий, усны том гүрвэл оршиж байснаас гадна ганц эст замаг их хэмжээний шим бодисын нөөцийг бүрдүүлж байжээ.

Цэрдийн түүрү үеийн ой шилмүүст, хейролепид, нарсны төрлийн моддоос бүрдэж байсан бол тэр үеийн эцсээр араукари, гингко, чекановскийн төрлийн ургамал тархжээ. Хуурай газрын хамгийн нийтлэг амьтан нь үлэг гүрвэл (динозавр) байсан юм. Тэдгээрийн дотроос ялангуяа өвсөн тэжээлт, хоёр хөлт, багавтархан биетэй үлэг гүрвэл пситтакозавр олон олдогоос гадна өвсөн тэжээлт игуанодонт, анкилозавр, зауропод, мөн том жижиг араатан үлэг гүрвэл олддог юм. Түүнчлэн том биет нисдэг гүрвэлтэн үлдэгдэл, шувууны өдний хэв, хөхтөн, түүний дотор эртний шавьж тэжээлтэн, бас бяцхан гүрвэл, төрөл бүрийн шавьжийн үлдэгдэл олдсон байна.

Цэрдийн галавын хожуу үед хурдас тунаж хуримтлах үйл явц Монгол орны зөвхөн өмнөд, зүүн өмнөд хэсэгт төвлөрч байжээ. Тэнд тогтож байсан томоохон нуурт гадаад төрх байдлаараа тэнгисийнхтэй төстэй өвөрмөц хясаа, бас том хэмжээний дун оршиж байжээ. Харин дунд төрмөлийн эриний нуурт нийтлэг байсан шавьж алга болжээ. Эх газарт мөн ихээхэн өөрчлөлт болжээ. Буур цэрдийн эхэн үед үүссэн цэцэгт ургамал, шинэ маягийн шилмүүст модны хамт ой бүрдүүлэгч хамгийн түгээмэл ургамал болсон байна. Амьтдын дунд үлэг гүрвэл зонхилсоор байсныг дурьдвал: өвсөн тэжээлт жижиг протоцератопс, төрөл бүрийн гадозавр, хуягт динозавр, аварга биет тарбозавр болон бусад том жижиг араатан гүрвэл, хуурай газрын томоохон амьтан болох зауропод зэрэг юм. Эдгээр үлэг гүрвэлтэн нэлээд нь Монгол оронд зөвхөн эндээс олдсон билээ. Энд бас яст мэлхий, матар, загас, бяцхан гүрвэл, бүүдүүлэг хөхтөн амьтад оршиж байв. Цэрдийн сүүлчээр үлэг гүрвэл бүрмөсөн сөнөжээ.

Дунд төрмөлийн эринд Монгол орны нутагт тархаж байсан цэцэгт устай томоохон усан сангууд палеогений үед татарч алга болжээ. Палеогений эх газрын хурдас Монгол оронд бараг зөвхөн нутгийн өмнөд хэсгээр тархаж бөгөөд үндсэндээ нуур-голын гаралтай хурдас бүрдсэн байдаг юм. Палеогений үеийн сар нуурт амьтан болон ургамлын олдвор голчлон говийн хотгоруудын хөвдөөр хурдас хуримтлалын бүсийн зах орчмоор тохиолдоно. Палеогений галав бол эртний эхэст хөхтөн амьтан хөгжил цэцэглэлтийн үе юм. 40 шахам сая жил үргэлжилсэн тэр хугацаанд манай дэлхий дээр кондилартр, пантодонт, диноцерат зэрэг эртний шавьж амьтдын зарим анги бүлэг үүсэж, өргөн хүрээтэй улиран хувьсаж, ажигдаа мөхөж сөнөсөн байна. Мөн олон янзын битүү ба ац туурайтан, туулай хэлбэртэн, мэрэгчид, бич, жинхэнэ араатан хөхтөн бий болж өргөн тархаж байжээ. Палеогений галавт Монгол орны уур амьсгал чийглэг нөхцөлөөс хуурай болтлоо дахин давтан хэлбэлзэн өөрчлөгдөж байв.

Палеогений түүрү үе (хожуу палеоцен)-д янз бүрийн шавьж идэштэн, бич болон зөвхөн Ази тивийн онцлог амьтан болох анагалид, бүүдүүлэг араатан, анхны туурайтан болох кондилартр, нотоунгулат, пантодонт, диноцерат, эртний мультитуберкулат зэрэг амьтад тархаж байжээ. Шувуудаас эртний хөгчүү хэлбэртэн, галуу хэлбэртэн болон сэлүүр хөлтөн, мөн загас, яст мэлхийн үлдэгдэл олдсон байна. Ургамлын аймгийн шилмүүст амьтадас үзэхэд таксоди, троходендрондес зэрэг моддоос голчлон бүрдсэн судлаагчид, өргөн навчит ой өргөн дэлгэр тархсан нь тэр үед сэрүүдээр уур амьсгалтай байсныг харуулж байна.

Палеогений дунд үеийн (зоценин) хурдас томоохон хотгороор тархсан байдаг. Дунд ба хожуу зоценид анхны хивэгчид (трагулид) бий болж, гахай хэлбэртэн, хос биш туурайтан болох хамгийн эртний адуу хэлбэртэн, бронтозавр элбэг байснаас гадна ялангуяа янз бүрийн тапир хэлбэртэн нэн олон байжээ. Тэр үед эртний шавьж идэштэн, мультитуберкулат, диноцерат, кондилартр сөнөж алга болжээ. Ургамлын аймгийн бүрдэл мөн нэлээд өөрчлөгдөж таксоди-траходендрондес ойн оронд дулаан уур амьсгалд зохицсон хатуу навчит ба навчаа гөвдөг модлог ургамал дэлгэрч, тэдгээрийн дотор мирт, лаврын төрөл, нарийн навчит агч, туулайн бөөрлөг царс зонхилж байжээ.

Палеогений хожуу үеийн эхэн (түүрү олигоцен)-д Азийн хойт хагас нийтдээ хүйтэрлийн улмаас Төв Азийн уур амьсгал хуурайшантай уялдаж амьд иж бүрдэл бас өөрчлөлт орсон байна. Усны хагалбар газраар ил задгай ландшафт бий болохын хамт хатуу навчит ой, өвслөг ургамлын бүлгэмдэл оршдог байснаас гадна хөндий, нуур усны эрэг орчмоор татмын экологийн сэрүүдээр нөхцөлд ургадаг хайлаас, зэрлэг мод, улиас, улиангар бүхий ой бүрэлдэн тогтжээ. Энэ шинэ орчин нөхцөлд хөхтөн амьтадас том биет кирсийн төрөл болох индикотери, хурдан гүйгч жижиг гиракодонт, газар ухагч мэрэгч цилиндродонтид, оготно хэлбэртэн амьдарч байсан бөгөөд шувуудаас хос хуруут үл нисдэг эргилоритид (тогоруу хэлбэртэн) бий болж, яст мэлхийнээс хуурай газрын аварга том тестудинид орших байжээ. Бронтозери, намгийн хирс, гахай хэлбэртэн, жижиг буга-трагулид зэрэг амьтад нутагладаг усны эрэг хавийн ой, намгархаг газар их тархал байв. Тэр үеийн амьтдын үлдэгдэл олигоцены эхэн үеийн хөхтний олдвороороо дэлхийд алдаршсан говийн өмнөд хэсэг дэх Эргэлийн Зоо, Хоёр Заан гэдэг газар элбэг бий.

Палеогений хожуу үе (дунд ба хожуу олигоцен)-д уур амьсгал улам хуурай болжээ. Энэ үед зэвсгүүр аварга хирс-индикотерийн нэрээр индикотерийн амьтны аймаг гэж нэрлэгдсэн бүлэг амьтад үүсэж Ази, Европт өргөн тархсан байна. Индикотерийн амьтны аймагт түүнчлэн хурдан гүйдэг хирс аллацеропс, олон төрлийн мэрэгчид (ялангуяа газар ухагч цилиндродонтид, оготно хэлбэртэн), туулай хэлбэртэн, гахай хэлбэртэн болон хивэгч амьтад багтаж байжээ. Энэ бол халуун уур амьсгалтай эх газрын хуурайтар уудам тал нутагт зохицсон орчин цагийн саваннын бүсийн амьтадтай төстэй юм. Ой мод нь хэсэг бүлгээрээ уржаг алаг цоог шинжтэй байснаас гадна тал газарт үет ургамлын бүлгэмдэл анх бий болж улмаар өргөн тархсан бөгөөд тэдгээрийн дотор миртийн төрлийн модорхог сөөг их байжээ.

Неогений галавт Монгол орны нутагт үет улам өргөгдөж, уул хоорондын гүн хотгорууд үүсжээ. Энэ үед Их нууруудын хотгор, Нууруудын хөндий болон Монгол орны зүүн хойт нам дор хэсэгт олон нуур тогтож байжээ. Неогений эхэн (түүрү миоцен)-д уур амьсгал улам чийглэг болж анхитерийн хөхтний аймгийн амьтад зонхилж байсан бөгөөд түүний гол төлөөлөгчид гэвэл: зааны төрлийн гомфотери, кирсийн бүлэгт хамаарах ацератори ба гобитери, тэр үеийн амьтны аймгийг бүхэлд нь нэрлэсэн адууны төрлийн жижиг биет гураан хуруут анхитери, багавтар биетэй эртний буга хэлбэртэн-лагоммерикс, буга-динокерус, степаноцебус, бүх гөрөөс юм. Тэдгээр амьтад ихэвчлэн ойд, мөн усны эрэг орчмоор нутагшиж зөөлөн шувуусыг ургамаар хооллож байжээ. Түүрү миоцений үеийн ургамлын аймаг нь өрөнхийдөө хожуу олигоценитхтэй төстэй бөгөөд нутгийн хойт хэсэгт өргөн навчит, шилмүүст ой, өмнөд элбэг хатуу навчит болон навчаа гөвдөг ой эзэнхилж байсан ажээ.

Миоцений сүүл үед уур амьсгал хуурайшиж явдал үргэлжилсээр байсан тул Монголын баруун ба зүүн хойт хэсгийн хотгоруудад хэзэрийн ургамлын эвчил бий болж, өмнөд хэсэгт нь саванн маягийн ландшафт голлох болжээ. Тэр үед Умард Америкаас Ази тив рүү адууны төрөл гилпарнон орж ирж эртний гилпарноны амьтны аймаг бүрэлдсэн байна. Түүний бүрэлдэхүүнд гурав хуруут адууны төрөл-гилпарноноос гадна хирс-хилотери, анаш-палеотрагус, самотери болон анхны гөрөөс багтахын хамт жинхэнэ оготно, хулгана анх үүсжээ.


Плиоцений эхэнд уур амьсгал сэрүүн болж, хотос нам газарт алаг өвст хээр зонхилон, уулархаг ба өндөрлөг газраар навчит ой (царс, агч, даладуу, улиангар, хус, бургас) болон шилмүүст мод уржаж байв. Хээр нутагт гилпарнон, эээр, хэзэрийн хирс, бүх гөрөөс амьдарч байжээ. Ойгүй ил задгай нутагт шувуудаас том биет хос хуруут тэмээн хяруул, нисдэггүй амфицеларгус, янз бүрийн гургуул өргөн тархаж, цэнгэг устай нууруудад хун, галуу, нугас, хар галуу зэрэг одоогийнхтой төстэй усны шувууд нутагшиж, олон тооны дун, хясаа, цэнгэг усны загас амьдарч байв. Плиоцений хожуу үеийн сэр нуруут амьтдын үлдэгдэл Монгол орны хойт хэсгээс гол төлөв олддог юм. Мэрэгчдийн дотор тэр үед арга шүдтэ одоогийнхтой төстэй болох орчмоос сэрүүдээр бүсийн нарийн биет сармагчид үлдэгдэл олддаг.

Неогений сүүлчээр орчин үеийн амьтны аймаг үүсэж, цаашид хөгжих нөхцөл бүрэлдэжээ.

ШИМ ҮЛДЭГДЭЛ ОЛДСОН ГОЛ ГАЗАР

47 КЕМБРИЙН ӨМНӨХ ҮЕ (ВЕНД) БА КЕМБРИЙН ГАЛАВ

Масштаб 1:6 000 000



- Хуурай газар
- Тэнгис байдла төстэй байсан газар
- Тэнгис үе үе төстөж байсан газар
- Голт уулын чулуулаг тархсан газар
- Чулуулсан шим биетэй тархсан газар

ШИМ ҮЛДЭГДЭЛ ОЛДСОН ГОЛ ГАЗАР


- | | |
|-----------------|--------------|
| 1 Хан Хойд | 6 Зүүн Ард |
| 2 Саяр | 7 Төвшөр |
| 3 Ак-Баши | 8 Талман |
| 4 Заахан, Хүмэй | 9 Бүрэн Хол |
| 5 Салааны гол | 10 Эгийн гол |
| II Харзан гол | |
| • Олдсон газар | |

УРГАМАЛ, АМЬТНЫ ГОЛЛОХ БҮЛЭГ

- Строматолит
- Онколит
- Аристерх
- Усны урсгал (саяа)
- Архейцит
- Төвөрхэй бус шохойноос биетүүд
- Хийлт, төвөрхэй бус фосфорлог биетүүд
- Дун хясаа
- Трилобит

48 ОРДОВИК, СИЛУР, ДЕВОНЫ ГАЛАВ

Масштаб 1:6 000 000



- Хуурай газар
- Тэнгис байдла төстэй байсан газар
- Тэнгис үе үе төстөж байсан газар
- Голт уулын чулуулаг тархсан газар
- Чулуулсан шим биетэй тархсан газар

ШИМ ҮЛДЭГДЭЛ ОЛДСОН ГОЛ ГАЗАР

- | | | |
|----------------------|------------------------------|--------------------------|
| 1 Нийлэл Дяар Чанусу | 6 Саяр | II Нийслэл уул |
| 2 Цэвэр нуур | 7 Шаргал уул | 12 Цэвэр Фэл (Балханзор) |
| 3 Үүрэг нуур | 8 Бодхон, Хөвсгөлийн Довоо | 13 Мандал овоо |
| 4 Алт нуур | 9 Уян гол | 14 Харзан гол |
| 5 Хуань булга | 10 Тонхил, Цэцэг, Хойд Цэцэр | 15 Баруун-Урт |
| • Олдсон газар | | |


УРГАМАЛ, АМЬТНЫ ГОЛЛОХ БҮЛЭГ

- ОРДОВИКИЙН СИЛУРЫН ДЕВОНЫ
- Усны урсгал (саяа)
 - Хөндий хэвцэлэн
 - Дун хясаа
 - Трилобит
 - Хөд биетэн
 - Мор хөдлөн
 - Орост ирсэн
 - Грэйолит
 - Зөгс

ШИМ ҮЛДЭГДЭЛ ОЛДСОН ГОЛ ГАЗАР

49 ЧУЛУУН НҮҮРСНИЙ БА ПЕРМИЙН ГАЛАВ

Масштаб 1:6 000 000



- Хуурай газар
- Тэнгис баялаг тогтсон байсан газар
- Тэнгис үе үе тогтож байсан газар
- Галт уулын чулуулаг төрхөөн газар
- Чулуулсан шам биетэн төрхөөн газар


- УРГАМАЛ, АМЬТНЫ ГОЛЛОХ БҮЛЭГ
- ЧУЛУУН НҮҮРСНИЙ ПЕРМИЙН
- Эх газрын урсгал
 - Форминифер
 - Хөндий хээлтэн
 - Трилобит
 - Хөвд биетэн
 - Мор хөлтөн
 - Долойн сөрөг цэцэг

ШИМ ҮЛДЭГДЭЛ ОЛДСОН ГОЛ ГАЗАР

- | | | |
|-----------------|------------------|------------------|
| 1 Анхн нуур | 6 Мөрөн гол | 11 Онгийн гол |
| 2 Ормолзгон уул | 7 Өндөрхан | 12 Ноён сум |
| 3 Биндэр сум | 8 Урд Ташрын гол | 13 Дан нуруу |
| 4 Цагаан Тогтоо | 9 Түйн гол | 14 Тогон толгой |
| 5 Цэнхэр гол | 10 Абацгай сум | 15 Цохиотын хийд |
- Олдсон газар

50 ТРИАС БА ЮРИЙН ГАЛАВ

Масштаб 1:2 000 000



- Зөөдлийн үйл явц зонхилж байсан газар
- Тэнгисийн курбас хуримтлагдсан газар
- Нуур-голын курбас хуримтлагдсан газар
- Галт уулын гэрэлтэй курбас хуримтлагдсан газар

УРГАМАЛ, АМЬТНЫ ГОЛЛОХ БҮЛЭГ


- Эх газрын урсгал
- Цэнгээ усны дүн хясаа
- Тэнгисийн дүн хясаа
- Остриной
- Шаан

ШИМ ҮЛДЭГДЭЛ ОЛДСОН ГОЛ ГАЗАР

- 1 Неролаит
- 2 Бахар
- 3 Ноён
- 4 Хөөтийн хөлтөр
- 5 Түшээ
- Олдсон газар

51 ЦЭРДИЙН ГАЛАВ

Масштаб 1:6 000 000




- ШИМ ҮЛДЭГДЭЛ ОЛДСОН ГОЛ ГАЗАР
- | | |
|-----------------------|--------------------------|
| ДООД ЦЭРДИЙН | ДЭЭД ЦЭРДИЙН |
| 1 Гурван Эрэний нуруу | 5 Бүгийн шав, Гурлын цаг |
| 2 Боон Цагаан нуур | 6 Хүрэмийн цаг |
| 3 Хоовэр, Лидай хийд | 7 Намзал, Алтан уул |
| 4 Хурин Бух | 8 Ундсын сайр |
| | 9 Тоого, Баян Зог |
| | 10 Бовшин шав, Лилтэй |
| | 11 Хэрхител |
- Олдсон газар

- УРГАМАЛ, АМЬТНЫ ГОЛЛОХ БҮЛЭГ
- Эх газрын урсгал
 - Цэнгээ усны дүн хясаа
 - Остриной
 - Шаан
 - Зогс
 - Ялт малчи
 - Зсуриной
 - Сенокосар
 - Илени
 - Протосарлатос
 - Зсуриной
 - Периозар
 - Шууу
 - Дод шалны хөлтөн

- Нуур-голын курбас хуримтлагдсан газар
- Галт уулын гэрэлтэй курбас хуримтлагдсан газар
- Зөөдлийн үйл явц зонхилж байсан газар

ШИМ ҮЛДЭГДЭЛ ОЛДСОН ГОЛ ГАЗАР

52 ПАЛЕОГЕНИЙ ГАЛАВ
Масштаб 1:6 000 000




- Уулархаг нутаг
- Цаг төлөгдөм нутаг
- Эхэлдвэр үүссэн жил газар
- Гол-нуурын хурдас хуримтлагсан газар
- Хүрмэн чулуу тархсан газар

ШИМ ҮЛДЭГДЭЛ ОЛДСОН ГОЛ ГАЗАР

ПАЛЕОЦЕН	О	Л	И	Г	О	Ц	Е	Н
1 Хайчин I	Түрүү үе	10 Шинэ Ус	11 Улаан гол	14 Булбаастайн хуяг	24			
2 Цагаан хонь	7 Эрдэйн гол	12 Холын оум	15 Зан Хайрхан уул	25 Татал гол				
3 Наран булаг	8 Гуа тээв	13 Билэр II	16 Могойн тээв	26 Шал гол				
4 Хашгал	9 Хоёр Зал	14 Билэр III	17 Улаан шав хуяг	27 Улаан хүрээ				
	10 Кокуу үе	15 Бундуйн гол	18 Ташан гол	28 Цахар				
5 Хайчин II-IV	11 Наранбулаг сум	16 Хайр уул	19 Цагаан оюу	29 Шунт				
6 Хойболин, Манхан тээв	12 Өвчин Бор Үзүүр уул (Өвч)	17 Ойсон газар						

- УРГАМАЛ, АМЬТНЫ ГОЛЛОХ БҮЛЭГ
- Усны ургамал (самаг)
 - Эх газрын ургамал
 - Эх газрын дун хясаа
 - Острикод
 - Засаг
 - Яст малчид
 - Шүүгүү
 - Палеогений хөхтөн
 - Эоцений хөхтөн
 - Олигоценей түрүү үеийн хөхтөн
 - Аврагч хярсний аймаг

53 НЕОГЕНИЙ ГАЛАВ
Масштаб 1:6 000 000



- Уулархаг нутаг
- Цаг төлөгдөм нутаг
- Эхэлдвэр үүссэн жил газар
- Гол-нуурын хурдас хуримтлагсан газар
- Хүрмэн чулуу тархсан газар

ШИМ ҮЛДЭГДЭЛ ОЛДСОН ГОЛ ГАЗАР

МИОЦЕН	П	Л	И	О	Ц	Е	Н
1 Өвч	6 Хоёр гол	9 Чоно харайх гол	12 Плавин толгой				
2 Шинэ Ус	7 Били нуур	10 Идэр	13 Туйн гол				
3 Билэр I	8 Хярс нуур I-II	11 Орхон	14 Холд				
4 Луу	9 Пикар	12 Шошмар	15 Хүн хүрээ				
5 Улаан толгой	10 Ташал	13 Алтан Тээв	16 Сухайн				
	11 Зөвсөн Хайрхан	14 Шарын гол	17 Дорнод				

- УРГАМАЛ, АМЬТНЫ ГОЛЛОХ БҮЛЭГ
- | | |
|---------------------|----------------------|
| МНОЦЕН | ПНОЦЕН |
| Эх газрын ургамал | Усны ургамал (самаг) |
| Эх газрын дун хясаа | Острикод |
| Засаг | Яст малчид |
| Шүүгүү | Эртний эвчин аймаг |
| Эртний эвчин аймаг | Эртний оюуны аймаг |
| Сэрмэлчин | |

УУР АМЬСГАЛ

Монгол орны уур амьсгал тус орны газарзүйн байршлын онцлог, газрын гадаргын тогтоц, далайн төвшнөөс дээших өндөршлөөс шалтгаална. Өндөр уул, тэгш тал алаглан гадаргын байдал янз бүр байдаг явдал тухайн нутгийн уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын байдалд ихээхэн нөлөө үзүүлдэг юм. Уур амьсгалын өвөрмөц нөхцөлөөс хүний аж ахуйн үйл ажиллагааны онцлог нэлээд шалтгаална.

Сүүлийн жилүүдэд улс ардын аж ахуйн практик хэрэгцээг хангах зорилгоор «БНМАУ-ын уур амьсгалын лавлах» (1971), «БНМАУ-ын уур амьсгал, гадаргын усны нөөцийн атлас» (1984), «БНМАУ-ын нарны эрчим хүчний кадастр» (1985) зэрэг бүтээлд цаг уурын ажиглалтын мэдээ сэлтийг эмхтгэн дүгнэсэн байна. Түүнчлэн тус орны нутаг дэвсгэрийг ерөнхий уур амьсгал, агро-уур амьсгал, зоо-уур амьсгалын хувьд мужлах ажлыг хийсний зэрэгцээ цаг агаарын үзэгдэл, үйл явцын онцлог, түүний дотор шороон шуурга, цасан шуурга, хүчтэй салхи, их хур тунадас, цочир хүйтрэлт, ган зэрэг улс ардын аж ахуйд аюултай, онц аюултай үзэгдлийн зүй тогтлыг судалжээ.

Эдгээр судалгааны үр дүн болон цаг уурын горимын ажиглалтын мэдээ баримт атласын уур амьсгалын бүлгийн зургуудыг зохиох үндэс суурь нь болсон юм. Энэ бүлгийн зургууд уур амьсгалыг бүх талаар нь тодорхойлон харуулж, цаг агаарын зарим аюултай үзэгдлийг тусгахын хамт нар, салхины эрчим хүч зэрэг байгалийн нөөцийн тухай мэдээг мөн агуулна.

Уур амьсгалын зураглалд үндсэндээ 15—40 жилийн хугацааны цаг уурын ажиглалтын дүн мэдээг нэгтгэн ашигласан юм. Ажиглалтын мэдээ ховортой уулархаг нутгийн хувьд бол уур амьсгалын нөхцөл гадаргын өндөрөөс хамааран өөрчлөгдөх физик зүй тогтлыг үндэслэн тооцооны аргаар гаргаж авсан үзүүлэлтийг ашиглав. Ингэж бодож гаргасан тоон үзүүлэлтээ байгалийн хил зааг, голын урсац, ууршилт, хөрс, ургамалшил зэрэг физик газарзүйн нөхцөлтэй уялдуулан тодотгов. Цаг уурын мэдээ баримтыг боловсруулахдаа уур амьсгалын тодорхойлолтыг магадлал сайнтай болгоход онцолж анхаарсны дүнд жилийн хур тунадасны хэмжээ, дулаан үе дэх ургамлын чийг хангамж гэх мэт үзүүлэлтийг тооцоолох номограмм зохиох боломжтой болсон байна.

Нарны цацрагийн үйл явц бол газрын гадарга орчмын агаарын температурын горимыг тодорхойлдог учраас уур амьсгал бүрэлдүүлэх гол зүйл юм. Газрын гадаргад ирэх нарны цацрагийн хэмжээ тэнгэрийн хаяанаас дээших нарны өндөр, түүний гийгүүлэх хугацаа болон үүлшилтээс шалтгаална. Тус орны хэмжээнд нар гийгүүлэх хугацаа өргөргөөс болж төдий л их өөрчлөгдөхгүй, харин үүлшилт хойноос урагшлах тутам мэдэгдэхүйц багасдаг учраас нар гийгүүлэх хугацаа урд зүг рүү нэмэгддэг байна. Үүнтэй уялдаж нарны нийлмэл цацраг өмнө зүгийн нутгаар харьцангуй их байхаас гадна зуны улиралд мөн их байна. Монгол орны нөхцөлд газрын гадаргад ирж байгаа нарны шулуун цацрагийн хэмжээ, сарнимал цацрагийнхаас хавьгүй илүү бөгөөд ийнхүү нарны шулуун цацраг их тусч, цэлмэг өдөр олон байдаг нь нарны эрчим хүчийг улс ардын аж ахуйд ашиглах сайхан бололцоог бий болгодог ажээ.

Агаарын урсгал бол уур амьсгал бүрэлдүүлэх үндсэн хүчин зүйлийн нэг бөгөөд түүнийг агаарын даралтын зургуудаар харуулав. Салхины тархалт ч үүнтэй нягт холбоотой юм. Агаарын даралтын талбарыг тус орны дундаж өндөрт ойролцоо 1500 м өндөрөө (далайн төвшнөөс дээш) тооцоолов. Өвөл тус орны баруун хойт хэсэгт Увс нуурын хотгор дээр төв нь байдаг азийн эсрэг циклон тод илэрнэ. Эсрэг циклоны төв орчимд салхины хүч сул буюу заримдаа огт салхигүй байдаг. Агаарын хөдөлгөөн сул, үүлшилт багатай учраас агаар хүчтэй хөрч улмаар хөрс гүн хөлдөхөд хүрнэ. Нимгэхэн тогтсон цасан бүрхэвч хөрсийг дулаанаа алдахаас төдийлөн хамгаалж чаддаггүй байна. Эсрэг циклоны төвөөс зүүн тийшлэх тутам даралтын зөрөө (градиент) нэмэгдэж салхины хурд ч бас ихсэнэ.

Зуны цагт тус орон Таймыраас өмнө тийш үргэлжилдэг өндрийн даралтын хотос муж ба түүнтэй холбоо бүхий зүүн тийших өндрийн даралтын гүвгэр муж хоёрын уулзварт оршдог байна. Энэхүү өндрийн гүвгэрийн хэвтээ тэнхлэгийн баруун талаар дулаан агаар өмнөөс хойшоо урсаж байхад өндрийн хотсын хэвтээ тэнхлэгийн баруун талаар хүйтэн агаар хойноос урагшаа нэвтрэн ирдэг ажээ. Энэ хоёр урсгал хоорондоо ойртох үед агаар долгиж, тунадас унах нэн тохиромжтой нөхцөл бүрдэнэ. Жилийн энэ улиралд гадарга орчмын агаарын даралтын талбар бүдэг болж, даралтын зөрөө багасан салхины хүч буурна.

Монгол орон дунд өргөрөгт оршдог учраас жилийн аль ч улиралд баруун ба хойт зүгийн салхи зонхилно. Хотгор хонхор газар салхины хурд гол төлөв 1 м/сек-ээс хэтэрдэггүй бол задгай хээр талд 2-5 м/сек хурдтай салхи зонхилно. 15 м/сек буюу түүнээс хүчтэй салхи харьцангуй цөөн тохиолдох бөгөөд давтагдал нь хойноос урагшлах тутам ихсэнэ.

Нутаг орны уур амьсгалыг аль болох дэлгэрэнгүй тодорхойлохын тулд агаарын температур тухайн нутгийн өндөршлөөс хэрхэн хамаардгийг графикаар харуулсан юм. Зун бараг хаана ч тэр, өндрийн төвшин 100 м өгсөх тутам агаарын температур 0,5°—0,6°-аар буурна. Харин өвөл битүү хонхор, хотгор, салхигүй хөндийд хүйтэн агаар тунарч тогтдогтоос шалтгаалан агаарын температурын хуваарилалт тонгоруу болж 100 м өгсөх тутам температур 0,8°-аар дээшилдэг байна.

Жилийн дундаж температурын 0°-ын ижил утгын шугам өргөргийн дагуу Монголын нутгийн бараг төв дундуур өнгөрч олон жилийн цэвдэг чулуулаг алаг доог тархсан нутгийн өмнөд хилтэй давхцдаг ажээ. Энэхүү шугамаас хойших нутагт өвөл урт, хахир хүйтэн байх ба газрын хөрс 3-4 м хүртэл гүн хөлдөж, 1 м гүн хүртэлх хөрсний температур өвлийн түрш —20°С-аас доош байна. Харин түүнээс урагших нутагт хөрсний улирлын хөлдөлтийн гүн 2,5 м хүрч, —20°С-аас бага температур зөвхөн нэгдүгээр сард 10-20 см хүртэл гүнд ажиглагдана.

Өвөл хүйтэн агаар тунарч тогтдог хотос хонхор газар хамгийн хүйтэн болж нэгдүгээр сарын хоногийн дундаж температур —35°С хүрнэ. Увс нуурын хотгорт үнэмлэхүй хамгийн бага температур (—50,0°С) тэмдэглэгдсэн юм. Зун Монгол орны өмнөд хэсэгт хамгийн дулаан болж долдугаар сарын хоногийн дундаж температур +25°С хүрдэг бөгөөд үнэмлэхүй хамгийн их температур (+40,8°С) Сайншандад

ажиглагдсан байна. Жилийн туршид температурын хэлбэлзэл 50°—60° хүрдэг нь Монгол орны уур амьсгал эх газрын эрс тэс шинжтэйг гэрчилнэ.

Хүйтэн, халуун үеийн үргэлжлэх хугацааг мэдэх явдал аж ахуйн үйл ажиллагаанд онцгой чухал юм. Цаг агаар хүйтэн байх үе хотгор газраар хамгийн удаан үргэлжилдэг бол халуун байх хугацаа хойноос урагшлах тутам уртасдаг байна.

Уур амьсгалын тохиромжгүй нөхцөлийн нэг нь ургамал ургах хугацаа нийтдээ богино, цочир хүйтрэлт намар эрт эхэлж хавар орой болтол тохиолддог явдал юм. Хүйтрэлтгүй хугацаа газар нутгийн онцлогоос их шалтгаална. Уулархаг нутагт цочир хүйтрэлт эрт эхэлж хожуу дуусахаас гадна заримдаа зун, 7 дугаар сард ч цочир хүйтрэх явдал үзэгдэнэ. Монгол орны аль ч нутагт хоногийн агаарын дундаж температур +10°С ба түүнээс дээш байх хугацаа хүйтрэлтгүй хугацаанаас ямагт урт байдаг бөгөөд энэ нь цочир хүйтрэлт таримал ургамлын идэвхтэй ургалтын хугацааг богиносгодог гэсэн хэрэг юм.

Тус орны чийгшлийн хэмжээг үнэлэх, мөн гол мөрөн, нуурын усны балансыг тодорхойлоход зориулан хур тунадасны болон 13 цагийн агаарын харьцангуй чийгийн зургуудыг зохиосон юм. Тунадасны хуваарилалт газар нутгийн өндөр, ялангуяа чийг авч яваа агаарын урсгалын замд тохиолддог уулс яаж байрласнаас ихээхэн шалтгаалах учраас хур тунадасны хэмжээ тухайн нутгийн өндөрөөс хэрхэн хамаардгийг графикаар үзүүлэв. Монгол Алтайн уулст зөвхөн 3000 м-ээс дээш өндөрт жилдээ 250-300 мм тунадас унадаг бол ийм хэмжээний хур тунадас Хангайн нуруунд 2000 м, Хөвсгөлийн уулст 1500 м, Хэнтийн уулст 1000 м-ээс дээш төвшинд тус тус унадаг байна. Иймд манай орны хамгийн чийглэг нутаг бол Хэнтий, Хөвсгөл орчмын уулс юм. Монгол орны бүх нутагт зуны хур тунадас давамгайлж жилийн нийт тунадасны 60-70%-ийг бүрдүүлнэ.

Жилийн хүйтэн улирлын бүх хур тунадас цас байдалтай орж 10 дугаар сараас 4 дүгээр сарын эх хүртэл уулс цасан бүрхүүлтэй байна. Ууланд цас хамгийн зузаан байдагас гадна хамгийн удаан тогтоно. Харин говь, хээрийн бүсэд тогтвортой цасан бүрхүүл бараг үүсдэггүй.

Харьцангуй чийгийн жилийн хуваарилалтад өвөл, зуны хоёр их, хавар, намрын хоёр бага хэмжээ ялгарна. Өвлийн их хэмжээ агаар хүйтэн байдагтай, зуны их хур тунадас их ордогтой холбоотой. Харьцангуй чийгийн намрын бага хэмжээ, агаарын температур өндөр, хөрсөнд чийг бага байдаг хаврынхыг бодвол төдийлөн тод илэрдэггүй байна. Хавар агаар илүү хуурайшиж 30% ба түүнээс бага харьцангуй чийгтэй өдрүүд тохиолдох бөгөөд ялангуяа өмнө зүгийн нутагт байн байн ажиглагдана.

Зуны эхэн үед хөрсний чийгийн нөөц хамгийн бага болж ихэнх нутагт чийг дутмаг байдаг явдал хөдөө аж ахуйд бэрхшээл учруулдаг уур амьсгалын тохиромжгүй нөхцөлийн нэг мөн. Цаг агаарын хувьд тааламжтай жилд ч гэсэн тус оронд чийг хангамж, шаардагдах хэвийн хэмжээний зөвхөн 60-70%-тай тэнцүү байдаг нь газар тариаланд хүрэлцээ багатай юм. Цаг агаарын нөхцөлөөр тааламж муутай жилд бол ургамлын чийг хангамж 30-40% хүртэл буурна. Гангийн давтагдалыг хуурайшлын зэргээр нь тооцоолох аргаар тодорхойлсон болно.

Улс ардын аж ахуйн салбарууд, түүний дотроос хөдөө аж ахуйд зохисгүй нөлөө үзүүлж болох уур амьсгалын зарим үзэгдлийг хүчтэй салхи, цасан шуурга, шороон шуурганы давтагдлын хэд хэдэн зургаар харуулав. Хүчтэй салхи хавар, намар олонтаа ажиглагдах бөгөөд тус орны бүх нутгийн бараг тэн хагаст нь хүчтэй салхи 1-ээс 6 цаг үргэлжилнэ. Ялангуяа 20-30 м/сек хурдтай салхи онцгой аюултай. Цасан шуурга бүх нутгийн бараг гуравны нэгд нь 1-ээс 8 цаг үргэлжилнэ. Цасан шуурга их болдог нутагт 12 цагаас урт хугацаагаар шуурах явдал ч бий. Тачир сийрэг ургамалтай говь нутагт, ялангуяа элсэрхэг хөрсөтэй газар шороон шуурга ихээхэн нийтлэг бөгөөд тэгэхдээ шороон шуурга хавар хамгийн олон байна.

Барилга байгууламжийн зураг төсөл хийхэд ашиглаж болох салхины тооцоот их хурд, галлагааны үеийн үргэлжлэх хугацааны зургийг энэ бүлэгт оруулсан юм. Таван жилд нэг удаа тохиолдож болох салхины хамгийн их хурд болон салхины хурдын түрэлт тус улсын хэмжээнд хойноос урагшлах тутам ихэсхийн хамт энэ чиглэлд харин галлагааны үеийн үргэлжлэх хугацаа багасна.






Уур амьсгалын мужлалт үйлдэхдээ хоногийн агаарын дундаж температур +10°С буюу түүнээс дээш байх үеийн хөрсний гадаргын температурын нийлбэрийг үндсэн үзүүлэлтийн нэг болгож авсан бөгөөд энэ нь мөн хугацааны нарны нийлмэл цацрагийн хэмжээтэй бүрэн нийцэж байгаа юм. Ийнхүү дулаан хангамжийн нь нөхцөлөөр тус орныг 5 бүсэд хуваав. Дутагдал чийгийн хэмжээг хур тунадасны нийлбэрт харьцуулсан утгаар илэрхийлэгдэх хуурайшлын үзүүлэлтээр нутгийн чийг хангамжийг тодорхойлсон болно. Энэ үзүүлэлт бэлчээрийн болон таримал ургамлын ургацтай сайн авцалдаж байгаа бөгөөд үг үзүүлэлтийг баримтлан тус орныг чийг хангамжийн хувьд 5 бүсэд хуваалаа. Энэ хоёр зургийг давхцуулан тавьж уур амьсгалын бүсүүдийг тогтоосон юм.

Уур амьсгалын мужийг ялгахдаа өвлийн температурын нөхцөл буюу жилийн хасах, нэмэх температурын нийлбэрийн ялгаарыг үндэс болгожээ. Энэ нь хэр зэрэг хахир хатуу өвөлтэйг харуулах бөгөөд өвлийн хахир шинж нь тухайн нутгийн хотгор гүдгэрийн нөхцөл, газрын гадаргын цацрагийн баланстай нэлээд нягт холбоотой байна. Өвлийн хахир хатуу байдлаар нь 4 хэвшинж болгон ялав. Энд ялгасан уур амьсгалын муж тус бүр жилийн дөрвөн улирлаар болон бөмбөрцгийн хойт хагасын ерөнхий чийгшлийн үе үеийн өөрчлөлтийг даган зүй ёсоор хувааж байдаг цаг агаарын өвөрмөц хам шинжийг хадгална.

Монгол орны уур амьсгал манай дэлхийн түүхийн туршид ихээхэн өөрчлөгдөж иржээ. Сүүлийн жилүүдэд цэнгэг нуурын ёроолын хурдас болон түүнтэй зэрэг үүссэн салхин гаралт хурдас чулуулгийн онцлог, тэдгээр хурдас булагдсан амьтан ургамлын үндэгдлийн шинж байдал, археологийн олдвор болон цацраг идэвхт нүүрстөрөгчийн аргаар насыг нь тогтоосон дарагдмал хөрсний тухай шинэ мэдээ баримт бий боллоо. Эдгээр мэдээ сэлтээс үзэхэд голоцны үе буюу сүүлийн 12 мянган жилд уур амьсгалын нөхцөл геологийн цаг хугацаагаар жишихэд нэлээд түргэн түргэн солигдож ирснийг мэдэж болно.



54 НАРНЫ НИЙЛБЭР ЦАЦРАГ. ЖИЛЭЭР

Масштаб 1:6 000 000





55 НАР ГИЙГҮҮЛЭХ ХУГАЦАА. ЖИЛЭЭР

Масштаб 1:12 000 000






56 АГААРЫН ДАРАЛТ, САЛХИ. ЖИЛЭЭР

Масштаб 1:12 000 000





57 АГААРЫН ДАРАЛТ, САЛХИ. 1 ДҮГЭЭР САР

Масштаб 1:12 000 000








58 АГААРЫН ДАРАЛТ, САЛХИ. 7 ДУГААР САР

Масштаб 1:12 000 000






59 АГААРЫН ТЕМПЕРАТУР

Масштаб 1:6 000 000




60 ИХ ХҮЙТЭН ӨДРИЙН ТОО

Масштаб 1:12 000 000




61 ИХ ХАЛУУН ӨДРИЙН ТОО

Масштаб 1:12 000 000



62 ХҮЙТЭЛТГҮЙ ҮЕИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА

Масштаб 1:12 000 000




ЦОЦИР ХҮЙТЭЛТ ДУУСАХ БА ЭХЛЭХ ХУГАЦАА

хөрсний дундаж температур	хөрсний дундаж температур	хөрсний дундаж температур	хөрсний дундаж температур
дундаж	хамгийн халуун	дундаж	хамгийн эрэг
30.VI	10.VIII	15.VIII	30.VIII
15.VI	6.VII	20.VIII	3.VIII
6.VI	14.VI	1.IX	10.VIII
27.V	5.VI	4.IX	15.VIII
23.V	2.VI	18.IX	9.IX
15.V	22.V	26.IX	8.IX
10.V	20.V	29.IX	17.IX




63 АГААРЫН ТЕМПЕРАТУРЫН ХОНОГИЙН ДУНДАЖ +10° БА ТҮҮНЭЭС ДЭЭШ БАЙХ ӨДРИЙН ТОО

Масштаб 1:12 000 000







АГААРЫН ТЕМПЕРАТУРЫН ХОНОГИЙН ДУНДАЖ +10°-ЫН ЗААГИЙГ ДАИРЧ ӨНГӨРӨХ ХУГАЦАА

хөрсний дундаж температур	хөрсний дундаж температур	хөрсний дундаж температур	хөрсний дундаж температур
дундаж	хамгийн халуун	дундаж	хамгийн эрэг
11.VI	20.VII	13.VIII	7.VIII
5.VI	12.VI	25.VIII	26.VIII
29.V	8.VI	1.IX	26.VIII
13.V	24.V	16.IX	10.IX
8.V	14.V	23.IX	15.IX
1.V	6.V	30.IX	22.IX




64 ХҮР ТУНАДАС. ЖИЛЭЭР

Масштаб 1:6 000 000




65 ХҮР ТУНАДАС. ХҮЙТЭН УЛИРАЛ

Масштаб 1:12 000 000




66 ХҮР ТУНАДАС. ДУЛААН УЛИРАЛ

Масштаб 1:12 000 000



67 ТОГТВОРТОЙ ЦАСАН БҮРХҮҮЛ ҮҮСЭХ ХУГАЦАА

Масштаб 1:12 000 000




ТОГТВОРТОЙ ЦАСАН БҮРХҮҮЛ ҮҮСЭХ ХУГАЦАА

Дундаж	Хамгийн эрт	Хамгийн хожуу
1.Х-ээс эрт	6.Х	25.Х
1.Х-10.Х	10.Х	2.1
10.Х-20.Х	15.Х	5.1
20.Х-1.Х	20.Х	10.1
1.Х-10.Х	25.Х	15.1
10.Х-ээс хожуу	3.Х	21.1




68 ЦАСАН БҮРХҮҮЛ ХАНЗАРЧ ЭХЛЭХ ХУГАЦАА

Масштаб 1:12 000 000




ЦАСАН БҮРХҮҮЛ ХАНЗАРЧ ЭХЛЭХ ХУГАЦАА

Дундаж	Хамгийн эрт	Хамгийн хожуу
10.И-ээс эрт	17.1	5.И
10.И-1.И	23.1	10.И
1.И-20.И	1.И	25.И
20.И-10.И	17.И	21.И
10.И-1.И	1.И	10.И
1.И-ээс хожуу	20.И	20.И




АГААРЫН ХАРЬЦАНГУЙ ЧИЙГИЙН ДУНДАЖ,13 ЦАГТ


69 1 ДҮГЭЭР САР
Масштаб 1:12 000 000




70 4 ДҮГЭЭР САР
Масштаб 1:12 000 000




71 7 ДУГААР САР
Масштаб 1:12 000 000




72 10 ДУГААР САР
Масштаб 1:12 000 000




73 ГАНГИЙН ДАВТАГДАЛ (1940-1982 онд)
Масштаб 1:12 000 000




74 ХҮЧТЭЙ САЛХИ
Масштаб 1:12 000 000



75 ЦАСАН ШУУРГА
Масштаб 1:12 000 000




76 ШОРООН ШУУРГА
Масштаб 1:12 000 000




77 ЗУРАГ ТӨСӨЛ, БАРИЛГЫН АЖИЛД ЗОРИУЛСАН САЛХИНЫ ХУРДЫН ТООЦООНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Масштаб 1:12 000 000




78 ЗУРАГ ТӨСӨЛ, БАРИЛГЫН АЖИЛД ЗОРИУЛСАН АГААРЫН БАГА ТЕМПЕРАТУРЫН ТООЦООНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Масштаб 1:12 000 000




79 ХОНЬ, ЯМААНЫ ӨВЛИЙН БЭЛЧЭЭРЛЭЛТЭД ТААЛАМЖГҮЙ ЦАГ АГААРЫН НӨХЦӨЛ

Масштаб 1:12 000 000




80 ХОНЬ, ЯМААНЫ ЗУНЫ БЭЛЧЭЭРЛЭЛТЭД ТААЛАМЖГҮЙ ЦАГ АГААРЫН НӨХЦӨЛ

Масштаб 1:12 000 000



81 УУР АМЬСГАЛЫН МУЖЛАЛТ



Масштаб 1:6 000 000



МУЖУУДЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Бүс	Муж	Уур амьсгалын нөхцөл		Өвлийн шилж
		Чийг хангамж $\Sigma d/P$	Дундаж хэмжээ $\Sigma t > 10^\circ$	
I Чөлөөт сэрүүн зун	1, 2	< 1,0	< 1500	-1000...-500
II Чөлөөтэй, сэрүүтэр зун	1	1,1-2,5	1500-2000	< -1000
	2, 3			-1000...-500
III Хурайдуу сэрүүн зун	1	2,6-4,0	2000-2500	< -1000...
	2, 3			-1000...-500
IV Хурай, сэрүүтэр зун	1	4,1-5,5	2500-3000	< -1000
	2, 3, 4			-1000...-500
V Гандуу дуулин зун	1	> 5,6	> 3000	< -1000
	2, 3, 4			-1000...-500

Тайлбар:
 $\Sigma d/P$ - чийг хангамжийн үзүүлэлт
 Σt - агаарын дундаж чийгийн хангамжийн дундаж хэмжээний нийлбэр
 P - жилийн дундаж хур тунадасны нийлбэр (мм)
 $\Sigma t > 10^\circ$ - 10° -оос дээшх агаарын хангамжийн дундаж температурын нийлбэр ($^\circ\text{C}$)
 Чийг ба дундаж хангамжийн үзүүлэлтийг 80 хувиар тооцожгарахаар авна.
 Өвлийн шилжид агаарын нэмэх хаасх температурын нийлбэрийн хязгарсар тодорхойлох ($^\circ\text{C}$).



ГАДАРГЫН УС

Бүгд Найрамдах Монгол Ард Улс гадаргын болон газрын доорх усны харьцангуй их нөөцтэй орон юм. Атласын энэ бүлэгт Монгол орны усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалахын тулд зайлшгүй мэдэж байх шаардлагатай усны нөөцийн хэмжээ, түүний горимын онцлогийн тухай төсөөллийг өгөв.

Энэ бүлгийн зургуудыг зохиоход Монгол орны гол мөрөн, нуурын усны горимын талаар БНМАУ-ын Байгаль орчныг хамгаалах яамнаас хийсэн олон жилийн суурин ажиглалтын материалаас гадна БНМАУ-ын ШУА-ийн Газарзүй, цэвдэг судлалын хүрээлэнгээс явуулсан хээрийн судалгааны болон хэвлэж нийтэлсэн зарим эх материалыг ашиглав.

Монгол орны гол мөрөн Умард мөсөн далай, Номхон далай, Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамаарна. Умард мөсөн далайн ай савд Монголын хамгийн том гол болох Сэлэнгэ мөрний урсгалын эхэн, дунд хэсэг, мөн тус улсын нутгаас эх авдаг Енисей мөрний хэсэг багтана. Номхон далайн ай савын усны сүлжээ түүрхийнхээс сийрэг бөгөөд энэ ай савд багтдаг томхон голуудаас Их Хянганы салбар уулсын хойт хажуугаас урсдаг Халхын гол, Хэнтэйн нурууны зүүн хажуугаас эх авдаг Хэрлэн, Онон, Улз голуудыг нэрлэж болно. Энэ ай савын хамгийн урт гол нь Хэрлэн боловч жилийнхээ урсгалын хэмжээгээр тус орны хамгийн их устай Сэлэнгэ мөрний дараа ордог Онон голынхоос нэлээд бага юм. Монгол орны нутгийн гуравны хоёр орчмыг Төв Азийн гадагш урсгалгүй ай сав эзэлнэ. Монгол Алтайгаас эх авдаг Ховд, Хангайн нурууны баруун хажуугаас урсдаг Завхан, Тэс голууд энэ ай савдаа хамгийн том нь юм.

Тус орны усны сүлжээ нутгийн хойт ба баруун хэсгийн уулархаг нутагт нэн нягт тул голын системийн ихэнх нь тэнд бүрэлдэн тогтоно. Нутгийн өмнөд, төв, зүүн өмнөд хэсэгт гол горхи цөөн, уг багатайгаас гадна гадагш урсгалгүй хотгорт орж замхардаг байна. Монгол орны нутагт байнгын урсгалтай 3800 гаруй гол байдаг бөгөөд тэдгээрийн нийлбэр урт 67 мянга орчим километр юм.

Монгол орны нутагт түр зуурын урсгалтай сайр газар сайгүй элбэг боловч олонх нь говийн хотгоруудыг хүрээлсэн уул нуруудад үүсч, уртаараа хэдэн арван километр хүрэх ч цөөнгүй бий.

Монголын баруун хэсэг буюу Их нууруудын хотгор, Нууруудын хөндийд Увс, Хяргас, Хар Ус, Хар, Бөөн Цагаан, Орог, Улаан зэрэг томоохон нуур оршино.

Тогтмол урсгалтай голын сүлжээний дундаж нягтшил улсын нийт нутаг дэвсгэрт $0,05 \text{ км}/\text{км}^2$ байдаг бөгөөд Монгол Алтайд $0,25 \text{ км}/\text{км}^2$ -аас илүү, Хангай, Хэнтэйн уулст $0,18-0,35 \text{ км}/\text{км}^2$, Номхон далайн ай савд багтах нутагт $0,10-0,15 \text{ км}/\text{км}^2$, Хангайн нурууны өвөр талд $0,05 \text{ км}/\text{км}^2$ -аас бага байна.

Монголын гол мөрний урсац бүрэлдэхэд хур бороо, газрын доорх ус, цас, мөсөн голын ус аль аль нь оролцох боловч гол мөрний эх тэжээл болохын хувьд тэдгээрийн үүрэг газар бүр харилцан адилгүй юм. Тухайлбал, Монгол Алтайн голуудын урсацыг бүрэлдүүлэхэд улирлын цас, мөсөн голын ус зонхилдог бол Хангай, Хэнтэйн голуудад хур борооны ус голлоно. Ерөнхийдөө Монгол орны нутагт хойноос урагшаа, баруунаас зүүн тийшээ гол мөрний тэжээлд хур борооны усны оролцоо ихсэж, цасны усны урсацын үүрэг багасах явдал нийтлэг юм. Монгол Алтайн Ховд, Сагсай, Буянт зэрэг голд цасны усны урсацын оролцоо 55—70%, борооны усных 5—10% байхад Хэнтэйн Ерөө, Хараа, Туул, Хэрлэн зэрэг голд борооны усны тэжээл цасныхаас 5—6 дахин их байна. Голын тэжээлд газрын доорх усны оролцоо ерөнхийдөө 20—40% байдаг боловч ус хураах талбайн дундаж өндөр ихсэх тутам түүний эзлэх хувь бага болно. Ус хураах талбайн дундаж өндөр ихсэх тутам гол мөрний тэжээлд цас, борооны усны эзлэх хувь өсөх бөгөөд тэгэхдээ борооны усны өсөлтийн шатлалын хэмжээ цасны усныхаас олон дахин бага байдаг ажээ.

Монгол орны бүх гол мөрний урсац зуны улиралд ямагт их байна. Хэдий тийм боловч сар, улирлын урсацын хэмжээ голын усны тэжээлийн онцлогоос голлон хамаарч нутаг нутагт ялгаатай байдаг. Тухайлбал Монгол Алтайн голуудад жилийн урсацын дийлэнх хэсэг 7—8 дугаар сард бүрэлддэг байхад Хөвсгөлийн баруун хэсэг, Хангайн баруун хойт хажуугийн голуудад жилийн урсацын ихэнх нь 5—6 дугаар сард бүрэлдэнэ. Хэнтэй, Хангайн голуудад 5 дугаар сараас урсацын хэмжээ нэмэгдэж хамгийн их нь 7,8 дугаар сард ажиглагдана.

Хамгийн их зарцуулга хур борооны үерийн үед голдуу ажиглагдана. Хэнтэй, Хөвсгөл орчмын голууд ихэвчлэн борооны усаар үерлэх боловч зарим жил цасны усны гаралтай шар усны үер тохиолдоно. Хөвсгөлийн баруун хэсгийн болон Хангайн нурууны баруун хойт хажуугийн голууд зуны хур бороо, хаврын цасны усаар үерлэх тохиолдол бараг тэнцүүхэн юм. Харин Монгол Алтайн голууд өндөр уулын цас мөс хайлах цагаар хамгийн их зарцуулгатай байдаг. Гол мөрний хамгийн бага урсац өвлийн цагт ажиглагдана. Тус орны өмнөд хэсгийн голууд зундаа их төлөв тасалддаг.

Өвөл удаан үргэлжилж хүчтэй хүйтэрдэг учраас Монгол орны олонх гол бараг жил бүр тундаа хөлдөнө. Намар гол захлах, зайр гүйх, цөн түрэх хэлбэрээр голууд мөстөх янз ордог бөгөөд тийнхүү мөс тогтож эхлэх хамгийн эрт хугацаа нь 10 дугаар сарын дундуур жижиг голуудад, хамгийн хожуу нь 10 дугаар сарын сүүлчээр уулын том голуудад тохиолддог.

Голын мөсөн бүрхэвч 140—180 хоног үргэлжлэн тогтдог бөгөөд зөвхөн Хангайн өвөр хажуугийн голууд 140-өөс цөөн хоног мөстэй байна. Жижиг, дунд хэмжээний олонх гол дээр халиа тошин үүснэ. Ялангуяа хөндий татмын сэгсвэр хурдас нь хөрсний ус элбэгтэй байдаг Хангай, Хэнтэйн голуудад халиа тошин нийтлэг юм.

Голын усаар зөвөрлөгддөг хатуу урсацын тухайд гэвэл Монгол Алтай, Хангай, Хэнтэйн голуудын эх булингар багатай ($25-50 \text{ г}/\text{м}^3$), харин адаг руугаа усны булингар $200 \text{ г}/\text{м}^3$ хүртэл ихэсдэг байна. Голын усны булингарын хамгийн их хэмжээ хаврын шар ус, зуны борооны үерийн үед ажиглагдах бөгөөд энэ хугацаанд жилийн бүх хатуу урсацын 90 шахам хувийг зөвөрлөдөг байна. Хур борооны үерийн үед их хэмжээний хатуу хашаас сайруудаар урсаж, зарим тохиолдолд уруйн үер буюу уруйн үертэй төстэй урсгал ч бий болно.

Атласын зураг дээр Монгол орны усны балансыг тодорхойлон үзүүлэхдээ газрын доорх урсац болон хөрсний чийгээс бүрдсэн усны эргэлтийн хурдас чулуулаг дахь хэсгийг ялган үнэлэх, түүнчлэн усны нөөцийн өөр өөр гаралтай эх үүсвэрийг тооцож үнэлэх бололцоог олгодог хэд хэдэн тэгшитгэлийн системийг иш үндэс болгосон юм.

Эдгээр тэгшитгэлийн систем нь дараах байдлаар илэрхийлэгдэнэ:

$$P=R+E; R=S+U, U+E=W, W=P-S, P=S+U+E,$$

Үүнд: P—хур тунадас, R—голын нийлбэр урсац, S—гадаргын урсац, U—газрын доорх урсац, E—ууршилт, W—газрын нийт чийгшил.

Усны балансын дээрх бүрэлдэхүүн хэсгийн зургийг зохиоходоо бүрэлдэхүүн

хэсэг тус бүр ус хураах талбайн дундаж өндрөөс хэрхэн хамаарч өөрчлөгдөх зүй тогтлыг үндэс болгов. Усны балансын бүрэлдэхүүн хэсгүүд ус хураах талбайн өндрөөс хэрхэн хамаарах байдлыг дараах 10 мужаар төлөөлүүлэн авч үзсэн байна. Үүнд: 1) Хан Хөхийн нурууны ар хажуу, 2) Хангайн өвөр хажуу, 3) Монгол Алтайн ар хажуу, 4) Монгол Алтайн өвөр хажуу, 5) Хөвсгөлийн баруун хэсэг, 6) Хөвсгөлийн зүүн хэсэг, 7) Хөвсгөлийн өмнөд ба Хангайн хойт хэсэг, 8) Хэнтэйн ар хажуу, 9) Хэнтэйн өвөр хажуу, 10) Их Хянганы ар хажуу эдгээр болно.

Монгол орны байгалийн нөхцөл янз бүр байдаг явдал усны балансын бүрэлдэхүүн хэсгийн тархалт хуваарилалтын онцлог нөлөөлнө. Голын нийлбэр урсац, түүнийг бүрдүүлэгч зүйлүүд хойноос урагшлах тутам багасна. Голын хамгийн их (200 мм-ээс дээш) урсац Хангай, Хэнтэй, түүнчлэн Монгол Алтайн өндөрлөг хэсэгт ажиглагдана. Гадаргын урсацын хэмжээ тус орны нийт нутгийн хувьд ихээхэн хэлбэлзэлтэй буюу 5—100 мм-ийн хооронд өөрчлөгдөж байдаг юм. Нийлбэр урсацын дотор газрын доорх урсацын эзлэх хувь 10—15%-иас 40—45%-ийн хооронд хэлбэлзэнэ. Газрын доорх урсацын хуваарилалдаг бүсийн зүй тогтол нь голын хашаас хурдас хуримтлансан уулс хоорондын олон хөндий хотгорт зөрчигддөг байна. Газрын нийт чийгшил, ууршилтын хэмжээ гадаргын өндөр ихсэх тутам буурна.

Монгол орны бүх нутгийн хувьд усны баланс ерөнхийдөө дараах байдалтай: хур тунадас—230 мм, голын нийлбэр урсац—22 мм, гадаргын урсац—14 мм, газрын доорх урсац—8 мм, газрын нийт чийгшил—216 мм, ууршилт—208 мм байна.

Монгол орны усны нөөцийг балансын аргаар тооцоолоход: хур тунадас—351 км³, голын нийлбэр урсац—34 км³, гадаргын урсац—22 км³, газрын доорх урсац—12 км³, газрын нийт чийгшил—329 км³, ууршилт—317 км³ болдог байна.

Тус орны байгалийн нэг өвөрмөц бүрэлдэхүүн хэсэг нь нуур юм. Монгол оронд 3000 орчим нуур байдаг бөгөөд тэдгээрийн нийлбэр талбай улсын бүх нутаг дэвсгэрийн 1 хувь орчмыг эзэлнэ. Бүх нуурын 85 хувь нь 1 км² хүртэл талбайтай жижиг нуур юм. Нийт нуурын дөнгөж 0,2% нь 1000 км²-аас их талбайтай бөгөөд тэдгээр хэдхэн том нуурын талбайн нийлбэр нь нийт нуурын талбайн 58,6 хувьтай тэнцэнэ.

Нуурын тархалт тун жигд биш, томхон нуурын олонх нь Монгол орны баруун ба хойт хэсгийн уулс хоорондын хотгор хонхорт, тухайлбал Их нууруудын хотгорт голчлон тархжээ. Сэлэнгэ мөрний ай савд хамгийн гүн (262 м) бөгөөд цэнгэг усны нөөцөөр хамгийн арвин Хөвсгөл нуур оршино.

Байгалийн үндсэн мужаар авч үзвэл нуурууд дараах байдлаар хуваарилагдана. Үүнд: бүх нуурын 13,3% нь Алтайн уулст тогтолцоонд, 20,8% нь Хангай, Хэнтэйн уулст, 29,4% нь Монголын дорнод хэсэгт, 36,5% нь говьд тус тус байна. Нуурууд тектоник, галт уул, мөстөл, цөмрөл, элсэнд хаагдсан, хөндийлж, дулааны хөндийлж, хаагдал-нуралтын болон орчин үеийн эвдрэл-хуримтлалын гаралтай хотгор хонхорт тогтсон байна.

Монгол орны нуурыг усны сэлбэг тэжээлийн байдлаар: 1) борооны усаар голчлон тэжээгддэг (байн байн ширгэдэг жижиг нуурууд), 2) голын усаар голчлон тэжээгддэг, 3) газрын доорх усаар илүү тэжээгддэг, 4) голын ба газрын доорх усны холимог тэжээлтэй гэж 4 бүлэгт хувааж болно. Нуурын тэжээлийн эх үүсвэр нь тэдгээрийн усны төвшний горимыг тодорхойлно. Нуурын олонх нь усныхаа ихэнхийг зуны хоёр—гурван сард авдаг учир тэдгээрийн усны төвшин 7,8 дугаар сард эрс дээшлж хоёроос дөрвөн сарын турш тогтвортой өндөр байгаад 10 дугаар сараас эхлэн огцом буурна. Урсгал нуурын усны төвшний жилийн хэлбэлзэл 30—80 см байна.

Нуурын усны дулааны горимын өөрчлөлт жилийн турш харьцангуй нэг хэвийн байна. Ууланд ч тэр, тал газарт ч тэр, нуурын усны температур өвөл, хавар ихээхэн өөрчлөгдөж 3 дугаар сараас эхлэн 5,6 дугаар сар хүртэл алгуур нэмэгдсээр 7,8 дугаар сард нуурын ус хамгийн их хална.

Монгол орны нуурууд усан хангамжид ашиглах бололцоотой 500 км³ гаруй ус агуулж байдаг нь бүх голын урсацаас бараг 15 дахин их юм. Бас загас, давсны нөөцөөр баялагаас гадна эмчилгээний чанартай эрдэс, шавар агуулдаг (Цайдам, Тосон, Гурван нуур зэрэг) нуур ч цөөнгүй бий. Зарим урсгал нуур дээр усан цахилгаан станц байгуулах боломжтой юм.

Монгол орны уулын мөсөн голыг одоогоор бүрэн судлаагүй байна. 1947—1950, 1972 онуудад авсан агаарын гэрэл зургийн мэдээгээр Монгол оронд нийтдээ 186 мөсөн гол бий бөгөөд тэдгээрийн нийлбэр талбай 540 км² хүрнэ.


Бүх мөсөн голын 62% нь 1 км²-аас илүүгүй талбайтай жижиг мөсөн голууд бөгөөд тэдгээрийн нийлбэр нь нийт мөстлийн гадаргын дөнгөж 8,2%-ийг эзэлнэ. Мөстлийн нийт талбайн 57,4%-ийг 10 км²-аас дээш талбай бүхий томовтор мөсөн голууд эзэлдэг байна. Тархалт болон хамрах талбайн хувьд уулын ар хажуугийн мөсөн гол зонхилж, уулын энгэр хажууд бүх мөсөн голын дөнгөж 3-аас илүүгүй хувь нь байрлана.

Мөстлийн талбайн дийлэнх хэсэг нь Монгол Алтайн нуруунд байдаг. Тэнд Монголд хамгийн том Потанины болон Гранегийн мөсөн голууд бий. Потанины мөсөн голын талбай 53,5 км² юм. Монгол Алтайн нурууны мөсөн голыг: 1) хөндийн (хотгорын, хунх-хөндийн, дүүжин хөндийн) мөсөн гол—24,6%, 2) уулын хажуугийн (хунхын, дүүжин-хунхын, дүүжин) мөсөн гол—75,3%, 3) элэгдлийн гадаргын (хавтгай оройн) мөсөн гол—0,4% гэсэн 3 бүлэгт хувааж болно. Монгол Алтайн мөсөн голуудын гөлчир мөсний хилийн шугам уулсын үнэмлэхүй өндөр, хэрчигдэл, сүүдэртлийн байдлаас шалтгаална. Монгол Алтайн зүүн хэсгийн ар хажуу дахь мөсөн голын доод үзүүр хамгийн өндөр байрласан нь далайн төвшнөөс дээш 3200—3600 метрт, хамгийн нам нь Ховд, Сагсай голын савд 2800—3200 метрт оршино. Монгол орны мөсөн голууд орчин үед ерөнхийдөө хайлж шуугдсаар байгааг адагт нь хонхор үүсч нуур тогтож буй явдал гэрчилнэ.


Монгол орон усны хүрэлцээтэй нөөцтэй юм. Тус улс нь нэг хүнд ногдох усныхаа хэмжээгээр Ази тивд тэргүүн байранд ордог боловч усны нөөц бүх нутагт жигд биш тархжээ. Монгол орны ус үндсэндээ цэвэр тунгалаг учраас ахуйн болон үйлдвэрийн хэрэгцээнд ашиглах бүрэн боломжтой. Монголчууд эртнээс усыг эрхэмлэн хайрлаж цэвэр ариун байлгах, нөөцийг нь барагдуулахгүй байхыг хичээж ирсэн заншилтай билээ. Орчин үед усыг ашиглахын зэрэгцээ түүнийг хамгаалах асуудал онцгой чухал болж байна.

Усны нөөцийг зүй зохистой ашиглах, хамгаалах талаар иж бүрэн арга хэмжээ авч явуулж байна. Зарим газар бороожуулах төхөөрөмж тавьж ашигласнаас гадна усжуулалтын жижиг системүүд байгууллаа. Монгол орны усны нөөцийг нэгдмэлээр ашиглах хамгаалах ерөнхий болон бус нутгийн схемийг боловсруулаад байна.


82 УСЗҮЙН СҮЛЖЭЭ
Масштаб 1:4 500 000



83 ГОЛЫН СҮЛЖЭЭНИЙ НЯГТШИЛ
Масштаб 1:2 000 000




84 ГАДАРГЫН УСНЫ ХИМИЙН НАЙРЛАГА, ЭРДЭСЖИЛТ
Масштаб 1:2 000 000




85 ГОЛ МӨРНИЙ НИЙЛБЭР УРСАЦ

Масштаб 1:9 000 000




86 ГАДАРГЫН (ҮЕРИЙН) УРСАЦ

Масштаб 1:9 000 000




87 ГАЗРЫН ДООРХ УРСАЦ

Масштаб 1:9 000 000




88 ГАЗАР НУТГИЙН НИЙТ ЧИЙГШИЛ

Масштаб 1:9 000 000




89 УУРШИЛТ

Масштаб 1:9 000 000





90 УСНЫ ГАДАРГААС УУРШИХ УУРШИЛТ


Масштаб 1:9 000 000




91 ГОЛ МӨРНИЙ УСНЫ ГОРИМ
Масштаб 1:9 000 000




92 ГОЛ МӨРНИЙ МӨСНИЙ ГОРИМ
Масштаб 1:9 000 000




93 ХАТУУ УРСАЦ
Масштаб 1:9 000 000




94 ГОЛ МӨРНИЙ УСНЫ БУЛИНГАР
Масштаб 1:9 000 000




95 ШАР УСНЫ ҮЕРИЙН ХАМГИЙН ИХ УРСАЦ
Масштаб 1:9 000 000




96 БОРООНЫ ҮЕРИЙН ХАМГИЙН ИХ УРСАЦ
Масштаб 1:9 000 000







97 УСНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ НӨӨЦ
Масштаб 1:9 000 000



98 УСНЫ НӨӨЦ АШИГЛАЛТ
Масштаб 1:9 000 000



99 ОРЧИН ҮЕИЙН МӨСӨЛ(бүдүүвч)



ХӨРС

Хөрсөн бүрхэвч бол хөдөө аж ахуйн голлох салбарын хөгжих чиглэл, шинж төлөвт чухал нөлөө үзүүлдэг газарзүйн орчны нэг хэсэг мөн. Монгол орны байгалийн өвөрмөц нөхцөлд мөн өвөрмөц маягийн хөрс тогтворжиж, газарзүйн тархалтын нь зүй тогтол нарийн ээдрээтэй болжээ.

1970-аад оноос эхлэн БНМАУ-ын ШУА, ЗСБНХУ-ын ШУА-ийн Монгол-Зөвлөлтийн хамтарсан биологийн иж бүрэн экспедиц Монгол орны хөрснийг судлах талаар ихээхэн ажил хийж, тус улсын бүх нутгийг хамарсан хөрсний хайгуул шинжилгээ болон байгалийн янз бүрийн бүсэд тайлал хийхээр сонгож авсан тодорхой газруудад агаарын гэрэл зураг ашиглан хөрсний нарийвчилсан зураглалын судалгаа явуулж хөрсөн бүрхэвчийн бүтэц, бүрэлдэхүүнийг илрүүлэх боломжийг бүрдүүлсэн байна. Байгалийн үндсэн бүсүүдийн голлох хөрсний чийг-дулааны горимын талаар суурин ажиглалт явуулснаас гадна хээрийн судалгаагаар цуглуулсан хөрсний дээжүүдэд задлан шинжилгээ хийжээ. Эрдэм шинжилгээний энэ бүх мэдээ баримт нь атласт орсон хөрсний зургуудыг зохиох эх үндэс болж өгсөн юм. Үлэмжхэн мэдээ сэлт хуримтлуулсан боловч уулархаг нутгийн хувьд судалгааны маршрут сийрэг байсан учраас нэг нутаг районд илэрсэн зүй тогтлыг нөгөө рүү тохон шилжүүлэх аргын өргөн хэрэглээ.

БНМАУ-ын хөрсний 1:3 000 000 масштабтай зурагт хөрсөн бүрхэвчийн бүтцийн ялгаа, бүх төрлийн хөрсний тархалтын ерөнхий зүй тогтлыг тусган үзүүлээ. Хөрсний тархалтын байр байдалд бүсийн уур амьсгал, өндрийн бүслүүр, хотгорын үйлчлэл, тонгороо (инверсийн) үзэгдэл, уулын нөмрийн чийгэрхүү шинж, хажуугийн зүг зохисын ялгаа, түүнчлэн талархаг нутгийн өндрийн төвшний өөрчлөлт хавсран нөлөөлнө. Эдгээр хүчин зүйлийн нарийн төвөгтэй харилцан үйлчлэлийн үр дүнд хөрсний өргөргийн бүсүүд зүүнээс баруун тийш үргэлжлэхдээ зарим газар чиглэлээ өөрчилж, өргөн нарийн болж, хааяа тасалдаж, уулс урагшаа түрж орсон буюу ялангуяа уулнаас тал газарт эрс огцом шилждэг хэсэгт бүр тасардаг ч бий. Уул нуруудын хоорондох хөндий хотгорт уулсын хормойгоос хотгорын төв рүү хөрсөн бүрхэвч өөрчлөгдөж хамгийн хуурай төв хэсэгт нь говь, цэлийн хөрс тогтворжиж тал нутагт байдгаасаа хойгуур өргөртөг тархсан нь цөөнгүй үзэгдэнэ. Үүний нэг тод жишээ нь Их нууруудын хотгорын хөрсөн бүрхэвч юм.

Хөрсний нь онцлог шинжийг харгалзан Монгол орныг, ЗХУ-ын хил залгаа зарим нутагтай хамтруулан Төв Азийн хөрс-био уур амьсгалын биеэ даасан их муж болгон тусгайд нь ялгаж үздэг байна. Тус их мужийн хүрээнд Хангайн болон Говийн хөрс-био уур амьсгалын хоёр үндсэн муж ялгардаг. Эдгээр муж тус бүрийн доторх хөрсний бүс, бүслүүрийн хам бүрдэл нь цацрагийн болон температурын нөхцөл, чийг хангамжийн байдал, энэ бүхнээс шалтгаалах хөрс үүслийн үйл явцын онцлогийн хувьд хоорондоо төстэй юм. Үүнээс гадна Монгол орны баруун өмнөд захад баруун талаараа задгай, бусад талаараа уул нуруугаар хүрээлэгдэн оршдог багавтар талбайтай Баруун Хуурайн хотгорыг хөрс-био уур амьсгалын өөр тусгай мужид багтааж үздэг.

Хангайн хөрс-био уур амьсгалын муж Монгол орны умард хагасыг эзэлдэг бөгөөд урд хил нь цайвар хүрэн хөрсний дэд бүсийн хойт хилтэй давхцаж таарна. Тус мужийн уулархаг бүс нутаг нэлэнхийдээ хар хүрэн, хүрэн хөрстэй. Хар шороон хөрс ихэнхдээ нам уулын хотгор гүдгэрийн нөхцөлд, заримдаа уулын бэл хормойн талархаг газраар тархаж ерөнхийдөө багахан талбайг эзлэнэ. Уг хөрсийг тариаланд ашиглах боломж газрын гадагш онцлогоос нь болоод хязгаарлагдмал байдаг. Харин хар хүрэн, хүрэн хөрс тус улсын талархаг нутгийн тэн хагасаас илүү хувийг эзэлдэг тул тариаланд ашиглахад бололцоотой юм. Эдгээр хөрс хэдийгээр уудам их талбайг хамрах боловч ухаа толгодорхог гадарга давамгайлж нимгэн давхаргатай, сайр чулууурхаг, эсхүл хөнгөн (элсэнцэр ба элсэн) бүрэлдэхүүнтэй хөрс зонхилдог учраас тариалангийн эдлэлрийн талбайг тэлж нэмэгдүүлэх нөөц газар бага гэж болно.

Хангайн хөрс-био уур амьсгалын мужийн уулархаг нутагт ой, тайгын хөрсний өндрийн бүслүүр тод ажиглагдана. Тайгын хөрсөнд олон жилийн цэвдэгтэйгээс гадна улирлын цэвдэг удаан хадгалагдахаас болоод хөрс гулсах, үе давхаргууд нь хэв гажиж хоорондоо хутгалдах үзэгдэл элбэг тохиолддог. Тайгад уулын тайгын цэвдэгт, уулын тайгын-ширээт гүн хөлдөмтгий хөрс голлон тархаж, харин чандруулаг хэвшинжийн хөрс Монголд ховор байна. Тайгын бүслүүрийн дээд хэсэгт уулын цэвдэгт-тайгын өнгөнөөсөө төмрийн исэлжилтэнд автагдсан хөрс тогтворжиж дээд захаараа тундрын хөрстэй хиллэнэ. Уулын тайгад хар шороон маягийн хөрстэй хээрийн жижиг толбууд тохиолдох бөгөөд тэгэхдээ зөвхөн уулсын хоорондох өргөн ам хөндий рүү харсан эгц энгэр газраар л үзэгддэг. Экологийн өөр өөр нөхцөлд байдаг хөрс ийнхүү нэг дор зэрэгцэн орших явдал ялангуяа тайга, хээрийн зааг орчмын нутгийн хөрсөн бүрхэвчийн үндсэн дүр төрх нь болдог байна. Тэнд ой, хээр хоёрын эзлэх талбайн харьцаа маш хэлбэлзэлтэй байдаг юм. Энэхүү өвөрмөц маягийн ойт хээрийн бүсийг хөдөө аж ахуйд өргөн ашигладаг учир тус орны тариалангийн эдлэл, хадлан, бэлчээрийн үлэмж хэсэг нь энд оршдог. Монгол орны ойт хээрийн байгалийн нөхцөл жигд биш, газар газар өөр байдаг тул хөрсөн бүрхэвч нь мөн олон янз байна. Ийм учраас тус нутгийн аль нэг хэсгийг ашиглах боломжийг тодорхойлох болон үйлдвэрлэлийн өндөр үр өгөөжийг хангахуйц өргө ажиллагааг боловсруулахдаа онцгой анхааралтай хандах явдал чухал юм.

Говийн хөрс-био уур амьсгалын муж Монгол орны өмнөд ба баруун хэсгийг эзлэнэ. Энд өндөр уул нурууд, уул хоорондын хотгор эзлэсэн үргэлжилж, тэгш тал газар тус орны зүүн өмнөд хэсэгт харьцангуй багахан талбайтай байна. Тэрхүү тал нутагт хөрсний өргөргийн бүсүүд тод илэрч хойноос урагшаа цайвар хүрэн, цөлөрхөг хээрийн бор, цөлийн бор саарал хөрс солигдон тархдаг юм. Уулсын хоорондох хотгоруудад түр зуурын урсгал усны ул мөр болох хуурай сайраар хэрчигдсэн хэвгий тал газар буюу уулын бэл үлэмжхэн талбайг хамарна. Сайрын гулдрал нь эхэн хэсэгтээ чулууурхаг бол адаг руугаа элсэн хурдсаар дүүрч, тэр элс нь хөрс үүслийн үйл явцад ямар нэг хэмжээгээр өртөж тэнд уулын бэл хормойн хөрстэй ойролцоо маягийн хөрс тогтсон байдаг. Ийм газрыг Монгол орны хөрсний зураг дээр хөрсөн бүрхэвчийн бүтцийн өвөрмөц нэгэн хэвшинж — сайрын хэвшинжит нутаг болгон ялгаж, Заримдаг цөлийн бүсийн уул нурууд гол төлөв цайвар хүрэн хөрстэй, бэл хормой нь цөлөрхөг хээрийн бор, цөлийн бор саарал хөрстэй байна. Гэтэл цөлийн бүсийн баруун хэсэг-Алтайн өвөр говьд бол байдал өөр юм. Хамгийн гандуу нутаг болох энэ хязгаарт уулын бэл хормойн талархуу газар үндсэндээ чулууурхаг цөлийн (гаммада) төрхийг хадгална. Энд дунд ба шинэ төрмөлийн эриний давсархаг тунчмал чулуулаг байн байн ил гарч, хэт гандуу цөлийн борзон хөрс тархна. Говийн хөрс-био уур амьсгалын мужийн нутаг дийлэнхдээ бэлчээрийн эдлэл болж ашиглагддаг. Тэндхийн хөрс хөнгөн механик бүрэлдэхүүнтэй учраас салхинд хийсч эвдрэх үйл явц дамжрахаас болгоомжилж бэлчээрийн даацыг хэтрүүлэхгүй байвал зохино.

Говийн хөрс-био уур амьсгалын муж доторх уулархаг нутагт хөрсөн бүрхэвчийн өндрийн бүслүүрийн зүй тогтол мөн тод илэрнэ. Уулын доод бүслүүрт цөлөрхөг хээрийн ба цөлийн хөрстэй байснаа өндрийн төвшин дээшлэхэд хүрэн хэвшинжийн хөрсөөр солигдож, улмаар өндөр уулын хээрийн бүдүүн ялзмагт, уулын нутаг-хээрийн, уулын нугын, заримдаа уулын тундрын хөрс дээш дээшлэнэ шатлан тархжээ.

Хөрсний мужлалтын одоогийн баримталж буй системийн дагуу хөрс-био уур амьсгалын мужийг дотор нь өргөргийн бүсний бүтэц бүхий нутаг, босоо бүслүүрийн бүтэц бүхий нутаг гэсэн хоёр хэвшинжид хуваадаг. Гэтэл Монгол орны

хувьд гурав дахь хэвшинжийн — холимог бүсний бүтэцтэй нутгийг ялгах шаардлага гарч ирсэн бөгөөд тийм нутгийн хөрсөн бүрхэвчийн шинж байдалд өргөргийн бүсний зэрэгцээгээр газрын өндөр нам, уул нурууд ойр байрласан явдал нөлөөлнө. Холимог бүсний бүтэц бүхий үргэлжилсэн томоохон нутгийн тоонд Их нууруудын хотгор, Монголын дорнод тал орно. Монголын дорнод талд улсын умард хилээс өмнөд хил хүртэл өргөргийн дагуух асар уудам нутгийг хар хүрэн хөрсний бүс дангаараа эзэлдэг нь тэнд хойноос урагшаа тухам газрын үнэмлэхүй өндөр ихэсдэгтэй холбоотой юм. Хар хүрэн хөрстэй нутгийн доторх уужуу хотос нам газруудаар арай хуурайдуу шинжтэй жинхэнэ хүрэн хөрс тархаж, захын уулс руу харьцангуй чийглэг нөхцөлд тогтворждог хар шороон, нугат-хар шороон хөрс хэсэг хэсгээр тохиолдоно.

Холимог бүсний бүтэц бүхий нутаг нь хөрсөн бүрхэвчийн бүрэлдэхүүн хэсгүүдийн хоорондох уялдаа холбоо, геохимийн шилжил үйл явцын нөхцөлийн хувьд нэлээд өвөрмөц шинжтэй байдаг. Ийм нутагт хөрсөн бүрхэвчийн бүтэц байгууламж олон янз байхаас гадна тэдгээрт нөлөөлөх төрөл бүрийн хүчин зүйлийн үйлчлэлийн хэр хэмжээ ч харилцан адилгүй байна. Хөрсний мужлалтыг цааш нь нарийвчилж бүсний бүтэц бүр бүтэц бүхий дээрх гурван хэвшинжийн нутаг тус бүрийн дотор хөрсний хослол, хам бүрдлийн хувьд нэг янзын төрх байдалтай, бэсрэг хотгор гүдгэрийн хувьд нэг хэлбэрдүү шинжтэй тодорхой хэсэг болох хөрсний тойргуудыг ялган тогтоов.

Монгол орны байгалийн өвөрмөц нөхцөлөөс хамаарч хөрс үүсэх үйл явц бас онцлог шинжтэй байна. Тухайлбал уулын тайгад хөрсний урвалын орчин хүчиллэг шинжтэй, ялзмаг нь фульват найрлагатай байдаг боловч хөрс чандруужих явц сул байна. Үүний нэг шалтгаан нь хөрс удаан хугацаагаар хөлдүү байдалд оршиж хэт хөрдөг явдалтай холбоотой. Бага температуртай орчинд хөрсөн дэх цахиурлаг бүс хэлбэрийн төмөр болон төмөрт-органик нэгдлүүд усгүйжиж улмаар хөнгөн цагаант-цахиурлаг ширхэгүүдийн гадарга дээр тунаж тогтдог байна. Үүний дүнд уг төмрийн нэгдлүүдийн цаашид шилжил хөдөлгөөн удаашрахын хамт эрдэс чулуулгийн ширхэгүүдийг хучиж тогтсон төмрийн өнгөр хальс нь тэдгээрийг хөрсний уусмалын хүчтэй үйлчлэлээс хамгаалдаг ажээ. Үүнээс болоод тайгын хөрс чандруулаг шинжтэй болж чаддаггүй байна. Хүрэн, хар шороон хөрсний ялзмагийн давхарга нимгэн байдаг нь тэдгээрийн нэг нийтлэг онцлог бөгөөд энэ нь ургамлын үндэсний дийлэнх хэсэг ус чийгийн төлөөнөө тэмцэх амьдралын жамыг даган хөрсний гадаргад ойрхон шахаж байрласантай холбоотой бизээ.

Жилийн хур тунадасны ихэнх нь зуны богино хугацаанд бөөн ордог боловч борооны ус хөнгөн механик бүрэлдэхүүнтэй хөрс чулуулагт гүн нэвчиж, заримдаа бүр хүрэн хөрсний бүх үе давхаргыг нэвт норгож чийглэгдэж байна. Хөрсөн дэх уусмалын доошоогоо чиглэсэн хөдөлгөөн зонхилдог үе, хөрсний биологийн идэвх дээд хэмжээндээ хүрч хөрсний агаарын найрлагад нүүрсхүчлийн хийн агууламж харьцангуй их байдаг үе хоёр нэг хугацаанд давхцаж таардаг учраас хөрс угаагдах боломж бүрддэг байна. Үүний үр дүнд хар хүрэн, хүрэн хөрсөнд дээрээсээ угаагдаж тогтсон карбонатын алтүү давхарга тод илрэхээс гадна карбонатгүй байх ч явдал бий. Нүүрсхүчлийн давс их хэмжээгээр агуулсан карбонатын хуримтлалын зузаан давхарга хээрийн хөрсөнд цөөнгүй байдгийг зөвхөн орчин үеийн хөрс үүсвэрийн үйл явцтай холбож тайлбарлах боломжгүй бөгөөд түүнийг тухайн хөрсний үүсэл хөгжлийн өмнөх үе шатанд одоогийнхоос илүү чийглэг нөхцөлд бүрэлдэж бий болсон үлдмэл шинжтэй зүйл гэж үзэх нь зөв бололтой.

Монгол оронд тархсан цөлөрхөг хээрийн бор, цөлийн бор саарал хөрсөнд хялбар уусах давс, гөлтгөнө ихэнх тохиолдолд байхгүй байдаг нь тэдгээр хэвшинжийн хөрсний онолох нэг шинж тэмдэгтэй зөрж буй хэрэг. Эдгээр хөрс болон доор нь дэвсгэр тогтсон нэвсгэр хурдас чулуулагт ийнхүү угаагдаж давсгүй болсныг тухайн орон нутгийн эх газрын хөгжлийн түүхэн онцлогтой холбож үзвэл зохино. Хэт гандуу цөлийн борзон хөрс чулууурхаг цөлийн нөхцөлд дээд ургамлын оролцоогүйгээр үүсэж бүрэлдэнэ. Уг хөрсний гадарга сайр чулууургаар битүү хучигдаж, түүний доорх өнгөн хэсэг нь олон талт ан цаваар жижиг хэсгүүдэд хуваагдсан байдаг. Тэрхүү ан цав нь давсны хүчилд буцлахгүй угаагдамал элсээр дүүрсэн байна. Ан цаваар тусгаарлагдсан хөрсний олон талт цуламд хэсгүүдийн дээд талд өрмөтөн тогтсон том сүвэрхэг өнгөн үе байна. 2-3 см нимгэн энэ өнгөн үе болон түүний доод давхарга нь хялбар уусах давс, гөлтгөнө их агуулдаг боловч гүн рүүгээ тэдгээрийн хэмжээ багасна. Атласт үзүүлсэн хөрсний зүсэлтийн зургаас харахад хэт гандуу цөлийн борзон хөрсний нийт зузаан 30-40 см-ээс хэтэрдэггүй ажээ.


Энэ бүлэгт хэсгэлэн өвч үзүүлсэн хөрсний амагт дэлгэрэнгүй зургууд хөрсөн бүрхэвчийн бүтцийг нэлээд нарийн тусгахын хамт байгалийн янз бүрийн бүс дэх хөрсний тархалтын газарзүйн зүй тогтлыг харьцуулан дүгнэх боломжийг олгоно. Эдгээр зургийг үндэслэн зохиосон газрын агро-үйлдвэрлэлийн бүлэглэлийн бүдүүвч нь байгалийн өөр өөр нөхцөлд хөрсний зөв зохистой ашиглах төлөв байдлыг илэрхийлэхээс гадна нутаг дэвсгэрийг аж ахуйд зориулан зохион байгуулахад байгалийн бүсүүдээр ялгаартай хандах явдал зайлшгүй хэрэгтэйг харуулж байна.

БНМАУ-ын хөрсний зурагт тус орны янз бүрийн нутагт цоохортон тархсан элдэв төрлийн давсархаг хөрсний байрлалыг мөн үзүүлсэн бөгөөд эдгээр хөрс нийтдээ харьцангуй бага талбайг эзэлдэг боловч хөрсөн бүрхэвчийн чухал бүрэлдэхүүн хэсэг нь болж газар нутгийн ашиглалтын байдалд, ялангуяа түүний давсны балансын ерөнхий үнэлгээг гаргахад мэдэгдэхүйц нөлөө үзүүлнэ. Энэ бүлэгт орсон давсархаг хөрсний тархалт, химийн шинжийн зургаас дараах хэдэн гол зүйлийг харж болно. Үүнд: 1. Гандуу ба гандуувартар нөхцөлтэй бусад улс оронтой жишихэд Монгол оронд давсархаг хөрс харьцангуй бага тархсан байна. 2. Байгалийн янз бүрийн бүсийн давсархаг хөрс давсныхаа найрлагаар ялгаатай. Хойт зүгийн нутгаар нүүрсхүчлийн натрийн (хужирлаг) давсжилттай хөрс, цөлийн бүсэд гөлтгөнө их агуулсан саармаг давсжилттай хөрс зонхилдог байна. 3. Цөл нутагт орчин үеийн давс хуримтлалын явц хязгаарлагдмал бөгөөд зөвхөн усархаг хэлбэрийн хөрстэй газраар илэрч үзэгдэнэ. 4. Цөлийн зарим хөрс бор орны нөлөөгөөр илүү шүлтлэг шинжтэй болсон байна.

Монгол оронд хур тунадас голчлон аадар борооны шинжтэй ордог, түүнчлэн хүчтэй салхи, шороон шуурга байн байн тохиолддог, ялангуяа өвс ногоо ургаж гүйцээгүй, хөрс хуурай байдаг хаарын сөрүүдэд салхи ихтэй байдагас болоод хөрс эвдрэх үзэгдэл түүгээс дэлгэрчээ. Эдгээр үзэгдлийн тухай ерөнхий төсөөллийг хөрсний эвдрэлийн зургаас олж үзэж болно. Уг зурагт хөрсний эвдрэлийн явц хүчтэй илэрч болзошгүй эмзэг газруудыг ялган харуулсан юм.


Энэ бүлэгт Алтайн өвөр говьд байдаг Эхийн голын баян бүрдийн хөрсөн бүрхэвчийн бүдүүвчийг үзүүлсэн нь сонирхолтой юм. Баян бүрдүүд Монголын цөлийн онцгой нэгэн экосистем мөн учраас хэдийгээр өчүүхэн бага талбайг хамардаг ч гэсэн тухайн нутаг орны төрх байдлыг тодруулахад нэмэр болно. Эхийн гол бол цөл нутагтаа хамгийн том баян бүрд бөгөөд тэнд усалгаатай тариалан эрхэлж, дулаан шаарддаг зарим төрлийн таримал ургуулдаг ажээ. Баян бүрдийн экосистемийн хөрсөн бүрхэвчийн бүтэц бүрэлдэхүүн нэлээд нарийн агаад тэнд усархаг хэлбэрийн хөрс болон давсжих үйл явц ихээхэн дэлгэрснийг энэ бүдүүвч зургаас харж болно.

Монгол орны хөрсөн бүрхэвчийн бүрэлдэн тогтох явцад хүний аж ахуйн үйл ажиллагааны үр нөлөө жилээс жилд улам нэмэгдсээр байна. Тус орны хөрсний нөөцийг зүй зохистой ашиглаж газраас хамгийн их бүтээгдэхүүн авах зорилгыг шийдвэрлэхийн тулд хөрсөнд оногдох хүний үйл ажиллагааны ачааллын байж болохуйц дээд хэмжээг тодорхойлох асуудал тулгарч байна.



УУЛ НУРУУД	НАМ УУЛ, УХАА ТОЛГОД	ТАЛ, ХОТГОР, ЖИЖИГ ЦАВ ТОЛГОД	ХӨРС
ӨНДӨР УУЛЫН БА УУЛЫН ТАЙГЫН ХӨРС			
			Тундрын
			Өндөр уулын хээрийн дэвсгэл
			Өндөр уулын хээрийн бүдүүн хэлээт
			Уулын хуурай хээрийн бүдүүн хэлээт
			Уулын нугын
			Уулын нугын цэвдэгт
			Уулын-нууц-хээрийн
			Цэвдэгт-тавын өнгөнөөсөө шилжин исламтай
			Цэвдэгт-тавын
			Чандруулал (цэвдэгт ба гүндээ цэвдэгтэй)
			Шаргал-тавын гүндээ цэвдэгтэй (мүүний дотор үндэс карбонатлаг)
			Шаргал-тавын чандруулал гүндээ цэвдэгтэй
			Шаргал-суя чандруулал гүндээ цэвдэгтэй
			Нугын цэвдэгт
ОЙТ ХЭЭРИЙН БА ХЭЭРИЙН ХӨРС			
			Нугат-ойн гүн хэлбэртэй
			Карбонатлаг хар шороон (мүүний шал нь доод эзэлтэй, нууцарха шинжтэй)
			Нугат карбонатлаг хар шороон
			Нугат карбонатлаг нилсэн хар шороон
			Нугат карбонатлаг доод эзэлтэй нууцарха шинжтэй хар шороон
			Сул хөгжилтэй эвсэн хар шороон
			Гүн хөгжилтэй нугат-хар шороон
			Нугын хээрсэн
			Нугын давсарха гүндээ цэвдэгтэй

УУЛ НУРУУД	НАМ УУЛ, УХАА ТОЛГОД	ТАЛ, ХОТГОР, ЖИЖИГ ЦАВ ТОЛГОД	ХӨРС	УУЛ НУРУУД	НАМ УУЛ, УХАА ТОЛГОД	ТАЛ, ХОТГОР, ЖИЖИГ ЦАВ ТОЛГОД	ХӨРС
ХУУРАЙ ХЭЭРИЙН БА ЦӨЛЖҮҮ ХЭЭРИЙН ХӨРС							
			Нугат карбонатлаг хар хүрэн				Нугат карбонатлаг цайвар хүрэн
			Үндэс карбонатлаг хар хүрэн				Нугат карбонатлаг маралаа цайвар хүрэн
			Нугат карбонатлаг маралаа хар хүрэн				Нугат карбонатлаг нилсэн цайвар хүрэн
			Нугат карбонатлаг ба карбонатлаг нилсэн хар хүрэн				Өнгөнөөсөө карбонатлаг хүрэн (адамалаагүй)
			Нугат карбонатлаг доод эзэлтэй нууцарха шинжтэй алт хүрэн				Сул хөгжилтэй эвсэн хүрэн
			Нугат карбонатлаг үндэс нууцарха шинжтэй хар хүрэн				Нугат карбонатлаг нугат-хүрэн
			Нугат карбонатлаг хүрэн				Нугат карбонатлаг хээрсэн нугат-хүрэн
			Нугат карбонатлаг маралаа хүрэн				Маралаа нугат-хүрэн
			Нугат карбонатлаг нилсэн хүрэн				Нугын давсарха
			Нугат карбонатлаг үндэс нугарха шинжтэй хүрэн				



ХӨРСӨН БҮРХЭВЧИЙН БҮТЭЦ


- ӨНДӨРШИЛ-ЗҮГ ЗОВХИСЫН**
- ЗҮГ ЗОВХИСЫН**
- ЭЛЭГДЭЛ-ХУРИМТЛАЛЫН**
Хөрсний харшил:
- уусуул хэлбэрийн чулуурхай нимсэн ба гүйцэд хөгжилтэй хөрс
- уусуул ба чийгт хэлбэрийн хөрс
- уусуул ба чийгт хэлбэрийн дэвсгэрлэг хөрс
- ЭЛЭГДЛИЙН**
Хөрсний харшил:
- ил гарсан хай чулуу бүхий дундуу хөгжилтэй хөрс
- ил гарсан хай чулуу бүхий дундуу ба гүйцэд хөгжилтэй хөрс
- ХУРИМТЛАЛЫН**
Хөрсний харшил:
- уусуул ба чийгт хэлбэрийн (эсвэл дорой аюултай) хөрс
- чийгт хэлбэрийн хөрс
- чийгт хэлбэрийн хөрс ба мара
- мараалаг ба мараалаг хөрс
- ҮЛЭГДЭЛ ХИЙСЭЛТИЙН**
- САЙРТ-ЭВДРЭЛИЙН**

- Ил гарсан суурь чулуулаг
- Ил гарсан шавар
- Эгс
- Хөрс зулалт
- Асва хай
- Мисэн дэл

Тайлбар: Хөрсөн бүрхэвчийн бүтэцтэй илгэсэн зурсан тэмдгийг зураг дээр зөвхөн хөрснийх нь өнгөөр өгөө

УУЛ НУРУУД	НАМ УУЛ, УХАА ТОЛГОД	ТАЛ, ХОТГОР, НИЖИГ ЦАВ ТОЛГОД	ХӨРС	УУЛ НУРУУД	НАМ УУЛ, УХАА ТОЛГОД	ТАЛ, ХОТГОР, НИЖИГ ЦАВ ТОЛГОД	ХӨРС	ТАЛ, ХОТГОР, НИЖИГ ЦАВ ТОЛГОД	ХӨРС
ЗАРИМДАГ ЦӨЛИЙН БА ЦӨЛИЙН ХӨРС				ДАВСАРХАГ, НАМГИЙН, ТАТМЫН БА САЙРЫН ХӨРС					
			Цөлэрхэг хээрийн бор (зөлтөгмөц)				Цөлийн бор саарал (зөлтөгмөц)		Уусуул хэлбэрийн мара
			Цөлэрхэг хээрийн мараалаг бор				Цөлийн мараалаг бор саарал		Нугам мараалаг мара
			Цөлэрхэг хээрийн нимсэн бор				Цөлийн зөлтөгмөц бор саарал		Хужир мара
			Цөлэрхэг хээрийн салхиар үүссэн хүнмэл үетэй бор				Цөлийн нимсэн бор саарал		Нугалт-намгийн цэвдэг
			Цөлэрхэг хээрийн үлдээл нуураараг шингэжээ бор				Хэт хуурай цөлийн энгийнессэ зөлтөгмөц борзон хөрс		Нугалт-намгийн дэвсгэрлэг цэвдэг
			Хээржүү цөлийн бор				Хэт хуурай цөлийн зөлтөгмөц нимсэн борзон хөрс		Нугалт-намгийн дэвсгэрлэг
			Хээржүү цөлийн мараалаг бор				Нугалт-бор		Намгийн цэвдэг
			Хээржүү цөлийн нимсэн бор				Мараалаг нугалт-бор		Татмын
			Сүл хөгжилтэй эгсэн бор				Шалархуу		Сайрын (гүйцэд тогтвормоц)

103 ХӨРС-ГАЗАРЗҮЙН МУЖЛАЛТ
Масштаб 1:12 000 000




ХӨРС-БИО УУР АМЬСГАЛЫН ИХ МУЖУУД	ХӨРС-БИО УУР АМЬСГАЛЫН МУЖУУД	БҮСШИЛҮЙН ХЭВШИНЖҮҮД		
		Өргөргийн	Холмог	Өндрийн
I ТӨВ АЗИЙН	A ХАНГАЙН	Бус Хүрэн хөрсний Тойрог: 1, 2, 3	Хангайн мужийн Дэд мужууд I Орхон-Туулин Тойрог: 14, 15 II Моговийн Өмнөд хэсгийн Тойрог: 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23	Хилсэд-Хэнтийн a) Умардын b) Өмнөдийн Тойрог: a) 41, 42, 43 b) 44, 45, 46, 47, 48, 49, 50, 51, 52, 53, 54
		Бус, дэд бүсүүд Цагаар хүрэн хөрсний Тойрог: 4, 5 Цөлөрхөг хээрийн бор хөрсний Тойрог: 6, 7 Хээржүү цөлийн бор хөрсний Тойрог: 8, 9 Цэлийн бор саарал хөрсний Тойрог: 10, 11, 12, 13	Говийн мужийн Дэд мужууд III Их нууруудын хөтгөр Тойрог: 24, 25, 26, 27, 28 IV Нууруудын хэлдэл Тойрог: 29, 30 V Говь Алтайн Тойрог: 31, 32, 33, 34, 35, 36, 37 VI Алтайн өвөр говийн Тойрог: 38, 39	Алтайн Тойрог: 55, 56, 57 Говийн Тойрог: 58
II ЗУУНГАРЫН			Зүүнгарын их мужийн Тойрог: 40	


ТОЙРГУУДЫН ХӨРС

Тойрогын дугаар	Хөрс	Тойрогын дугаар	Хөрс	Тойрогын дугаар	Хөрс	Тойрогын дугаар	Хөрс
1	$H_2 + H_3 + K_0$	5	$H_2 + H_3 + K$	9	$CB_2 + CB_3 + C_0 + P$	12	$CB_2 + CB_3 + C_0 + P$
2	$H_2 + H_3 + H_4 + C_0$	6	$CB_2 + CB_3 + CB_4 + C_0$	10	$CB_1 + CB_2 + CB_3 + CB_4 + C_0 + P$	13	$CB_1 + CB_2 + C_0$
3	$H_2 + H_3 + K_0 + C_0$	7	$CB_2 + CB_3 + C_0 + P$	11	$CB_2 + CB_3 + C_0 + P$		
4	$H_2 + H_3 + H_4 + K$	8	$CB_2 + CB_3 + CB_4 + C_0$				
14	$H_2 + H_3 + H_4 + T_0$	21	$H_2 + H_3 + H_4 + H_5 + K_0$	28	$H_2 + H_3 + H_4$	35	$CB_2 + CB_3 + C_0 + P + S$
15	$H_2 + H_3 + H_4 + H_5 + K_0$	22	$H_2 + H_3 + H_4 + C_0 + P$	29	$H_2 + H_3 + H_4 + C_0 + S$	36	$CB_2 + CB_3 + C_0 + P + S$
16	$H_2 + H_3 + C_0 + C_1$	23	$H_2 + H_3 + H_4 + T_0 + P$	30	$CB_2 + H_2 + P + C_0$	37	$CB_2 + CB_3 + CB_4 + C_0 + S$
17	$H_2 + H_3 + H_4 + H_5 + H_6 + C_0 + P$	24	$H_2 + CB_2 + K_0 + H_1 + C_0 + P + S$	31	$CB_2 + CB_3 + CB_4 + H_2 + C_0 + P$	38	$CB_2 + CB_3 + C_0 + S$
18	$H_2 + H_3 + H_4 + H_5 + K_0 + H_1$	25	$H_2 + CB_2 + CB_3$	32	$CB_2 + CB_3 + C_0 + P + S$	39	$CB_2 + CB_3 + C_0 + S$
19	$H_2 + H_3 + H_4 + H_5 + K_0$	26	$H_2 + H_3 + H_4 + CB_2 + CB_3 + P + S$	33	$CB_2 + CB_3 + CB_4 + H_2 + S$	40	$CB_2 + CB_3 + CB_4 + H_2 + P + S$
20	$H_2 + H_3 + H_4 + H_5 + H_6 + C_0$	27	$H_2 + H_3 + H_4 + C_0$	34	$CB_2 + C_0 + S$		
41	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6 + G_7 + G_8 + G_9 + G_{10} + B_0$	46	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6$	51	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6 + H_2 + K_0$	56	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6 + G_7 + G_8 + G_9 + G_{10} + CB_2$
42	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6$	47	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6 + G_7 + G_8 + G_9 + G_{10} + H_2 + K_0$	52	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6 + G_7 + G_8 + G_9 + H_2 + K_0$	57	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6 + G_7 + G_8 + G_9 + G_{10} + CB_2$
43	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6 + G_7$	48	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6 + G_7 + G_8$	53	$G_2 + G_3 + G_4 + G_5 + H_2 + K_0$	58	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6 + G_7 + G_8 + G_9 + G_{10} + CB_2$
44	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6 + G_7 + G_8$	49	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6 + G_7 + G_8 + G_9$	54	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6 + H_2 + K_0$		
45	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6 + G_7 + G_8 + G_9 + G_{10} + H_2 + K_0$	50	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6 + G_7 + G_8 + G_9 + G_{10}$	55	$G_2 + G_3 + G_4 + G_5 + G_6 + G_7 + G_8 + H_2 + K_0$		


ХӨРСНИЙ ӨНДРИЙН БҮСШИЛҮЙН ХЭВШИНЖҮҮД



МОНГОЛ ОРНЫ ТАЛАРХАГ НУТГИЙН (тал, нам уулс, жижиг цав толгодын) ХӨРСНИЙ ТАЛБАН ХАРЬЦАА




104 ГОЛЛОХ ХӨРСНИЙ ЗҮСЭЛТ




105 БАЙГАЛИЙН ҮНДСЭН БҮСИЙН ХӨРСӨН БҮРХЭВЧИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН (ХЭСЭГЧЛЭН ҮЗҮҮЛСЭН НЬ)

ОЙТ ХЭЭР



ХУУРАЙ ХЭЭР



ТАЛ ГАЗРЫН ХӨРС

- К₁ Нунтаг карбонатлаг нилсэн хар хурим
- К₂ Нунтаг карбонатлаг дунд зэрэг зузаан хар хурим (мүүгүй дотор доод эсвэл нугаргал)
- К₃ Нунтаг карбонатлаг нилсэн хурим
- К₄ Нунтаг карбонатлаг дунд зэрэг зузаан хурим
- К₅ Нунтаг карбонатлаг дунд зэрэг зузаан, дээрээс буцалдаг хурим
- К₆ Нунтаг карбонатлаг үймэл маралаг хурим
- К₇ Нунтаг карбонатлаг цооног хурим
- К₈ Нунтаг карбонатлаг эвдрэл орсон цооног хурим
- С₁ Цөлөрхөг-хээрэн бор (галтэмнэгүй)
- С₂ Эвдрэл орсон цөлөрхөг-хээрэн бор
- С₃ Салхиар гарим хүчлэг үетэй цөлөрхөг-хээрэн бор
- С₄ Хээржүү-цөлийн бор
- С₅ Салхиар үүссэн хүчлэг үетэй хээржүү-цөлийн бор
- С₆ Хээржүү-цөлийн маралаг бор
- С₇ Цөлийн суя хөгжилтэй бор саарал (галтэмнэгүй)
- С₈ Цөлийн бор саарал (галтэмнэгүй)
- С₉ Цөлийн хөгжилтэй бор саарал
- Ч₁ Удаан хөлдөг нугам-харшорон
- Н₁ Нунтаг карбонатлаг хэврэг нугам-хурим
- Н₂ Нунтаг карбонатлаг хэврэг буй нугам-хурим
- К₁ Нунтаг карбонатлаг нугам-хурим
- К₂ Нунтаг карбонатлаг усалдмал нугам-хурим
- К₃ Нунтаг карбонатлаг үймэл маралаг нугам-хурим
- К₄ Нунтаг карбонатлаг сүлжлээр маралаг нугам-хурим
- С₁ Цөлийн нугам-бор
- С₂ Сайрын бор
- С₃ Сайрын карбонатлаг бор
- С₄ Сайрын маралаг бор
- С₅ Сайрын суя толгойрсон
- Л₁ Удаан хөлдөг нугам маралаг
- Л₂ Удаан хөлдөг нугам маралаг
- Л₃ Удаан хөлдөг нугам-маралаг маралаг
- Ст Шалархуу
- Тк Шал
- Сн Марал
- Сн₁ Маралаг марал
- Сн₂ Нугам марал
- Н₁ Нугам маралаг марал (нилсэн ба дунд зэрэг зузаан)
- Суя хөгжилтэй, их сайр чулуулаг хөрс

УУЛЫН БА НАМ УУЛАРХАГ НУТГИЙН ХӨРС

- Г₁ Уулын ширээт-талын гүйцээг цэвэрлэлтэй
- Г₂ Уулын нугам-ойн гүйцээг хөлдөгтэй
- Г₃ Уулын ойн удаан хөлдөг
- Г₄ Уулын карбонатлаг дунд зэрэг зузаан ба нилсэн харшорон (мүүгүй дотор доод эсвэл нугаргал)
- Г₅ Уулын нунтаг карбонатлаг хар хурим
- Г₆ Уулын нунтаг карбонатлаг их сайр чулуулаг, нилсэн хурим
- Г₇ Уулын нунтаг карбонатлаг дунд зэрэг зузаан хурим
- Г₈ Уулын нунтаг карбонатлаг нилсэн цооног хурим
- Г₉ Уулын цөлөрхөг-хээрэн бор

ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

- Элсэн
- Элсэнцэр
- Элсэн дунд ба хөнгөн шавранцар
- Шавранцар
- Элсэн ба элсэнцэр хөрс эзэлнэг
- Элсэнцэр ба элсэн хөнгөн шавранцар хөрс эзэлнэг
- Хөнгөн шавранцар ба шавранцар хөрс эзэлнэг
- Шавранцар ба хүнд шавранцар хөрс эзэлнэг
- Хүнд шавранцар ба шавранцар
- Ялгарч тархалгүй элс-сайрын хурдас дээрх (50-100 см гүнд) шавранцар
- Хавранцар хурдас дээрх (30-50 см гүнд) шавранцар

ХАТУУ СУУРЬ ЧУЛУУЛАГ ДЭЭРХ ХӨРС

- ++ Хүчлэг талст чулуулаг дээрх
- xx Суурлаг чулуулаг дээрх
- ++ Хүчлэг талст ба хувирил чулуулаг дээрх
- ^ Хувирил чулуулаг ба занор дээрх

ХӨРСНИЙ БУС ЗҮЙЛ

- Элс, хайраг-бул чулуу бүхий сайрын гулбарал
- Ил гарсан кумул чулуу
- Хай асан, чулуун өвсгөр
- Ил гарсан удаан элсэн чулуу
- Элс

ХӨРСӨН БҮРХЭВЧИЙН БҮТЭЦ


Бүтцийн хэлбэр	Бүтцийн хэлбэр				
	Элсний	Усаар үүссэн	Усаар үүссэн баялаг	Эвдрэлийн	Салхиар үүссэн
Элсний-хуримтлалын	[Pattern]	[Pattern]	[Pattern]	[Pattern]	[Pattern]
Хуримтлалын	[Pattern]	[Pattern]	[Pattern]	[Pattern]	[Pattern]
Салхиар үүссэн	[Pattern]	[Pattern]	[Pattern]	[Pattern]	[Pattern]
Сайрын	[Pattern]	[Pattern]	[Pattern]	[Pattern]	[Pattern]

106 ХӨРСНИЙ АГРОҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (БҮДҮҮВЧ)


ОЙТ ХЭЭР



ХУУРАЙ ХЭЭР




ЦӨЛӨРХӨГ ХЭЭР



ХӨРСНИЙ АГРОҮЙЛДВЭРЛЭЛИЙН БҮЛЭГ

- Тархалд тохиромжтой хөрс
- Тархалд ага цоог тохиромжтой хөрс
- Хөлдөг тохиромжтой хөрс зарим газар үндсэн сайжруулалт хийх шаардлагатай
- Бэлчээр тохиромжтой хөрс
- Бэлчээр тохиромжтой, усалдмал тохиромжтой ага цоог шилжээг бэлчээг
- Бэлчээр тохиромжтой хөрс, бэлчээр тохиромжтой дундаж хэмжээнд бэлчээг шаардлагатай
- Бэлчээр тохиромжтой хөрс, бэлчээр тохиромжтой баялаг шавранцартай
- Уулын бэлчээр
- Бэлчээр ага цоог тохиромжтой ойн хөрс
- Марлааг бэлчээр
- Давсаргаг бэлчээр
- Хөндөг аж ахуйд тохиромжгүй ага цоог буюу ний уулын бэлчээр
- Хөндөг аж ахуйд тохиромжгүй газар буюу бэлчээр ага цоог тохиромжтой хөрс

107 ДАВСАРХАГ ХӨРСНИЙ ТАРХАЛТ, ХИМИЙН ШИНЖ
Масштаб 1:6 000 000



ДАВСАРХАГ ХӨРС 10%-ИАС БАГА ТАЛБАЙГ ЭЗЭЛДЭГ НУТАГ


Байгалийн нлгөөр	Хөрсний давсжилтын хиймэл гол шинж
Ойт хээр, хээр	Шуулагас
Хуурай ба цөлөрөө хээр	Шүтлэг ба саармаг (хлорог ба сульфатлаг)
Зоримдг цөл, цөл	Саармаг-сульфатлаг (сөлгөмтэй) Хортой давс нь голдуу хөрсний найрлагадтай
Гальч татаж	Шүтлэг
Уулархаг нутаг	
Өндөр уул, ойт хээр	Хортонгоо хүчирхэг ба суурагч чулуулаг гарснаар шүтлэг-шүтлэг, өргийн давсараа хурдан их өрсөн гальч-саармаг
Хуурай хээр	
Цөл	

B^{III} - Маралаг хурин
 M^{II} - Маралаг нугал-хурин
 D^{II} - Нугал давсархаг
 C^{II} - Уууул хэлбэрлэлийн марга
 C^I - Нугал марга
 C^{II} - Марга
 C^I - Шалархуу ба шал
 C^{II} - Шалархуу хэлбэрлэлийн марга
 C^I - Хээрхүү цэлийн гальчлалтай бор
 C^{II} - Цэлийн маралаг бор сөөрөл
 C^I - Цэлийн гальчлалтай бор сөөрөл
 C^{II} - Хам хуурай цэлийн нэгдэлээр гальчлалтай борзон хөрс
 C^I - Хам хуурай цэлийн бага гальчлалтай нэгдэл борзон хөрс
 C^{II} - Хам хуурай цэлийн бага гальчлалтай нэгдэл борзон хөрс
 B^{III} - Нугал-маргац давсархаг

ДАВСАРХАГ ХӨРС 10%-ИАС ИХ ТАЛБАЙГ ЭЗЭЛДЭГ НУТАГ


Хиймэл шинж (Давсны найрлага)	Хөрсний төмөр-фосфор тэмдэг	Давсархаг хөрсний эзлэх хувь		
		50%-иас илүү	10-50%	10-50%
		Их	Дунд зэрэг	Их буур
Хуураг ба хуурай хамттай	C ^I , C ^{II} , C ^{III}	■	■	■
Сульфатлаг-хлорог ба хлорид сульфатлаг, хлорог ба хлорид найрлага илүү шүтлэг шүтлэг	C ^I	■	■	■
Сульфатлаг (сөлгөмтэй), нэгдэлээр их гальчлалтай нэгдэлээр бага гальчлалтай	C ^{II}	■	■	■
Дунд давсархаг гальчлалтай	C ^I , C ^{II}	■	■	■
Хөрс өөр давсархаг давсархаг (хлорог-сульфатлаг, сульфатлаг-хлорог)	C ^I , C ^{II}	■	■	■
	C ^{II} , C ^{III}	■	■	■

108 ЭХИЙН ГОЛЫН БАЯН БҮРДИЙН ХӨРС



Нугал хөрс
 M^{II} - Марга бодот нугал-нугал
 D^{II} - Гүн нэгдэлээр маргал нугал
 D^{III} - Марга шүтэй маргал нугал
Марга
 C^I - Усартал хэлбэрлэлийн марга (Эзэрэ хлорог, доороо сульфатлаг, давс хамгийн их хуримтлагдсан давхарга нь илүү шүтлэг)
 C^{II} - Дэлхийн ижил найрлагатай марга (үлэм давсгүй буй)
 C^{III} - Дөлс хуримтлагдсан давхарга нэгдэлээр усан хэлбэрлэлийн марга (голдуу хлорог)
 C^{IV} - Усартал хэлбэрлэлийн марга (голдуу хлорог)
 C^V - Усартал хэлбэрлэлийн марга (сульфатлаг-хлорог ба хлорид-сульфатлаг)
 C^{VI} - Усартал хэлбэрлэлийн марга (голдуу сульфатлаг, давс хамгийн их хуримтлагдсан давхарга нь илүү шүтлэг ба шүтлэг)
 C^{VII} - Усартал хэлбэрлэлийн марга (голдуу сульфатлаг)
 C^{VIII} - Шалархуу шүтлэг марга (голдуу сульфатлаг)
 C^{IX} - Гүн нэгдэлээр нугал хэрэглэн бээр үүссэн марга (илүү шүтлэг шинж бүхий хлорог)
 C^X - Усарталтай шалбар үүссэн марга (голдуу сульфатлаг-хлорог)
 C^{XI} - Чулуулагийн гаралтай марга
Нугал-цэлийн хөрс
 T^I - Марга бодот нугал-цэлийн (түүний дотор усартал хэлбэрлэлийн үзэмж шүтлэг)
 T^{II} - Марга-нугал шалархуу
 T^{III} - Нугал-цэлийн эхлэн хөрс
 T^{IV} - Цэлийн ба үе үе усан алтардаг сайрын хөрс
 T^V - Шалархуу
 T^{VI} - Програмын давсгаар хамт голдуу цэлийн гальчлалтай бодот борзон
 T^{VII} - Өндөрлөг төст гарам хамт голдуу цэлийн гальчлалтай шалбар борзон
 T^{VIII} - Хамт голдуу цэлийн их эзэрсэн гальчлалтай борзон
 T^{IX} - Хамт голдуу цэлийн их эзэрсэн борзон
 T^X - Сайрын (програмын ба өндөрлөг төст)
 T^{XI} - Сайрын (бага бээр дунда)
Элс
 S^I - Элс
 S^{II} - Их гарам уулын чулуулаг
 S^{III} - Усарталтай маргалчлалтай шалбар

109 ХӨРСНИЙ ЭВДРЭЛ
Масштаб 1:6 000 000



V^I - Эвдрэл өгсө цөөн алтарсан хөрс
 V^{II} - Эвдрэл өгсө бодот хөрс
 V^{III} - Эвдрэл ба эвдрэл өгсө хөрс
 V^{IV} - Зарим эвдрэл эвдрэл, ус сэлхийн эвдрэл өгсө хөрс
 V^V - Ус сэлхийн эвдрэл өгсө хөрс
 V^{VI} - V^V - V^{IV} - V^{III} - V^{II} - V^I

V^I - Хүчтэй хийсгэлт өгсө хөрс
 V^{II} - Элсээр хүчтэй хөрс
 V^{III} - Элс бүхий хийсгэлт хөрс
 V^{IV} - Хийсгэлт өгсө бүхий сайрын эвдрэлтэй хөрс
 V^V - Хүчтэй эвдрэлтэй гальчлал
 V^{VI} - Элс

УРГАМАЛШИЛ

Монгол орон Палеарктикийн салбар болох эрс тэс эх газрын шинж бүхий Дорнод Сибир-Төв Азийн нутгийн төв хэсэгт нь байрладаг учир ургамалшлын хувьд хосгүй өвөрмөц байдалтайгаас гадна зэргэлдээх Тураны цөл, Казахстаны хээр, Дундад Азийн өндөр уулстай ургамал-газарзүйн талаар холбоотой юм. Энэ бүлгийн гол зураг болох ургамалшлын 1:3 000 000 масштабтай зурагт янз бүрийн ургамлын бүлгэмдэл, тэдгээрийн бүрэлдэхүүний орон нутгийн онцлог болон газарзүйн тархалтын нь зүй тогтлыг байгаль орчны бусад хэсгийн өөрчлөлттэй холбож харуулсан байна. Зургийн таниурыг бус нутаг-хэвшинжийн зарчмыг баримтлан гурван шатлалтайгаар боловсруулав. Хамгийн том нэгдүгээр шатлалын өнгөт тэмдгүүд нь тал нутагт бол өргөргийн бүсээр, уулархаг нутагт бол өндрийн бүслүүрээр ургамал бүрхэвч хэрхэн өөрчлөгдөх байдлыг үзүүлнэ. Зураглаж буй ургамалшлын бүлгүүд геоморфологийн ямар нөхцөлд байрласныг хоёрдугаар зэргийн шатлал, муж нутгийн хувьд хаана хамаарахыг гуравдугаар зэргийн шатлалын нэр тус тус илэрхийлнэ. Зургийн тайлбарт юуны өмнө зонхилох ургамлын зүйлүүдийг нэрлэснээс гадна тархалт ховортой боловч ургамлын бүлгэмдлийн газарзүйн онцлог, экологийн тодорхой нөхцөлийг илтгэдэг, ургамал-газарзүйн хувьд чухалд тооцогдох зарим зүйл ургамлыг мөн оруулсан байна.

Монгол орныг ургамлын талаар нэлээд сайн судалсан юм. Тус орны ургамалшлын зураг болон энэ бүлэгт орсон бусад зургийг зохиход БНМАУ-ын ШУА, ЗСБНХУ-ын ШУА-ийн Монгол-Зөвлөлтийн хамтарсан биологийн экспедицийн бүрэлдэхүүнд оролцон ажилласан монгол, зөвлөлтийн эрдэмтдийн судалгааны эх материал, БНМАУ-ын ургамалшлын 1:1 500 000 масштабтай зураг (1979 он), БНМАУ-ын ой-ургамалшлын мөн масштабын зургийг (1983 он) гол үндэс болгов.

Ургамалшлын зургийн үндсэн дээр Монгол орны ургамал-газарзүйн мужлалтыг шинээр боловсруулжээ. Мөн ой үүсгэгч гол модны тархалт, ойжилт ба ой-ургамалшлын мужлалтын бүдүүвч, зонхилох болон онцлог ургамлын зүйлүүд, ховор ба унаган ургамал, жимс-жимсгэнэ, хүнсний ба эхийн ургамлын тархацын зургууд энэ бүлэгт орсон юм.

Тус оронд уулархаг хотгор гүдгэр зонхилж өргөргийн бүсийн зүй тогтлыг ихээхэн ээдрээтэй болгодог боловч тал газар болон уулсын хааяаар, ялангуяа тус орны төв ба дорнод хэсэгт ургамлын бүлгэмдлүүд хойноосоо урагшаа тодорхой бүсийн дарааллаар ээлжлэн солигддог ажээ. Ууланд бол ургамалшил өндрийн бүслүүрээр ялгарна. Өндөр уулын ургамалшлын ургамал-газарзүйн хоёр хэвшинжид хамааруулав. Үүнд: 1) Бүтэц, бүрэлдэхүүн, гарал үүслээрээ Сибирийн өмнөд хэсгийн ян сарьдагийнхтай төстэй сөөг, сөөгөнцөр, өвслөг ургамал, хаг-хөвдөт ба хөвдөт тундр (өмнөд сибирь-монголын умард хэсгийн хэвшинж); 2) Азийн халуун бүсийн гадна оршдог эх газарлаг шинжтэй өндөр уулст нийтлэг бушилз, улажит хүйтсэг ургамалтай өндөр уулын нуга (монголын хэвшинж) эдгээр болно.

Монгол оронд ой мод гол төлөв ууланд ургадаг. Тэгэхдээ Евразийн ойн мужид хамаарах уулсын хажуу бүхэнд нь жигд сайн илэрсэн ойн бүслүүр байдаг бол Евразийн хэсгийн мужид хамаарах уулст ойн бүслүүр зөвхөн уулын ар хажууд л үзэгдэнэ. Ой бүрдүүлэгч үндсэн төрлийн мод нь сибирь шинэс ойн Харин Хэнтэйн зүүн хэсэгт бол дагуур шинэс зонхилно. Хушин ой Хэнтэйд байдагс гадна Хангай, Хөвсгөлд бага бага талбайд тархаж ян сарьдаг өөд шилжих сарьдаг орчмын тармаг ойн зурвасыг үүсгэдэг байна. Хусан ой ихэвчлэн хоёрдогч гаралтай буюу шилжүүст ойт хөлж оронд нь ургадаг. Монгол орны уулын ой Сибирийн ойн байнгын нөлөөн дор бүрэлдэн тогтсон бөгөөд тархалтынхаа байдлаар Сибирийн өмнөд-монголын умард хэсгийнх, монголын умард хэсгийнх гэж хоёр янз байна. Тус орны ой дээд, доод ташингын ургамлын бүрэлдэхүүн, модны чансаа, нөвц болон аж ахуйн бусад чухал үзүүлэлтээрээ ялгаатай өндрийн бүслүүрийн 4 хэвшинжид хуваагдана. Үүнд: 1) Сарьдаг орчмын сийрэг ургасан хушин ба хуш-шинэсэн ой, мөн тармаг ой. Энд хаг-хөвдөт (ногоон ба срагнам хөвд), сөөгөнцөрт (тэрэлж, зожир өвс), сөөгт (тегрөг навчит хус, бургас) ташинга их үүрэгтэй байна. 2) Уулын тайгын ой. Энд шинэс, хуш хоёр нэлээд өтгөн, өндөр ургахын хамт зарим газраар гацуур, жодоо холилдсон ургана. Хөвдөлг, өвслөг болон сөөгт ташингын бүрэлдэхүүнд нь сэрүүн бүсийн ургамлын зүйлүүд (бадаан, нэрс, умардын ягжаа, ногоон хөвд) голлон оролцоно. Хангай, Хөвсгөлийн уулст бол энэ бүслүүрт «хуурмаг тайга» гэж ойролцоогоор нэрлээд байгаа хуурай хөвдөт өвөрмөц маягийн шинэсэн ой нийтлэг юм. 3) Тайга орчмын өвслөг ой. Уулын ойн бүслүүрийн доод хэсэг болох энхүү шинэс, хусан ойд өвслөг ургамлын нь бүрэлдэхүүнд нугат ойн алаг өвс (шилгэлэй, цахилдаг, гивц) элбэг байна. 4) Уулын хөндийн хэврэнэс нарсан ой. Өвслөг ургамлын нь бүрэлдэхүүнд хэврийн алаг өвс, шарилж, үетэн оролцоно.

Тус орны байгаль ерөнхийдөө гандуу шинжтэй учраас хэврийн ургамалшил асар их талбайг эзэлнэ. Хэврийн ургамалшил талархаг газраар жижиг бутлаг шинэст хялгана, хазаар өвс, дааган сүүл, ерхөг, ууланд бол ботууль, биелэг өвсөөс голцлон бүрдэнэ. Харин тус орны дорнод хэсгийн хээр үндэслэг ишт (нангад түнэг) ба бутлаг алаг өвст (зүр өвс) өвөрмөц хэвшинжийн ургамалтай юм.

Хэврийн ургамалшил зүйлийн бүрэлдэхүүн, бүтэц, ашиг шимээр ялгаатай. Хойноосоо урагшаа нугын хээр, жинхэнэ хээр, цөлжүү хээр дараалан оршино. Төв Азийн цөлийн хойт захаар үлэмж хуурайсаг шинжтэй, ихэнхдээ Төв Азийс гөрлөлт унаган ургамал болох жижиг өдлөг хялгана, таана, заримдаг сөөгөнцөрөөс бүрдсэн өвөрмөц цөлийн хээр үргэлжинэ. Тэрчлэн өрнөөс дорно зүг рүү хэврийн ялгаа ажиглагдах бөгөөд энэ нь тус орны янз бүрийн нутагт хэврийн ургамлын аймаг өөр өөр байдагс тодорхой юм.

Өндөр уулын хүйтсэг алаг өвс-бутлаг үетэнт хээрт улаж, бушилз, шарилж, алаг өвс (ортууз, ажгана, гингэнэ)-ний өндөр ууланд холидсон зүйлүүд элбэг байхын хамт тэдгээрийн олонх нь дэгнүүл байдлаар төлбөтөн ургадаг байна.

Алаг өвс-үетэнт ба үетэн-алаг өвст нугархаг хээр Хянганы орчимд ихээхэн талбай эзлэн тархдаг бол Хэнтэй, Хангайн уулст баялаг алаг өвст жинхэнэ хэврийн дунд хэсэг хэсэгээр тохиолдоно. Хянганы орчмын хээрт хамгийн чийгсэг үетэн, улаж (байганын ба Сибирийн хялгана, шеллийн бутнуур, зогдор улаж) болон манжуурын зүйл олон оролцсон алаг өвс зонхилно.

Алаг өвс-бутлаг үетэнт, бутлаг алаг өвст жинхэнэ хээр өргөн тархалттай. Хангай, хэнтэй, монгол алтайн уулын хээр бол их төлөв ленийн ботууль, биелэг өвс, дааган сүүлээс бүрдсэн жижиг бутлаг үетэнт хээр бөгөөд уулын хэврийн алаг өвсөөр баялаг юм. Алтайн бутнуур, малтууш баганалж, цэгцүүхэй, навчит тавилгана зэрэг тус орны хувьд «өрнөдийн» гэгдэх олон зүйл ургамал зонхилсон (монголын өрнөд, дорнод казахстан-монголын өрнөд хэвшинжийн) баялаг алаг өвс-бутнуурт хээр зөвхөн Хан Хөхийн нурууны арээр тааралдана. Хянганы орчмын болон Хэнтэйн зүүн талын хээр бол дагуур-монголын дорнод, монгол-дорнод сибирь буюу азийн дорнод хэсгээр тархалттай (япон согоовор, дагуурын хошоонбут, жиргэрүү, ацан цахилдаг зэрэг) ургамлын зүйлээс бүрдэнэ. Зүр өвст болон алаг өвс-зүр өвст хээр энд бас нийтлэг юм.

Бутлаг үетэнт болон үндэслэг ишт үетэнт хуурай хээр тус орны төв ба дорнод хэсгийн тэгш тал, ухаа толгодорхог нутагт хамгийн олон хэвшинжтэй байдаг. Монгол хэвшинжийн хээрт жижиг бутлаг үетэн-шивээт хялганат, шарилж-жижиг бутлаг үетэн-шивээт хялганат, мөн крыловын хялгана (арай хойгуурх хээрт бол байганын хялгана, элсэрхэг хөрстэй газраар бол том хялгана), хазаар өвс, дааган сүүл, ерхөг голцосон харгана-жижиг бутлаг үетэн-шивээт хялганат хээр хамаарна. Монголын өрнөд болон дорнод казахстан-монголын өрнөд хэвшинжийн хээрт (Увс нуурын хотгор, Хангайн баруун захын уулст) хар тэнгис орчим — казахстаны (валлийн ботууль, шивээт хялгана), дундад ази-казахстаны (киргиз хялгана) болон бусад зүйлийн ургамал оролцдог буюу зарим тохиолдолд зонхилж байдагсгаар онцлог юм. Иймэрхүү хээрт бас лавай тогтмол оролцоно. Дагуур-монголын дорнод хэвшинжид жижиг бутлаг үетэн-хялгана-хиагт, хиаг-хялганат хээр хамаарна. Монгол алтай, говь алтайн хэвшинжийн уулын хээрт саман ерхөг зохино.

Заримдаг сөөгөнцөр-бутлаг үетэнт болон бутлаг үетэнт цөлжүү хэврийг Монгол орны хувьд анх удаа энэ зурагт ялган үзүүлэв. Ийм хээр, казахстаны хэврийн нэгэн адил олон янзын ургамлаас бүрдэх буюу ургамалшилд нь хэврийн үетэн болох крыловын хялгана, ерхөг, хазаар өвс, түүнчлэн клеменцийн хялгана, говийн хялгана, сайрын хялгана зонхилно. Говийн хойт захаар хазаар өвс-шивээт хялгана-жижиг өдлөг хялганат, өдлөг хялгана-шивээт хялганат, аг-хазаар өвс-өдлөг хялганат болон чулууцаг алаг өвс-өдлөг хялганат (говийн умард хэсэг-монгол хэвшинжийн) хээр түгээмэл юм. Увс нуурын хотгор болон Монголын баруун өмнөд хэсгийн цөлжүү хэврийн бүрэлдэхүүнд умард тураны, умард туран-зүүнгарын, казахстаны зүйлүүд болох таар, шренкийн шарилж, нарийвтар шарилж, эмээгтүүр хялганат, Монгол алтайн уулын хээр тэр нутагтаа унагандуу шинжтэй неаскийн хялгаас бүрэлддэг.

Заримдаг сөөгөнцөр-бутлаг үетэнт цөлийн хээрт заримдаг сөөгөнцөр-өдлөг хялганат, таана-өдлөг хялганат бүлгэмдлүүд зонхилж багуур, борлоозой, шарилж мэтийн төв азийн олон янзын заримдаг сөөгөнцөр оролцдог ажээ. Говийн баруун хойт хэсгийн хэвшинж нь өдлөг хялгана дотроос сайрын хялгана голлож шарилж лууль мэтийн зарим унагандуу ургамалтай байдагсгаар онцлог юм. Элстэй газраар шарилж, харгана, үетэнт бүлгэмдэл ургана. Баруун Хуурайн хотгорт нарийвтар шарилж-сайрын хялганат, таар-сайрын хялганат зүүнгарын хэвшинжийн хээр тархана. Дорноговийн хэвшинжийн цөлийн хээрт бор бударгана, гурвалсан борлоозой ихээхэн үүрэг гүйцэтгэдэг.

Цөлийн ургамалшил умард туран-зүүнгарын, говийн гэсэн ургамал-газарзүйн хоёр хэвшинжид хамаарна. Нэг дэх хэвшинжийн цөл Монгол орны зөвхөн баруун урд (Баруун Хуурайн хотгорт) болон хойт хэсэгт (Увс нуурын хотгорт) тохиолдоно. Тус оронд зонхилон тархалттай нь говийн хэвшинжийн цөл юм. Энэ цөл зуны хур бороо ихтэй үед урлаж хөгждөг нэг нэгт ургамал болон сөөг элбэгтэйгээс гадна зарим зүйлийн шарилж, эфемероид ургамал байдаггүйгээрээ умард туран-зүүнгарын цөлөөс ялгаатай юм. Заг, улаан бударгана, багуурт эшил энд хамгийн дэлгэрмэл байдаг. Хойноосоо урагшаа үетэн-заримдаг сөөгөнцөрт цөл заримдаг сөөгөнцөрт, сөөгт цөлөөр солигдож бүр урдуураа хэт гандуу цөлд шилжинэ.

Үетэн-заримдаг сөөгөнцөрт цөлд заримдаг сөөгөнцөр зонхилохын зэрэгцээгээр таана, говийн хялгана чухал үүрэгтэй байдаг. Умард говийн цөл бол үетэн бүхий багуурт, өдлөг хялгана-борлоозойт (сөөгөн борлоозойт) цөл юм. Их нууруудын хотгорт сайрын хялгана оролцсон говийн баруун хойт хэвшинжийн багуурт цөл тархах бөгөөд сөөгөн лууль, горчакосын сэдэргэн зэрэг унагандуу зүйлүүд ургадаг нь энэ хэвшинжийн нэг өвөрмөц тал юм. Говийн дорнод хэсэгт л зөвхөн элстэй газраар өдлөг хялгана-борлоозойт цөл, сөөгт (коржинскийн болон улаан харганат) цөл, цаа толгодоор модлог бударганат цөл тааралдана. Зүүнгарын үетэн-таарт цөл Баруун Хуурайн хотгор, Увс нуурын хотгор хоёрт ихээхэн дэлгэрчээ.

Заримдаг сөөгөнцөрт ба сөөгт цөлд хт хуурайсаг сөөг, сөөгөнцөр, заримдаг сөөгөнцөр дагнаж ургах бөгөөд олон зүйлийн зонхилгог ургамалтай байдаг онцлогтой. Умард тураны цагаан газрын шарилж оролцсон заг, тээсэгт эшиллийн бүлгэмдэл нь зүүнгарын хэвшинжийн цөлийг бүрдүүлдэг. Өрнөд говийн хэвшинжийн цөл дэлгэрсэн гол нутаг бол Алтайн өвөр говь юм. Тэнд чулууурхаг хөрстэй газраар шармод, элсэнцэр хөрстэй газраар давжаа ба бэсрэг заг голлож ургана. Зэргээгт цөл мөн ихээхэн талбайг хамарна. Дорноговийн хэвшинжийн цөл ургамлын аймаг, экологи, бүлгэмдэл үүсгэгчийн хувьд хамгийн олон янз юм. Тэнд бор бударганат, тогстот, хойрогт цөлүүд бий. Цаа толгодоор нь модлог бударганат цөл, говийн өмнө талын уулст буйлст бүлгэмдэл зонхилно.

Хэт гандуу цөл Алтайн өвөр говьд ихэнх хэсгийг нь эзэлдэг бол Баруун Хуурайн хотгор, Говийн дорнод хэсэгт хотос хонхрын ероол дагаж алаг цоог тархана. Ийм цөлийн бүсэд тэгш төгөрдүү газраар нь дээд ургамал бараг байдаггүй юм. Гэгцхүү цаа толгодын дундах судал, сайруудыг дагаж ургасан армаг тармаг ургамал бүрэлдэхүүнээр нь тухайн цөл нутгийн хэвшинжүүдийг ялгадаг. Бусдаасаа илүү өндөрт орших чулууурхаг тал дундах сайруудаар рөгийн шармод, пржевальскийн зэргээнд, хитир оролцсон заримдаг сөөгөнцөрт бүлгэмдэл зонхилно. Дунд зэрэг өргөгдсөн тал болон уулын билийн элсэнцэр хөрстэй газраар усны хагабар болох төгөрдүү чулууурхаг гадарга, сайр дагаж ургасан заг хоёр хослон оршино. Энэ бол Алтайн өвөр говийн хувьд зонхилох хэвшинжийн нутаг юм. Тус говийн зүүн хэсэгт сайруудаар нь хармаг голлож ургадаг. Хотгор, хонхруудын харьцангуй нам хэсгийг хэрчиг отголсон гүехэн сайраар будраат бүлгэмдэл тархжээ. Зөвхөн Баруун Хуурайн хотгорын сайраар умард тураны зүйл болох навчгүй багуур тохиолдоно. Харин Монголын говийн дорнод хэсгийн хэт гандуу цөлд бол сайр дагаж бор бударгана зонхилон ургана.

Хужир марзтай хотос, хонхор, нуурын хөвөөний давсаг үетэнт, заримдаг сөөгөнцөрт, сөөгт ургамалшил Монгол орны янз бүрийн нутагт өөр өөр шинжтэй байна. Тус орны баруун өмнөд хэсгийн хужир марзтай газраар шорной, ренкийн шарилж, танамал багуур болон голын ширэнгэд ургах хонхот харгана мэтийн жинхэнэ тураны ургамал нэвтрэн орж ирсэн байдаг. Алтайн өвөр говьд загвар хүрээлэгдсэн тооройн сийрэгдүү төгөл, сүхийн ширэнгэ бүхий өрнөд говийн хэвшинжид хамаарах баян бүрд элбэг юм. Говийн хэвшинжид бол голцлон дэрст, шар бударганат, улаан бударганат бүлгэмдлүүд багтана. Говийн дорнод хэсэгт улаан бударганат, шар бударганат бүлгэмдлээс гадна марзтай газраар бор бударгана оролцсон бүлгэмдэл түгээмэл байна.

Голын татмын модлог, сөөглөг, нугын ургамалшил монголын болон Сибирийн өмнөд-монголын умард хэсгийн гэсэн ургамал-газарзүйн хоёр хэвшинжид хамаарна. Монголын хэврийн бүсийн голын татамд давсаг зүйлүүд (дэрс, цахилдаг) зонхилсон нугын бүлгэмдэл, сөөглөг бургасан шугуй нийлэг бөгөөд хааяа тармаг улиасан төгөл ургана. Монголын умард хэсгийн голуудын татамд зүйлийн бүрэлдэхүүнээр баялаг улажит, үетэнт, алаг өвст чийглэг болон намтархаг нуга, мөн олон янзын зүйлээс бүрдсэн сөөгөн ширэнгэ, шинэс голцосон хэсэг хэсэг шилжүүст ой тархмал юм.


Ургамалшлын энэ зураг нь Монгол орны нутгийг Евразийн шилжүүст ойн, Евразийн хэврийн, Афро-Азийн цөлийн гэсэн ургамал-газарзүйн 3 их мужид хамааруулсан ургамал-газарзүйн мужлалтын шинэ бүдүүвчийг зохиох үндэс болсон юм. Хэврийн их мужийг Монгол орны хэмжээнд Дагуур-Монголын уулын ойт хэврийн, Монголын хэврийн, Говийн умард хэсгийн цөлөрхөг хэврийн гэсэн 3 мужид хуваав. Сүүлийн мужид нь цөлжүү хээр ба цөлийн хээр нөврөхөно. Цөлийн их мужийн дотор Зүүнгарын цөл ургамлын аймаг, ургамалшлын хувьд онцгой өвөрмөц шинжтэй учраас түүнийг тусгайд нь нэг муж болгон ялгаава.

Ойн болон ой үүсгэгч моддын зурагт сибирь шинэс, сибирь хуш, энгийн нарс, хавтаг навчит хус гэсэн зонхилогч 4 зүйлийн мод, цөлд бол зайсангийн заг, түүнчлэн тэдгээртэй холилдон ургадаг бусад модлог ургамлын тархалтыг үзүүлсэн юм. Дээр нэрлэсэн голлох модноос гадна сүүлийн жилүүдэд тархацыг нь тогтоосон сибирь гацуур, сибирь жодоо, дагуур шинэсийг мөн зурагт харуулсан болно. Нутгийн өмнөд хэсгийн заган ойн тархалтыг зурагт тэмдэглэхдээ, өндөр нам болон ургалтын нь шинж байдлаар өндөр заг, бэсрэг ба давжаа заг гэсэн 2 бүлэгт хувааж үзүүлсэн байна. Ой-ургамалшлын мужлалтын бүдүүвчид Өвөр Байгалын, Хангайн, Төв Азийн гэсэн ой-ургамалшлын 3 их муж, тэдгээрийн дотор өөр хоорондоо ойн зонхилох бүлгэмдлийн бүрэлдэхүүн, босоо бүслүүрийн бүтэцээр ялгаатай 12 мужийг тус тус ялган харуулав. Ойжилтын зурагт Монгол орны ой бүхий хойт хэсэг, загтай өмнөд хэсгийн 36 км х 36 км талбайтай дөрвөлжин тус бүрд ногдог модлог ургамлын нягт сибиргийг үзүүлэв.


Энэ бүлгийн төгсгөлд унаган ба унагандуу зүйлийн ургамал, зарим ашигт (эмийн ба жимсний) ургамал, мөн ургамал-газарзүйн зүй тогтлын баталгаа болдог зарим чухал ургамлын тархацыг илэрхийлсэн хэд хэдэн зураг оруулжээ. Нэлээд олон зүйл ургамал, ургамал-газарзүйн тодорхой хил хязгаарыг зааглаж өгдөг юм.

112 ОЙ

Масштаб 1:4 500 000





Ой үрсээг зохиох мод	Давхайг мод	Төвөг мод	Модны нэр
[Symbol]	[Symbol]	[Symbol]	Сибирь шилс
[Symbol]	[Symbol]	[Symbol]	Дотор шилс
[Symbol]	[Symbol]	[Symbol]	Хуу
[Symbol]	[Symbol]	[Symbol]	Нарс
[Symbol]	[Symbol]	[Symbol]	Жайр
[Symbol]	[Symbol]	[Symbol]	Галзуур
[Symbol]	[Symbol]	[Symbol]	Хуу
[Symbol]	[Symbol]	[Symbol]	Улааншар
[Symbol]	[Symbol]	[Symbol]	Торбог
[Symbol]	[Symbol]	[Symbol]	Тэнгэр эрчим шилс ба мөдөрхүү аг
[Symbol]	[Symbol]	[Symbol]	Саяр, лавсан саяр аг





114 ОЙ-УРГАМАЛШЛЫН МҮЖЛАПТ

Масштаб 1:2 000 000



113 ОЙЖИЛТ


Масштаб 1:2 000 000




ЗАРИМ УРГАМЛЫН ТАРХАЦ

Масштаб 1:9 000 000


120




122




124




119



121



123



АМЬТНЫ АЙМАГ

Монгол орны амьтны аймаг элбэг баян, төрөл зүйл олонтой. Тус оронд 630 орчим зүйл сээр нуруутан амьтан байдгаас гадна элдэв бүлэг сээр нуруугүй амьтан ч их бий. Монгол оронд байгалийн янз бүрийн бүс, ландшафтын, тухайлбал, ой, хээр, заримдаг цөл, цөл, өндөр уулын тундр болон хад асга, ус орчмын шугуй, сэвсгэр элсний амьтад хөршлөн оршино. Эндэх амьтдын дотор сибирийн тайга, европ хэвшингийн ой, Баруун Ази болон Тураны цөлд өргөн тархдаг амьтад олон бий. Түүний зэргээс зөвхөн Төв ба Зүүн Азийн хээр, цөлд л хязгаарлагдмал оршдог унаган төрөл, зүйлийн амьтан ч цөөнгүй юм.

Монгол орны амьтдын тухай орчин үеийн шинжлэх ухааны мэдлэгийн үндсийг XVIII-XIX зууны оросын жуулчид тавьсан билээ. Одоо үед манай орны амьтны аймгийг БНМАУ, ЗСБНХУ болон социалист бусад орны амьтан судлагчид шинжилж байна. Ялангуяа БНМАУ-ын ШУА, ЗСБНХУ-ын ШУА-ийн Монгол-Зөвлөлтийн хамтарсан биологийн экспедицийн олон жилийн судалгааны дүнд ихээхэн материал хуримталжээ. Энэ судалгааг амьтны аймгийн зүйлийн бүрэлдэхүүн, амьтны газарзүй, эколог, аж ахуйн ба анагаах ухааны ач холбогдлыг судлах зэрэг янз бүрийн чиглэлээр хийж байна. Судалгааны энэ бүх чиглэл тус бүлгийн зургуудад тусгалаа олсон юм.

Амьтны бүлгэмдлийн тархалтыг хөхтөн, шувуу, хоёр нутагтан ба мөлхөгчид, загас, шавьж гэсэн анги бүлгүүдээр төрөлжүүлэн харуулсан цуврал зураг атласын энэ бүлгийн гол хэсгийг бүрдүүлнэ. Эдгээр анги бүлгээр ялгасан бүлгэмдлүүд нь амьтны зүйлийн бүрэлдэхүүн, зонхилгог зүйл, тоо толгойгоор хоорондоо ялгаатай юм. Янз бүрийн төрөл, зүйлийн амьтдын экологийн төлөв байдлыг тодорхойлоход ихээхэн анхаарах. Зурагт хавсаргасан хүснэгтэд зүйл бүрийн амьтны тооны харьцааг үзүүлж, тэдгээрийн байрлал, амьдралынх нь шинж төрхийн онцлогийг товч боловч тэмдэглэсэн болно.

Нөгөө цуврал зурагт ангилал зүйн шинж, хавсарга учир холбогдоор нь бүлэглэсэн хэсэг амьтдын зүйлийн тархалтыг үзүүлнэ. Үүнд шувуу, хөхтөн амьтдын хувьд агнуур олборын холбогдолтой зүйлүүд, хамгаалах шаардлагатай болсон ховор ба унаган зүйлүүдийг ялгажээ. Түүнчлэн хөдөө аж ахуйд хор учруулж болзошгүй шавьж, мэрэгч амьтдыг ч бас анхаарч үзсэн юм.

Тухайн бүлэг амьтны зүйлийн баялаг асвалтаар тэдгээрийн амьтны аймгийн тодорхойлолтыг дээрх зургуудад жигд бүрэн дүүрэн өгч чадаагүй тал бий. Тухайлбал, шавьжаас зөвхөн зарим нийтлэг бүлэг болон цөөн хэдэн зүйл, шувуунаас хамгийн олон тоотой болон онцлог зүйлүүд, хөхтөнөөс хааяагүй тархмал, эсхүл цөөн тоотой байдаг бусад ихэнх зүйлийг үзүүлсэн байна. Харин хоёр нутагтан, мөлхөгч, загас, хөхтүүрүү, мухар ялааны хувьд бол одоогоор мэдэгдэж буй зүйл амьтдыг бүрэн тусгасан юм.

Монгол оронд 130 орчим зүйл хөхтөн бий. Тус орны хойт хэсгийн ой, тайгад амьдардаг үндсэн хөхтөн амьтан гэвэл атаахай, оготно, бусад жижиг амьтад юм. Түүнчлэн энд олон зүйлийн туурайтан, махан идэштэн нутагшиж тоо толгой нь их хэмжээнд хүрдэг байна. Нэлээд олон жижиг амьтан ургамлын үр болон шавьжаар голлон хооллодог ажээ. Өвс ногоо, мөчир найлзуураар хооллогч амьтан ч цөөнгүй бий.

Тус орны ойт хээрийн бүсийн дотор хээрт багавтар нүх үүр малтаж орогнодог ногоон өвсөн тэжээлт жижиг амьтад зонхилсон хөхтний бүлгэмдэл элбэг тархжээ. Хээрийн бүсийн зүүн захгаар цагаан зээр сүрэг сүргээрээ нутаглана.

Тус орны төв хэсгийн, хээрийн өвс ургамалтай нутагт олон салаа гүн нүх малтан орогнож голдуу ногоон өвсөөр хооллодог мэрэгчид зонхилно. Тэдгээрийн тоонд өвөл ичдэг тарвага, жилийн турш идэх хөдөлгөөнтэй байдаг жижиг амьтад орно. Зарим зүйлийн мэрэгчид хэт олширсон үедээ хөрс, ургамалд сүрхий нөлөө үзүүлдэг ажээ.

Цөлөрхөг хээр ба цөлийн бүсэд ааг шимт ургамал болон шавьжаар хооллодог амьтад олширч, нүх малтах ажиллагаа нь ажмаар багасахын хамт өвөл ичдэг амьтны тоо нэмэгдэнэ. Энэхүү гандуу бүсийн хойт хэсэгт голдуу ногоон өвс, ургамлын үрээр хооллож, нүх үлий их ухаж, жилийн турш идэхтэй амьдардаг монгол чичүүл зонхилно. Мөн ургамлын үр, шавьжаар голлон хооллодог, болхидуу нүх үүртэй, өвөл ичдэг зарим зүйл алагдааг, шилүүхэй нийтлэг юм.

Урагшлах тутам сүүлчийн бүлэг мэрэгчдийн үүрэг оролцоо улам нэмэгддэг. Унаган зүйл болох атигдаахай байхаар барахгүй бүр ч олон тоотой болно. Чичүүлээс энгийн нүхэнд орогнодог, жинхэнэ үрэн идэшт шар чичүүл зонхилно. Нүх үлийнээс ондоо газар орогнодоггүй морин чичүүл хааяа тохиолдохдоо голдуу заган ойд үзэгдэнэ. Цөлд зэргэлдээх хээр нутгийг бодвол туурайтан олон байдаг. Хар сүүлт зээр нэлээд их газарт тархдаг. Хулан цөөвөрт тохиолдоно. Зэрлэг тэмээ-хавтгай тус орны баруун урд талын хэсгээр нутагт оршино.

Бүс дундын биотопын хөхтөн амьтны бүлгэмдэл байгалийн янз бүрийн бүс нутагт тохиолдоно. Тухайлбал, хад асганы амьтны бүлгэмдэл ялангуяа Монгол Алтай, Говь Алтай, Хангай, Хөвсгөл орчмын уулст элбэг байна. Тэнд жижиг амьтад хадны барагчин, монгол огдой, алтайн огдой, үрт сүүлт шилүүхэй, туурайтнаас хүдэр, ангир, араатнаас суусар, ирвэс, шилүүс нутагладаг. Өндөр ууланд хад асганы амьтад гадна өвстэй чийглэг нуга, сөөгөн шугуйд дуртай амьтад бас хамт оршино. Хөхтний зүйл ер нь ууланд хамгийн олон янз байдаг. Цөлөрхөг хээрийн ба цөлийн бүсийн баян бүрдүүд хөхтний өвөрмөц бүлгэмдэлтэй. Гэтэл тэр бүсэд тархсан хэсэг хэсэг элсэн тарамцаагаар нутагладаг сийрэг элсний амьтад бүрэлдэхүүнээрээ гоц ялгардаггүй байна.

Хөхтөн амьтад бол ан олборлол, спорт-агнуурын чухал объект мөн. Үслэг ангаас уулын ба тал хээрт түгээмэл тархсан монгол тарвага, алтайн тарвага нэн их ач холбогдолтой. Зурам, жирх, хэрэм, туулай зэрэг бусад амьтад бас агтана. Махан идэшт хөхтөнөөс тайгад амьдардаг ойн булга хамгийн үнэт үслэг ан юм. Туурайтнаас халиун буга, бор гөрөөс, зэрлэг гахай, цагаан зээр олборлолын чухал ач холбогдолтой. Нэлээд нутагт аргаль, янгир агнах хэмжээнд хүртэл олширч, түүнийг тусгай зөвшөөрлөөр спорт-агнуурт ашиглаж байна.

Зарим зүйлийн хөхтөн үржиж олширсон үедээ бэлчээрийн өвс ургамлыг сүйтгэж хөдөө аж ахуйд хохирол учруулж болно. Нөгөө талаар газар малтагч жижиг мэрэгч амьтдын үйл ажиллагааны нөлөөгөөр хээрийн хөрс сийрэгжиж, ургамал нөмрөг нь баяжиж, нийтдээ бэлчээрийн ашиг шим дээшилдэг ч явдал бий.

Монгол орны хөхтөн амьтдын дотор Төв ба Зүүн Азийн хээр, цөлийн унаган амьтад цөөнгүй байдаг. Үүнд дагуур зараа, монгол огдой, дагуур огдой, монгол тарвага, монгол чичүүл, хэдэн зүйл атигдаахай, шилүүхэй зэрэг өргөн тархалттай болон зарим ховор зүйл амьтад орно. Эдгээр амьтны биологийг судлах явдал шинжлэх ухааны чухал ач холбогдолтой. Ховордсон зарим том ан амьтан, тухайлбал, гандуу нутагт тахь, хавтгай, монгол бөхөн, хулан, мазаалай, уулын тайгад хандгай, цаа бугыг хамгаалах, тоо толгойг нь сэргээн олшруулах эрчимтэй арга хэмжээ авах явдал чухал байна.

Ондаотор, минж, цагаан зээр, бөхөн зэрэг агнуурын үнэт амьтныг шинээр болон сэргээн нутагшуулах ажил эхэлжээ.

Монгол орон 17 багт хамаарах 400 гаруй зүйл шувуутайн 300 гаруй нь өндөглөн зусдаг шувууд ажээ. Байгалийн янз бүрийн бүсийн шувууд харилцан өргөн нэвтрэлдэг явдал Монгол орны шувууны тархалтын нэг онцлог шинж юм. Өвөл цас багатай, нарлаг өдөр олон учраас зөвхөн нутгийн суурин шувууд төдийгүй умар тундрын шувууд ч өвөлжих аятай нөхцөл бүрддэг байна. Монголд нийтдээ 100 орчим зүйл шувуу өвөлждөг.

Байгалийн бүсээр шувууд хэрхэн тархсан байдлыг авч үзье. Хээрийн бүсийн шувуудын бүрдэл гоц тод илрэх өргөн тархсан байдаг. Тэдний гол төлөөлөгч гэвэл талын бүргэд, шилийн сар, тоодог, дорнодын хиазат, өвөгт тогоруу, монгол болжмор юм. Эдгээр зүйл шувууд тус орны зүүн хязгаараас Монгол Алтайн захын уулс хүртэл тархдаг жинхэнэ тал хээр ба уулын хээрээс бусад нутагт бол зөвхөн тохиолдлын

байдалтай өндөглөнө.

Цөлөрхөг хээрийн ба цөлийн бүсэд амьдардаг гандуу нутгийн шувуудын бүрдэл түрүүчийнхээс дутуугүй өвөрмөц шинжтэй. Энэ бүрдэлд жороо тоодог, зэвэн хиазат, шоорон алаг болжмор, монгол хулан жороо, цөлийн чоцого, цөлийн зэржэнэ зэрэг шувууд орно. Гандуу нутгийн олонх шувууд цөлөрхөг хээрийн бүсээс хойш байдаггүй буюу байлаа ч энд тэнд тохиолдох төдий юм. Эдгээр шувуудын ихэнх нь цөлөрхөг хээрийн бүсэнд л тоо толгой харьцангуй олонтой байна.

Тайгын бүрдэлд хамаарах нургийн сойр, ханамал хөхөө, буслаг бүгээхэй, дүүдүүш зэрэг зонхилох шувуудын тархалтын өмнөд хил тус орны хойт хэсгийн уулын шилүүст тайгаар хязгаарлагдана. Энэ бүрдлийн шувууд мөнх ногоон шилүүст ойд илүү олноороо амьдардаг. Тайгын ландшафтанд үл хамаарах шувууд тайгад гүн нэвтэрсэн явдал умардын ойн нэг онцлог юм. Тийм шувуудын тоонд уулын хээрийн энгэр хажуу болон голын хөндийд тархсан цохноны хөөндэй, шар хөмсөгт хөмрөг, наран бүдээ, тоодог орно.

Уулын ойт хээрийн алаг цоог ойд европ хэвшингийн навчит ойн шувуудын бүрдэлд багтах бөртөг намнаахай, тарчигнаа зэржэнэ, гал сүүлт, шар хүзүүт хөмрөг зэрэг зүйл мэдэгдэхүйц нөлөөтэй байна. Голын шугуй дагаж бүс дундын зарим шувуу хээр, ойт хээрийн аль аль руу гүн нэвтэрч ордог юм.

Шувууны аймаг ууланд хамгийн олон төрөл зүйлтэй байдаг. Тэнд алтайн хойлог, хүрэмт гал сүүлт, цахир бужирга, цэжжмэгт гал сүүлт мэтийн хад асга, таг, таг орчмын шувуудын өвөрмөц бүрдэл өргөн тархахаас гадна тундрын бүсийн шувууд бас элбэг байна.

Усны болон ус орчмын бүлэг шувуудын үндсэн хэсэг нь тус орны баруун нууруудын том хотгор хөндий болон хойт, дорнод хэсгийн нуур, голуудыг бараадаж оршино. Дайрч нүүдэллэдэг шувуудаас шалтгаалан улирлын нүүдлийн үед энэ бүлэг шувуудын тоо нэмэгддэг ажээ.

Хүнд ойр оршдог бүлэг шувуудыг Монгол орны хувьд хамгийн залуу гэж зүй ёсоор тооцдог юм. Энэ бүлэгт хэрээ, улаан хушуут, хадны тагтаа, сохор элээ, үхэр цахлай орно. Гэрийндүү шинжтэй хөхөөр тагтааны тархалтын хүрээ ихсэж, тоо толгой нь тасралтгүй олширсон байна. Монголд тархсан бүх зүйл шувуудын тэн хагас нь дан шавьжаар, 25 хувь нь голдуу ургамлаар, 10 хувь нь ихэвчлэн усны амьтнаар хооллодог.

Тус оронд жигүүртэн шувууг хамгаалах дагалдах аятай нөхцөл боллоцоо бий. Монголд хэвийн байдаг нэлээд олон зүйл шувуудын популяци бусад оронд тархдаг оршдог нутгийнхаа ихэнхэд нь хэвгүй муу байдалд байна. Ийм шувуудын тоонд хээрийн галуу, хошуу галуу, хар өрөөтас, халбаган хушуут, ямаан сүүлт, усны цагаан сүүлт бүргэд, явлаг сар орно. Цэн тогорууны зүйлийн бүх тоо толгойн үндсэн хэсэг нь Монголын зүүн хойт хэсэгт зузаж өндөлдөг байна. Тоодог, жороо тоодгийн дорнодын дэд зүйлийн дэлхий дээрх популяцийн дийлэнх хэсэг Монгол оронд байдаг ажээ.

Монголд ан олборлолын ач холбогдол бүхий 120 орчим зүйл шувуу бий боловч түүнээс зөвхөн нотгоруу, дагуур ятуу, сойр, хөтүү, хахилаг, цэвдгийн ба цагаан ятууг агнаж ашиглаж байна.

Монгол оронд 30 орчим зүйл хоёр нутагтан, мөлхөгчид байдаг. Хоёр нутагтнаас монгол бах, сибирийн мэлхий хоёр хамгийн өргөн тархалтай. Ногоон бах тус орны зөвхөн баруун хэсэгт, дорнодын мэлхий зөвхөн зүүн хэсэгт, бусад хоёр нутагтан нь хойт зүйлээр нутагтар оршино.

Мөлхөгчид жигд биш тархалттай бөгөөд говьд хамгийн олон зүйл мөлхөгч тэмдэглэгддэг. Элбэг тархалттай түгээмэл шинжтэй нь хонин гүрвэл, могой гүрвэл, бамбай хоншоорт могой, рашааны могой юм. Өмнө зүгийн нутагтар алтайн замба гүрвэл, нэхой гүрвэл, говийн гүрвэл нутагладаг. Загалт гүрвэл, тэмээн сүүлт могой хоёр зөвхөн Алтайн өвөр говийн талархаг газраар, толбот гүрвэл Зүүнгарын говьд тохиолдоно. Монгол гүрвэл дорнодын хээр талд өргөн тархжээ. Бусад зүйл ховор буюу ганц нэг олдвор төдийхнөөр тааралдана.

Монголд хоёр нутагтан, мөлхөгчдийн бүлгэмдлийн бүтэц тун энгийн юм. Нутаглан орших нэг газарт голдуу хоёр гурваас илүүгүй зүйл мөлхөгч тохиолдоно. Мөлхөгчдийн оршин тархсан нягтшил бага, ялангуяа могой ховор байна.

Монгол орны нуур голуудад 12 овогт хамаарах 60 гаруй зүйл загас, загас хэлбэртэн амьдардаг. Түүний дотор монгол хадран, алтайн сугас зэрэг унаган гаралтай загас, мөн хилэм, тул, зэвэг, цагаан загас мэтийн ховор ба үнэт загасны зүйл олон бий.

Монголын загасны аймаг Номхон далайн, Умард мөсөн далайн, Төв Азийн гадагш урсгалгүй гурван ай савд хамаарна. Үүний улмаас загасны зүйлүүдийн тархалтын хилийг экологийн хүчин зүйл биш, газарзүйн байдал тодорхойлж буй нөхцөлд ай савуудын загасны аймгийн зарим төлөөлөгч харилцан нэвтрэх бололцоотой юм. Жишээлбэл, голуудын усны хагалбар намагжснаас болоод алтайн сугас загас Омь мөрний савд нэвтэрсэн нь илт байна. Энэ зууны эхний хагаст Амар мөрний загасны аймгийн хэд хэдэн төлөөлөгчийг (амарын булуу цагаан, амарын цөлбүртэц загас) Умард мөсөн далайн ай савд нутагшуулсан нь тэндхийн гол мөрөн, нуурт тархан дэлгэрч тоо толгойн хувьд нэлээд өсжээ.


Төв Азийн гадагш урсгалгүй ай савын нуур ус онц сонирхолтой юм. Тэнд зөвхөн гурван төрлийн загас амьдардаг. Тэр нутгийн байгалийн нөхцөл олон янз учир загасны элдэв хэлбэр үүсэх явц эрчимжиж боломж бий болжсон нь алтайн сугас загасны хувьд хамгийн тод илэрнэ. Монголын загасны бүх зүйлийн хагасаас илүү агнуурын ач холбогдолтой гэж болно. Тус орны загасны аймгийг баяжуулах, ан олборлолын үнэт загасыг тараан нутагшуулах ажил өргөн хийж байна. Байгал нуурын оморь загасыг Хөвсгөл нуурт амжилттай нутагшуулаа. Хангайн нурууны загасгүй бүлэг нуурт пельд загасыг нутагшуулаа.

Монгол орны шавьжийн аймаг зүйлийн бүрэлдэхүүнээр баялаг, өргөрөг бүсийн болон экологийн янз бүрийн бүлэглэл олонтой, газарзүйн хувьд нарийн бүтэцтэй юм. Эх газрын гандуу уур амьсгалын нөлөөгөөр хуурайсаг болон нуугдамхай хэлбэрийн шавьж, ялангуяа авгалдайн шатандаа далд газар амьдралтай шавьж элбэгшихэд хүрчээ.

Тус орны хойт хэсэгт ойн ба ойт хээрийн шавьжийн бүлгэмдэл зонхилно. Монголын нутгийн ихэнх хэсгийг ядуувар бүрэлдэхүүнтэй хээрийн болон цөлийн бүсийн шавьжийн аймаг эзэлнэ. Энд шөвгөр цох, нүүгээ хар цохын шулуун далавчтаны баг зонхилж, тоо толгой ихтэй байхаас гадна зүйлийн бүрэлдэхүүнээр олон янз байна. Энэхүү гандуу бүсэд нэвтэрч тархсан чийгсүү зүйлийн шавьжууд гол төлөв бүс дундын шинжтэй нийтлэг биш биотопод тохиолдоно. Тэдгээр шавьж зүйлийн бүрэлдэхүүнээр овоо баялаг боловч нийт тоо толгой нь их биш юм. Уулархаг нутагт элдэв янзын шавьжийн гойд эрээвэр хураавар бүрдэл тохиолдоно. Уулын болон өндөр уулын шавьжийн аймаг унаган зүйл олонтойгоороо онцлог байдаг.

Монгол орон био газарзүйн мужуудын уулзаар зааг дээр оршдогийн улмаас шавьжийн аймгийн газарзүйн бүтэц нарийн төвөгтэй болж европийн ойн, еврозийн хээрийн, тураны, төв азийн, манжуурын гаралтай амьтад зэрэгцэн оршино. Монголын дорнод хэсэгт бараг дан ганц хайлаасан төвөгтэй холбоотой манжуурын шавьжийн аймгийн үлдмэл амьтад нийтлэг юм.

Хөдөө аж ахуйн хортон шавьж нэлээд олон бий. Шумуул, дэлэнч, хөхтүүрүү зэрэг цус сорогчид мал аж ахуйд хохирол учруулдаг. Хайрсан далавчтан, тэдгээрийн дотроос ялангуяа сибирийн хүр, хатуу далавчтанаас их төлөв зэрэг цох ой модыг хөнөөнө. Монголын хойт хэсэгт бэлчээр, тариалангийн хортон болох царцаа, хар цох, няслуур, навч идэгч, шөвгөр цох, бүгэг эрээхэй зэрэг шавьж цөөнгүй бөгөөд заримдаа хэт олширлын голомт үүсгэдэг ажээ. Эдгээр хортон шавьжтай тэмцэх арга хэмжээ авч явуулж байна.



АМЬДРАЛЫН ИДЭВХ, ОРГОГНОХ БАЙРААР НЬ ХӨХТНИЙ ЭКОЛОГИЙГ ТОДОРХОЙЛОХ БАЙДАЛ

Table with 2 main columns: 'Оргогдох байр' (Location) and 'Хөдөлгөөн' (Movement). It details the ecological requirements for various species groups.

Хөдөлгөөн-суурин амьдралд амьтай хөдөх хэдий эсвэл баад-хэдэн метрээр хэдэн орон метр бунд зэрэг-хэдэн орон метрээр хэдэн зуун метр их-хэдэн километр

Тайбар Хөхтний амьдралын тодорхойлолтыг I, II тусжээнд үзүүлэв

II Үндсэн хоол тэжээл, амьдрах давхарлагаар нь хөхтний экологийг тодорхойлох байдал

Table showing the relationship between food types and vegetation layers. Columns include 'Хоол тэжээл', 'Үндсэн хоол тэжээл', and 'Амьдрах давхарга'.

Өндөр уулын хөхтний бүлгэмдэл

Table detailing the composition of high mountain ungulate groups, listing species and their distribution across different vegetation types.

Ойн хөхтний бүлгэмдэл

Table detailing the composition of forest ungulate groups, listing species and their distribution across different vegetation types.

Хээрний хөхтний бүлгэмдэл

Table detailing the composition of steppe ungulate groups, listing species and their distribution across different vegetation types.

Цөлийн хөхтний бүлгэмдэл

Table detailing the composition of tundra ungulate groups, listing species and their distribution across different vegetation types.

Зонхилон хөхтний бүлэг


Table detailing the composition of mixed ungulate groups, listing species and their distribution across different vegetation types.

Зонхилон булган зооглох онцлог

Table detailing the characteristics of mixed ungulate groups, listing species and their distribution across different vegetation types.

Цөлөрхөг хээр ба цөлийн бүсийн ус орчмын биотопын хөхтний бүлгэмдэл

Table detailing the composition of ungulate groups in semi-desert and tundra zones, listing species and their distribution across different vegetation types.



ШУВУУДЫН ЭКОЛОГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Table detailing the ecological characteristics of water bodies, listing species and their distribution across different water body types.

ШУВУУДЫН БҮЛГЭМДЭЛ

Table detailing the composition of water body groups, listing species and their distribution across different water body types.

Шууны зүйл

Table detailing the composition of water body groups, listing species and their distribution across different water body types.

Шууны зүйл

Table detailing the composition of water body groups, listing species and their distribution across different water body types.

Шууны зүйл

Table detailing the composition of water body groups, listing species and their distribution across different water body types.

БҮС ДУНДЫН БИОТОПЫН БҮЛГЭМДЭЛ

Table detailing the composition of biotopes across the country, listing species and their distribution across different biotope types.

НУУДЛИН ШУВУУ ШУЛААГ ГАЗАР

Table detailing the composition of water bodies, listing species and their distribution across different water body types.

127 ХОЁР НУТАГТАН, МӨЛХӨГЧИД

Масштаб 1:9 000 000




Table with columns for species (Зүүлдүүд), zones (Хөёр нутагтан), and distribution (Мөхлөгчид). Lists species like Temnodon, Gazelle, and others with their corresponding zone and distribution codes.

Table with columns for species (Иргэнх бичир), zones (Хөёр нутагтан), and distribution (Мөхлөгчид). Lists species like Gazelle, Capreolus, and others with their corresponding zone and distribution codes.

128 ЗАГАС

Масштаб 1:9 000 000






Table with columns for species (Загасын загасууд), zones (Загасны ангитын бүрдэл), and distribution (Мөхлөгчид). Lists species like Hippocrepis, Astragalus, and others with their corresponding zone and distribution codes.

129 ЗЭРЛЭГ ТУУРАЙТАН

Масштаб 1:9 000 000




130




131 АГНУУРЫН ШУВУУ

Масштаб 1:9 000 000




132 ХОВОР ШУВУУД

Масштаб 1:9 000 000




133 МАХАН ИДЭШТ АГНУУРЫН ТОМ АМЬТАД

Масштаб 1:9 000 000




134 МАХАН ИДЭШТ АГНУУРЫН ЖИЖИГ АМЬТАД

Масштаб 1:9 000 000




135 ХОВОР ХӨХТӨН

Масштаб 1:9 000 000




136 ХӨХТНИЙ ЗҮЙЛИЙН ТОО

Масштаб 1:9 000 000



137 ТҮГЭЭМЭЛ МЭРЭГЧИД


Масштаб 1:6 000 000




138

МЭРЭГЧИД БА ТУУЛАЙ ХЭЛБЭРТЭН

Масштаб 1:12 000 000




139



140 АГНУУРЫН МЭРЭГЧИД БА ТУУЛАЙ ХЭЛБЭРТЭН

Масштаб 1:6 000 000



ЛАНДШАФТ БА БАЙГАЛИЙН МУЖЛАЛТ

Энэ бүлэг БНМАУ-ын ШУА-ийн Газарзүй цэвдэг судлалын хүрээлэн, ЗСБНХУ-ын ШУА-ийн Газарзүйн хүрээлэнгээс хамтран зохиосон, өөр хоорондоо харилцан холбоотой, нэг нь нөгөөгийнхөө агуулгыг баяжуулсан байгалийн цогцолбор зураг болон байгаль хамгааллын зургаас бүрдэнэ. Ландшафтын ба байгалийн мужлалтын зураг нь тус атласын байгалийн хэсэгт орсон олон зургийг ерөнхийд нь холбож үйлдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Монгол орны ландшафтын ба байгалийн мужлалтын зургийг зохиохдоо хээрийн судалгаа, суурин боловсруулалтын материалд тулгуурласан юм. Хээрийн судалгааны үед ландшафтын тархалтын үндсэн зүй тогтлыг илрүүлж тус орны янз бүрийн бүс нутгийн ландшафтын өвөрмөц бүтцийг тодруулсан билээ. Эдгээр зургийн зохиоход хэвлэмэл эх материал болон Монгол орны нутаг дэвсгэрийн байгалийн цогцолбор мужлалт үйлдсэн өмнөх бүх туршлагыг ашигласнаас гадна БНМАУ-ын ШУА, ЗСБНХУ-ын ШУА-ийн хамтарсан геолог, биологийн экспедицийн олон жилийн судалгааны үр дүнд зохиож хэвлэсэн байгалийн зургуудыг үндэс болгоо.

Ландшафтын зураг бол бүхэл бүтэн геосистемийг дүрсэлж харуулдаг билээ. Хэлбэр тектоникийн гол шинж төрх болон ландшафтын бүтцийг илэрхийлэгч бүс, бүслүүрийн бүрдлийг үндэслэн Монгол орны хэмжээнд талын, уулын, хотгорын гэсэн гурван ангийн ландшафтыг ялгалаа. Хотгорын ландшафтыг ангиллын эрэмбээр хамгийн том нэгжийн нэг болгож ялгасны учир бол хотгорууд их түгээмэл тархсан төдийгүй тэдгээрийн дотор байгалийн онцгой бүсний илэрдэгтэй холбоотой юм. Ландшафтыг шим-уур амьсгалын шинжээр нь мөнх цасныхаас авахуулаад хэт гандуу цөлийнх хүртэл бүсийн хэвшинж, дэд хэвшинжүүдэд хуваав. Бүс дундын ландшафт ч энд бас элбэг юм.

Ангилал шатлалын арай доод төвшинд ландшафтыг усны эвдлэх үйлчлэлээр хэр зэрэг шигүү, гүн хэрчигдсэнийг нь харгалзан бүлэг төрлүүд болгон ялгасан байна. Бүлэг төрлүүдийн дотор ландшафтыг бодисын шилжих хөдөлгөөний чиглэлээр нь эвдрэл-элэгдлийн, элэгдлийн, элэгдэл-хуримтлалын, хуримтлалын төрөлд тус тус хуваав. Ангиллын эрэмбээр хамгийн доод шатны нэгж бол ландшафтын зүйл юм.

Байгалийн мужлалтын зургийг ландшафтын зургийн үндсэн дээр зохиолоо. Уг зурагт бие биедээ захирагдан багтах таван шатлалтай бүс нутгийн систем болох байгалийн их муж, муж, дэд муж, район, дэд районуыг ялган харуулав.

Байгалийн их мужийг ялган тогтооход түүний байгалийн нөхцөл, хил зааг бүрэлдэн буй болоход хэлбэр тектоник шинж зонхилох рольтой гэсэн төсөөллийг үндэс болгосон билээ. Байгалийн их муж бол ерөнхий хэлбэр бүтцийн хувьд нэгдмэл шинжтэйгээ гадна шим-уур амьсгалын бүс, бүслүүрийн бүрдэл хийгээд ландшафтын бүтц бүрэлдэн тогтох явдлыг тодорхойлогч чийглэг агаарын ноёлох урсгал, хэлбэр бүтэц хоёрын харилцан үйлчлэлийн хувьд мөн нийтлэг нэгдмэл шинжтэй юм. Байгалийн муж бол нэгдүгээр зэргийн хэлбэр бүтэц болон шим-уур амьсгалын олон янзын бүс, бүслүүрийн бүрдлийн нийтлэг нэгдмэл шинжтэй байдаг. Байгалийн дэд муж бол хоёрдугаар зэргийн хэлбэр бүтэц, шим-уур амьсгалын арай цөөн янзын бүс, бүслүүрийн нэгдмэл байдлаар тодорхойлогдоно. Мужлалтын доод нэгжүүд болох байгалийн район, дэд район нь гурав, дөрөвдүгээр зэргийн хэлбэр бүтэцтэй тохирч, ландшафт тус бүрийн дотоод бүтцийг тусган илэрхийлнэ.

Ландшафт ба байгалийн мужлалтын зураг нь Монгол орны бүх нутаг дэвсгэрийн ландшафтын бүтцийг илтгэн харуулна. Тус орны газрын гадарга уул-тал-хотгор хосолсон эрс тэс байдалтай, чийг-дулааны нь горим онцлог шинжтэй учир Азийн энэхэн бүс нутагт нарийн бүтэц бүрдэл бүхий өвөрмөц маягийн ландшафтууд бүрэлдэн бий болдог ажээ. Ландшафтууд орон зайд ялгаран тогтоход нөлөөлөх гол хүчин зүйлийн нэг бол газрын гадарга бөгөөд тэр нь уур амьсгалын өргөргийн бүсүүд жигд илрэхэд садаа учруулж, түүний улмаас тус улсын нутаг дэвсгэрийн ихээхэн хэсэг байгалийн ямар бүсэд хамаарах тухай асуудал одоо хүртэл маргаантай хэвээр байна. Монгол орны зөвхөн төв ба зүүн өмнөд хэсгийн талаарх нутагт өргөргийн бүсүүд тод илэрч ландшафтын бүрэлдэхүүнд шим-уур амьсгалын хүчин зүйл голлож байгаа нь тодорхой харагддаг.

Монгол орны уулархаг нутгийн босоо бүслүүрийн бүтэц уул нуруудын үзмэлзүй өндөр, газарзүйн өргөрөг, чийглэг агаарын урсгалын чиглэлд уулс хэрхэн байрласан байдал, хажуугийн зүг зовхис зэргээс хамаарна. Босоо бүслүүрийн тоо, тэдгээрийн ландшафтын бүрдэл өөр өөр уул тогтолцоонд харилцан адилгүй байдаг. Хотгор газраар хотгорын нөлөөлөл тод илэрнэ. Энэ нөлөөлөл хэр тод, хэр хүчтэй байх нь хотгорын хэмжээ, хэлбэр дүрс, гүнзэг голлон хамаардаг бөгөөд дэлгэр нь хотгор дахь агаарын зүйлсийн шилжил хөдөлгөөний онцлогийг тодорхойлодог байна. Хотгорууд эргэн тойрных нь нутгийг бодвол нэлээд урдуур өргөргийн ландшафт бүхий босоо бүслүүр бүрэлдэн тогтдог ажээ.

Монгол оронд байгалийн нөхцөл байдлын хувьд Хангай-Хэнтэйн уулархаг их муж, Төв Азийн өндөрлөг тал, хотгор, уулт их муж, Их Хянганы уулархаг их муж гэсэн байгалийн гурван их муж ялгардаг нь Азийн газар бүтцийн их мужуудтай тохирч байгаа юм.

Хангай-Хэнтэйн уулархаг их мужид гол мөрний усны сүлжээ овоо сайн хөгжсөн, олон жилийн цэвдэг чулуулаг элбэг тархсанаас гадна бусад их мужийг бодвол агаар мандлын чийгшил мэдэгдэхүйц их, уур амьсгалын эх газарлаг шинж арай бага байдагараа онцлог юм. Энд босоо бүслүүр олон янз бөгөөд түүний бүтэц ерөнхийдөө ян сарьдгийн, сарьдаг орчмын, уулын тайгын, уулын ой, уулын ойт хээрийн, уулын хээрийн, уулын хуурай хээрийн ландшафтаас бүрдэнэ.

Хөмбөн-цүлдам уул, тэгш өндөрлөг, рифтийн хотгор бүхий Хөвсгөл орчмын мужид өндөр уулын ян сарьдгийн (хаг-хөвдөт тундрын болон чулуурхаг) ландшафт түгээмэл байна. Тэр нь дундаж өндөр уулст сарьдаг орчмын (тармаг ойн) ландшафт болон цэвдэгт-тайгын, ширэгт-тайгын хөрстэй шинэ, хуш-шинэсэн ой бүхий дундад ба өмнөд тайгын ландшафтаар солигдоно. Хотгор газраар тайгын, ойн, торлогийн буюу нугат-хээрийн, нугын ландшафт тархана.

Хөмбөн-цүлдам уул, хотгорууд бүхий Орхон-Сэлэнгийн муж ландшафтын бүтцийн хувьд нэлээд нарийн төвөгтэй юм. Энд уулын ар өвөр хажуугийн ойт хээр, уулын хуурай хээр, уулын ой, уулын хээрийн ландшафт алаглан тогтжээ. Тус мужийн чийгээр арай элбэгжүү баруун хойт хэсгийн хөндий хотгоруур нутагт карбонатлаг хар шороон хөрстэй алаг өвс-үетэнт ургамалшил бүхий хээрийн ландшафт бүрэлдэн тогтсон байна. Чийгээр дутмаг зүүн ба өмнөд хэсгийн уудам хотгор, тэдгээрийг хүрээлсэн нутагт нунтаг-карбонатлаг хар хүрэн хөрс бүхий жижиг бутлаг үетэнт хээрийн ургамалшилтай умард хуурай хээрийн ландшафт зонхилно. Хотгоруудын ёроолд нуга, элсний ландшафт, мараа-марзат хам бүрдэл, нарсан төгөл тогтворжжээ.

Хэнтэйн хөмбөн уулт өндөрлөгийн мужийн төв ба баруун хойт хэсгээр өмнөд болон дундад тайгын ландшафт бараг газар сайгүй тархжээ. Өндөр уулын төвшинд хүрэхэд уулын тайгын бүслүүр ян сарьдгийн болон сарьдаг орчмын бүслүүрээр солигддог. Тус мужийн зүүн хэсэгт, хөмбөнгийн дотоод хөдөлгөөнд нэлээд ялгарч гарч байсны улмаас нугат-хээр, умард хуурай хээр, нугын ландшафт бүхий хотгорууд үүсжээ. Уулт өндөрлөг зүүн тийшээгээ өвчим намсдаг учир уулын тайгын бүслүүрээс доош уулын ой, уулын ойт хээр, уулын нугат-хээр, уулын хээр ээлж дараалан солигдож, харин өмнө зүг рүү бол уулын хуурай хээртэй залгана.

Хөмбөн-цүлдам нам уул, хотгор, суурт өндөрлөг тал бүхий Онон-Улзын муж Хангай-Хэнтэйн асар том нуман хэлбэрийн уул тогтолцооны зүүн шугатаргын хэсэг нь юм. Энд илүү чийглэг нөхцөлтэй учраас ландшафтын бүтцийн хувьд үндсэндээ, карбонатгүй хар шороон хөрстэй зүр өвст жинхэнэ хээр болон нугын хээрээс бүрдэнэ. Уулсын дээд хэсэгт хээрийн ландшафт уулын хажуугийн ойт хээр болон гүн хөлдөмтгий нугат-ойн хөрстэй өвслөг ойгоор солигддог. Хээр, хуурай хээр зонхилсон өргөн хөндий хотгор нуга, нарсан төгөл, мараа-марзат хам бүрдэл элбэг тохиолдоно.

Хангайн хөмбөн-цүлдам уулт өндөрлөгийн муж байгалийн ландшафтын хувьд тус их мужид багтаа бусад мужтай харьцуулахад ихээхэн нарийн бүтэцтэй юм. Хангайн өндөр уулархаг хэсэгт ян сарьдгийн ландшафтын зэрэгцээ бушилз ургасан уулын нуга нэлээд дэлгэрчээ. Мөн уулын нугат-хээрийн ландшафт алаг цоог тархана. Тус мужийн дундаж өндөр уулст түрүүчийн мужуудад нийтлэг байдаг ландшафтуудаас гадна уулын ар хажуугийн ойн босоо бүслүүр онцгой байрыг эзэлнэ. Анх удаа ялган тогтоож буй энэхүү ландшафт Хангайн гол нуруунаас хойш, мөн Хөвсгөл орчмын нутгийн өмнөд хэсгээр тааралдана. Энэ ландшафт нь уулын хажуугийн ойт хээрийн ландшафтын нэгэн адил ар хажуугаар тархсан ой, өвөр хажуугаар тархсан хээр

гэсэн хоёр хэсгээс бүрддэг. Хангайн уулт өндөрлөгийн өмнөд хагасын дундаж өндөр уулын бүслүүрт, уулын умард ба өмнөд хуурай хээр, уулын цөлжүү хээрийн ландшафт зонхилно. Уулт өндөрлөгийн дотор хотгоруудаар хээрийн, умард хуурай хээрийн, өмнөд хуурай хээрийн болон нугын ландшафт түгээмэл байна.

Төв Азийн өндөрлөг тал, хотгор, уулт их муж Монгол орны нутгийн ихэнх хэсгийг эзэлдэг. Хэт эх газарлаг шинжтэй, гадагшаа урсгалгүй, гадаргын усны урсгал багатай, олон жилийн цэвдэг алаг цоог тохиолдог, ой мод байхгүй, хуурай хээр ба цөлжүү хээр, заримдаг цөл, цөлийн ландшафт голлосон өмнөд хуурай хээрийн, уулын цөлийн ландшафт зонхилно.

Тус их мужийн уулархаг нутгаар уур амьсгалын гандуу байдлын улмаас ой, тайга, ойт хээрийн ландшафт байхгүй, харин шинэ янзын босоо бүслүүр илэрч үзэгдэнэ. Энд мөстлийн үеийнхтэй төстэй байгалийн нөхцөлд бүрэлдэн тогтсон цэвдэгт-хуурайгаг маягийн уулын бушилзат нугын ландшафтаас гадна хээрийн бүдүүн ялзмагт хөрстэй дэгнүүлэн алаг өвс-ботуулыг ургамалшил бүхий таяншаньхтай ойролцоо шинжтэй өндөр уулын хээрийн ландшафт, мөн хуурай хээрийн бүдүүн ялзмагт хөрстэй алаг өвс-ботууль-жижиг бутлаг үетэнт ургамалшил бүхий уулын хуурай хээрийн ландшафт тархжээ. Уулын ландшафтын төрөл зүйл энд олон янз, хоорондоо эрс тэс ялгаатай байна. Тухайлбал, мөнх цасны, ян сарьдгийн, уулын нугын, алтйн уулын хээрийн ба уулын хуурай хээрийн, уулын умард хуурай хээрийн, уулын өмнөд хуурай хээрийн, уулын цөлжүү хээрийн, уулын заримдаг цөлийн, уулын цөлийн ландшафт тохиолдоно.

Монгол Алтайн хөмбөн-цүлдам уулт өндөрлөгийн муж баруун зүгээс ирдэг чийглэг агаарын урсгалд бага өртөмтгий дотор талын хуурайтар хажуунуудыг хамардаг учир тэндхийн өндөр уулсаар уулын нугын болон уулын хээрийн (алтайн) ландшафт нэн түгээмэл юм. Түүнээс гадна босоо бүслүүрийн бүрдэлд цас мөсний болон ян сарьдгийн ландшафт алаг цоог үзэгдэнэ. Дундаж өндөр уулд уулын хуурай хээрийн (алтайн) ландшафт голлоно. Уулан дундах битүү хотгоруудаар хуурай хээр, цөлжүү хээрийн ландшафт зонхилж заримдаг цөлийн ландшафт, мараа-марзат хам бүрдэл хааяа тааралдана.

Говь Алтайн бэлэрхэг уулын мужид бол Төв Азийн уулархаг их мужийн босоо бүслүүрийн ерөнхий шатлалын доод төвшинд хамаарах уулын хуурай хээрээс авахуулаад уулын нуга хүртэлх ландшафт тархсан байна. Эндхийн зарим ноён оргилд өндөр уулын нуга тохиолдоно. Уудам хотгор хоолойнуудаар өргөрөг-бүсийн шинжтэй заримдаг цөл, умард цөл, өмнөд цөлийн ландшафтаас гадна мараа, мараа, элс багагүй тархжээ.

Төв Азийн их мужийн дотор хотгоруудад гадаргын байдал нарийн төвөгтэйин улмаас өвөрмөц маягийн босоо бүслүүр тодорхой илэрнэ.

Их нууруудын хотгорын мужид бэлэрхэг, байрлал, тусгаарлалын хувьд харилцан адилгүй боловч бие биетэйгээ холбоотой уул хоорондын хотос хонхрын систем, тус тусдаа тогтсон бэлэрхэг уулстай хослон оршдог. Тэндхийн байгалийн ландшафт олон янз, нарийн бүтэцтэй. Ландшафтын бүтэц нь мужийн ихэнх нутагт хотгоруудын шинж төрхөөс, зарим районд уулын шинж байдалаас шалтгаална. Хотгоруудын ёроолд заримдаг цөлийн ландшафт ноёрхож, арай өндөр төвшинд цөлжүү хээрээр солигдон уулын бэл, цав толгод, цүлдам уулст бол өмнөд хуурай хээрийн ландшафт зонхилдог ажээ. Бэлэрхэг өндөр уулсаар хүрээлэгдэн бие биенээсээ тусгаарлагдсан цөлөрхөг хотгоруудад хотгорын нөлөөлөл хамгийн тод илэрнэ.

Баруун Хуурай хотгор, түүнийг хүрээлсэн бэлэрхэг уулын муж уулзүйн хувьд Монголын бусад нутгаас тусгаарлагдсан байдалтай, харин зэргэлдээх Зүүнгарын говьтой холбоотой юм. Энэ нь тус мужийн ландшафтын зарим бүрэлдэхүүн хэсгийн шинж байдалд нөлөөлжээ. Тэр хотгорын хамгийн нам хэсэгт нь хотгорын нөлөөлөл нэн тод илэрч хужир мараа, шал тойром, түүнчлэн эрс тэс эх газрын шинжтэй хэт гандуу хээрийн ландшафт тархсан байна. Цөлийн бор сарал хөрстэй Туран-Зүүнгарын цөлийн үетэнт-заримдаг сөөгөцөрт ургамалшил бүхий өмнөд цөлийн ландшафт уг хотгорын төвийг эргэн тойрон бүсэлж оршино. Хотгорын хамгийн өндөрлөг хэсэг болон уулын доод хажуу бэл хормойгоор Туран-Зүүнгарын ургамал ургасан умард цөлийн ландшафт бүрэлдэн тогтжээ. Бэлэрхэг уулын хормойгоос орой өнд өгсөхөд умард цөлийн ландшафт Зүүнгарын ургамалшил бүхий заримдаг цөл, цөлжүү хээрийн ландшафтаар солигдож улмаар уулын хамгийн өндөр оргилд алтайн хуурай хээр ба хээрийн ландшафтаас бүрдсэн өндрийн бүслүүр үүссэн байна.

Монголын төв болон зүүн өмнөд хэсгийн суурьт ба давхаргат өндөрлөг тал, тэгшдүү хотгор, сэргэж хэлбэршсэн үлдмэл-цүлдам уулс, бэлэрхэг уулс бүхий мужуудад ландшафтын тархалтын зүй тогтол үндсэндээ өргөргийн бүснийн хүчин зүйлээр тодорхойлогдоно. Монголын төв хэсэгт хойноос урагшааа жижиг бутлаг үетэнт ба сөөгөл ургамалшил бүхий хүрэн хөрстэй өмнөд хуурай хээрийн ландшафтын бүс, цөлжүү бутлаг үетэнт ба заримдаг сөөгөцөрт ургамалшил бүхий цайвар хүрэн хөрстэй цөлжүү хээрийн ландшафтаар солигдоно. Түүнээс урагш цөлөрхөг хээрийн бор хөрстэй заримдаг цөлийн ландшафт үргэлжилж, мужийн хамгийн урд захаар үетэнт-заримдаг сөөгөцөрт цөлийн ургамалшил бүхий хээржүү цөлийн цайвар бор хөрстэй умард цөлийн ландшафт голлодог. Монголын зүүн өмнөд мужид ландшафтын бүсүүдийн дараалал дээр дурдсан төв хэсгийнхээс хэний нэг дэд бүсээр дутуу байдаг. Цөлжүү хээр, заримдаг цөл, цөлийн ландшафт зонхилсон өргөн уудам хотос нам газраар мараа, хужир, мараа, элсний хам бүрдлийн ландшафт элбэг тархахын хамт өмнө зүг рүү шал тойром цөөнгүй үзэгдэнэ.

Давхаргат ба суурьт өндөрлөг тал, тэгш хотгор, үлдмэл-цүлдам уулс бүхий Монголын дорнод муж уур амьсгалын нөхцөлөөр тухайлбал, зүүн зэргэлдээх Зүүнгарын өргөр ирэх агаарын урсгалдаа шалтгаалдаг байж болох чийгшилгүй нөхцөлийн хувьд нэгэн ижил шинжтэй юм. Үүний улмаас БНМАУ-ын хойт хилиэс авахуулаад Хянганы уулс хүртэл олон зуун километр нутагт хойноосоо урагшаа нэлэнхийдээ умард хуурай хээрийн ландшафт зонхилсон хуурай хээрийн нэг л бүс үргэлжилдэг ажээ. Энэхүү тал нутагт өмнөд хуурай хээрийн ландшафт бүхий уудам хотгорууд байдаг явдал түүний дотор дэд бүсийн ялгааг үүсгэнэ. Үлдмэл-цүлдам уулс болон Дарьгангын галт уулын бэлэрхэг оройгоор уулын хээрийн босоо бүслүүр ялгаран харгалдана.


Сайраар их хэрчигдсэн бэлэрхэг уул, тал, хотгор бүхий Алтайн өвөр говийн мужид хотгор гүдгэрийн нөхцөлөөр маш жигд биш умард цөл, өмнөд цөл, хэт гандуу цөлийн ландшафт түгээмэл юм. Хойноос урагшлахад умард цөлийн ландшафт өмнөд цөлийнхөөр солигдоно. Цөлийн бүсийн хамгийн өмнө талд байрлах ёстой сайр дагасан сөөгт ургамалшил бүхий дээд давхаргадаа гөлтгөнө агуулсан борзон хөрстэй хэт гандуу чулуурхаг цөлийн ландшафт тархалтын хувьд өргөрөг бүсийн зүй тогтолд ул захирагдан өмнөд цөлийн ландшафттай нэг өргөрөгт оршдог байна. Газарзүйн ийм онцлогийг уулзүй-хотгорын нөхцөлтэй нь холбож үзвэл зохино. Бэлэрхэг уулст цөлийн ландшафтаас гадна босоо бүслүүрийн бүрдэлд нь уулын заримдаг цөл, уулын цөлжүү хээр, уулын хуурай хээр, түүнчлэн зарим тохиолдолд уулын нугат-хээр, уулын хээр оролцоно.

Их Хянганы уулархаг их муж дорно зүгээс ирэх чийглэг агаарын урсгалын нөлөөнд оршдог. Баруун Хянганы мужийн зах хэсэг болох уулын ойт хээр, уулын хээр, нугат-хээр бүхий хаая-нам уулс тус улсын нутагт хамаарах бөгөөд тэндхийн байгалийн ландшафт чийг овоо хангалттай нөхцөлд бүрэлдэн тогтжээ.

Ландшафтын орон зайн ялгаар нь тухайн нутгийн газрын үндсэн бүтэцтэй нягт холбоотой болохыг судалгааны ажлын үр дүнд илрүүлсэн байна. Байгалийн янз бүрийн мужийн ландшафтын бүрдэл газрын гадаргын хэлбэр бүтэцэд илэрлээ олдог бол өөр өөр төвшний байгалийн цогцолборын хил зааг бүрэлдэхэд тектоник шугаман хагарал — линеament болон цагирган бүтцийн зүйл олонтаа оролцдогийг тогтоолоо.

БНМАУ-ын ландшафтын болон байгалийн мужлалтын зургуудыг тус орны байгалийн нөөц баялагийг зүй зохиостой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөхөд үндэс суурь болгох, газар орныг шинээр эзэмшиж болон хөдөө аж ахуйг хөгжлөх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн төрөлийг нэрийлчлэхэд төвөг учруулж болох нөхцөл байдлаар нь нутаг дэвсгэрийг үнэлэхэд эх үндэслэл болох зэргээр ашиглаж болно.

Байгаль хамгааллын зураг нь улсын хамгаалалтад байгаа газар нутаг болон байгалийн биетүүдийг тусган харуулна. Хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн нөөцийг зүй зохиостой ашиглах асуудал бол БНМАУ-ын эдийн засаг, нийгмийн хөгжлийн чухал зорилтын нэг мөн.




Анги		УУЛЫН ЛАНДШАФТ															
		Дэд анги		Өндөр уулын (2500 м-ээс дээш)		Дундир өндөр уулын (1500-аас 2500 м хүртэл)		Нам уулын (1500м-ээс доош)									
Хэвсгэл ба дэд хэвсгэл	Бүлэг төрөл	Төрөл	Харчигдэлтэй		Бага харчигдэлтэй		Харчигдэлтэй		Бага харчигдэлтэй		Нам уулын (1500м-ээс доош)						
			Зайрлал-алгагчийн	Эзлэгдлийн	Зайрлал-алгагчийн	Эзлэгдлийн	Зайрлал-алгагчийн	Эзлэгдлийн	Зайрлал-алгагчийн	Эзлэгдлийн	Зайрлал-алгагчийн	Эзлэгдлийн	Хури				
Зонхилгооч	Давалдагч	30% 20% 10%															
Шас мөсний	Ж Ж Ж																
Ля сарьдасны	Х Х Х		2	3													
Сарьдас орчмын	У У У				18												
Уулын нугсын	Э Э Э		4	5	19	20											
Уулын нугст-хээрийн	Б Б Б		6														
Талзан	Дунгай талзан	◄ ◄ ◄			21	22											
	Өмнөд талзан	◊ ◊ ◊			23	24			49								
Ар халуунгийн өвч	▲ ▲ ▲				25	26											
Ой	▼ ▼ ▼				27	28			50								
Ойт хээрийн	▲ ▲ ▲				29	30			51	52	53						
Хээрийн (хэрцэгдмэл хуурай)	Алтайн (өндөр уулын)	● ● ●	7	8													
	Нугал-хээрийн	◄ ◄ ◄							54	55							
	Ижидэн хээрийн	◆ ◆ ◆	9	10	31	32	33		56	57	58						
Хуурай хээрийн (сандууцтар)	Алтайн	▲ ▲ ▲	11		34	35											
	Умард хуурай хээрийн	▶ ▶ ▶	12	13	36	37			59	60	61						
	Өмнөд хуурай хээрийн	▼ ▼ ▼		14	38	39			62	63	64						
Цөлжүү хээрийн ба заримдаг цөлийн	Цөлжүү хээрийн	⊕ ⊕ ⊕	15	16	40	41			65	66	67						
	Заримдаг цөлийн	€ € €	17		42	43			68	69							
Цөлийн	Умард цөлийн	■ ■ ■			44	45			70	71	72						
	Өмнөд цөлийн	■ ■ ■			46	47			73	74							
	Хам гандуу цөлийн	■ ■ ■				48			75	76							

Анги		ТАЛЫН ЛАНД								
		Дэд анги		Өндөр тал (600-аас 1000 м хүртэл ба)		Бага хэрцэгдэлтэй				
Хэвсгэл ба дэд хэвсгэл	Бүлэг төрөл	Төрөл	Харчигдэлтэй		Бага хэрцэгдэлтэй		Хури			
			Зайрлал-алгагчийн	Эзлэгдлийн	Зайрлал-алгагчийн	Эзлэгдлийн	Зайрлал-алгагчийн	Эзлэгдлийн	Хури	
Зонхилгооч	Давалдагч	30% 20% 10%								
	Хээрийн (хэрцэгдмэл хуурай)	● ● ●	77		78	79				
Хуурай хээрийн (сандууцтар)	Нугал-хээрийн	◄ ◄ ◄			80	81				
	Ижидэн хээрийн	◆ ◆ ◆								
	Алтайн	▲ ▲ ▲								
Цөлжүү хээрийн ба заримдаг цөлийн	Умард хуурай хээрийн	▶ ▶ ▶	83	84	85	86	87	88		
	Өмнөд хуурай хээрийн	▼ ▼ ▼	89	90	91	92	93	94	95	96
	Цөлжүү хээрийн	⊕ ⊕ ⊕	97	98	99	100	101	102	103	104
Цөлийн	Заримдаг цөлийн	€ € €	105	106	107	108	109	110	111	112
	Умард цөлийн	■ ■ ■	113	114	115	116	117	118	119	120
	Өмнөд цөлийн	■ ■ ■	121	122	123	124	125	126	127	128
	Хам гандуу цөлийн	■ ■ ■	129	130	131	132	133	134	135	136

145 ЛАНДШАФТ

Масштаб 1:3 000 000



Ш А Ф Т

түүхээс эхлэн


Төрөл	Тэгш газартай		
	Эзлэлийн	Эзлэлийн-хуримтлын	Хуримтлын
Төв	82		
Хээр	89	90	91
	98	99	
Хуурай хээр	106	107	
	113	114	115
Шал	120	121	122
	128	129	130
Хөд			135

Х О Т Г О Р Ы Н Л А Н Д Ш А Ф Т

Анг	Бүлэг төрөл	Хэрчигдэлтэй								
		Төрөл		Бага хэрчигдэлтэй			Тэгш газартай			
Хэвшин ба дэд хэвшин	Төрөл	Зөдрөл-элсдлийн	Эзлэлийн-хуримтлын	Зөдрөл-элсдлийн	Эзлэлийн	Эзлэлийн-хуримтлын	Хуримтлын	Эзлэлийн	Эзлэлийн-хуримтлын	Хуримтлын
Төв	Дундай төдий				136					
	Өмнөд төдий				137					
Ор					138					
	Хээрийн (харьцамгүй хуурай)	Нугал-хээрийн			139					140
Хуурай хээр (сандууцар)	Нижээд хээрийн		141		142	143	144		145	146
	Атайн			147		148				
Цэцэгүү хээрийн ба заримдаг цэцгийн	Умард хуурай хээрийн		149	150	151	152	153	154	155	156
	Өмнөд хуурай хээрийн				158	159	160	161	162	163
Шал	Цэцэгүү хээрийн		165	166	167	168	169	170	171	172
	Заримдаг цэцгийн		173	174	175	176	177	178	179	180
Хөд	Умард цэцгийн			182		183	184		185	186
	Өмнөд цэцгийн			188		189		190		191
Хөд	Хөд		194		195		196		197	198
									199	

БҮСИЙН БУС ХӨНДИЙ, ХОТГОРЫН ЛАНДШАФТ

Төрөл	Зонилгоо	Давалдаг		
		30%	20%	10%
Наран ой (элсэн газар)	200			
Торноо				
	Жинхэнэ	202		
Нууц	Нөмөрхөг	203		
	Хээршил биеэл	204		
	Дөвсгөрхөг	205		
Марал-маргал хам бүрдэл	206			
Марс	207			
Шал тойром	208			
Элсэн хам бүрдэл	209			



БАЙГАЛИЙН МУЖЛАЛТЫН ХИЛ ЗААГ

их мужийн
мужийн
дэд мужийн

районы
дэд районы

БАЙГАЛИЙН РАЙОНУУДЫГ БҮЛЭГЛЭСЭН НЬ
А. Бүс-бүслүүрийн (зонхилогч ба дагалдагч) ландшафтаар

1. Ан сарьдагийн
2. Уулын нугын
3. Дундай талын өмнөд талын
4. Ар хажуугийн ойн
5. Ойн

6. Ойт хээрийн
7. Хээрийн
8. а б в д е өмнөд уулын хээрийн дунд хээрийн өмнөд хээрийн

9. Цөлгүй хээрийн ба заримдаг цөлийн ацелуу хээрийн ба заримдаг цөлийн

10. Цөлийн аумар цөлийн бөмбөр цөлийн эхлэл гандуу цөлийн

Б. Бүсийн бүс (зонхилогч ба дагалдагч) ландшафтаар

1. Нууц
2. Марсаат
3. Эзэний

БАЙГАЛИЙН РАЙОНУУД ДАХЬ ДАГАЛДАГЧ ЛАНДШАФТ

А. Бүс бүслүүрийн

1. Мөнх цасны
2. Сарьдаг орчмын
3. Уулын нугалт-хээрийн

Б. Бүсийн бүс

1. Эзэсн дээрх нерсан ой
2. Торлог
3. Марса-марсаат хөм бүрдэл
4. Шал тойром

ДАГАЛДАГЧИЙН ХАРЬЦАА (хувиар)


Уулын 30% 20% 10% бага
Ландшафтын 30% 20% 10% бага
Хотгорын 30% 20% 10% бага

Уул
Тал
Хотгор

Гадаргын 20%-иас дээш 20%-иас доош

МУЖЛАЛТЫН НЭГЖ ТУС БҮРИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- I Хангай-Хэнтийн уулархаг их муж**
- I₁ Хөвсгөл нуур орчмын хөмбөн-цүлдэм уул, тэгш өндөрлөг, риафтын хотгорын муж**
- Район:
- 1 Сарьдаг орчмын ландшафт (10%-иас бага) бүхий ан сарьдагийн
 - 2 Нууц (10-20%), торлог (10%-иас бага) бүхий дундай талын
 - 3 Дундай талын (10-20%), өмнөд талын (10-20%), сарьдаг орчмын ландшафт (10%-иас бага), торлог (10%-иас бага) бүхий ан сарьдагийн
 - 4 Хээр (20-30%), ой (20-30%), торлог (10%-иас бага) бүхий нуган
 - 5 Дундай талын (10-20%), сарьдаг орчмын ландшафт (10%-иас бага), уулын нууц (10%-иас бага), торлог (10%-иас бага) бүхий ан сарьдагийн
 - 6 Хээр (10%-иас бага), нууц (10%-иас бага) бүхий өмнөд талын
 - 7 Ар хажуугийн ой (20-30%), ан сарьдаг (10-20%) бүхий уулын нуган
- I₂ Хөвсгөл нуурын зүүн талын цүлдэм дундаг өндөр уул, тэгш өндөрлөг бүхий талын дэд муж**
- Район:
- 8 Дундай талын (20-30%), сарьдаг орчмын ландшафт (10%-иас бага), торлог (10%-иас бага) бүхий ан сарьдагийн
 - 9 Дундай талын (20-30%), торлог (10%-иас бага) бүхий өмнөд талын
 - 10 Дундай талын (10-20%), хээр (10%-иас бага), нууц (10%-иас бага) бүхий өмнөд талын
 - 11 Дундай талын (20-30%), ой (10%-иас бага), торлог (10%-иас бага) бүхий өмнөд талын
 - 12 Өмнөд талын (10-20%), ар хажуугийн ой (10%-иас бага), хээр (10%-иас бага) бүхий ойн
- I₃ Сенгилений хөмбөн-цүлдэм уулт өндөрлөгийн уулын-нууц, ар хажуугийн ойн дэд муж**
- Район:
- 13 Ар хажуугийн ой (20-30%), өмнөд хуурай хээр (10-20%), хээр (10%-иас бага) бүхий умар хуурай хээрийн
 - 14 Уулын нууц (20-30%), өмнөд талын (10-20%), хээр (10%-иас бага) бүхий ар хажуугийн ойн
 - 15 Дундай талын (20-30%), ар хажуугийн ой (20-30%) бүхий уулын нуган
 - 16 Ар хажуугийн ой (10%-иас бага) бүхий уулын нуган
 - 17 Хээр (20-30%), уулын нууц (10%-иас бага) бүхий ар хажуугийн ойн
- I₂ Орхон-Сэлэнгэ мөрний сав газрын хөмбөн-цүлдэм уул, хотгорын муж**
- Район:
- 18 Ойт хээр (20-30%), умар хуурай хээр (10-20%), ойт хээр (10%-иас бага), нууц (10%-иас бага) бүхий ойт
 - 19 Ойт хээр (10-20%), хээр (10-20%), нууц (10%-иас бага) бүхий ойн
 - 20 Дундай талын (20-30%), торлог (10-20%) бүхий өмнөд талын
 - 21 Ойт хээр (20-30%), хээр (10-20%), умар хуурай хээр (10%-иас бага) бүхий ойн
 - 22 Ойт хээр (10-20%), ойт хээр (10%-иас бага) бүхий ойт хээрийн
 - 23 Хээр (10-20%), ойт хээр (10-20%), хээр (10%-иас бага) бүхий умар хуурай хээрийн
 - 24 Ойт хээр (10-20%), ойт хээр (10-20%), хээр (10%-иас бага) бүхий ойт хээрийн
 - 25 Ойт хээр (10-20%), умар хуурай хээр (10-20%), ойт хээр (10%-иас бага) бүхий умар хуурай хээрийн
 - 26 Өмнөд хуурай хээр (20-30%), нууц (10-20%), мөрс-мөрс (10%-иас бага) бүхий умар хуурай хээрийн
 - 27 Өмнөд хуурай хээр (10-20%), хээр (10%-иас бага), нууц (10%-иас бага) бүхий умар хуурай хээрийн
- I₂ Орхон-Туул голын сав газрын нам уул, хотгор бүхий хуурай хээрийн дэд муж**
- Район:
- 17 Ой (10-20%), умар хуурай хээр (10-20%), нууц (10%-иас бага) бүхий ойт хээрийн
 - 18 Хээр (10-20%), умар хуурай хээр (10-20%), мөрс (10%-иас бага) бүхий ойт хээрийн
 - 19 Наро (10-20%), нууц (10-20%), мөрс-мөрс (10%-иас бага) бүхий умар хуурай хээрийн
 - 20 Ой (20-30%), умар хуурай хээр (10-20%), ойт хээр (10%-иас бага) бүхий ойт хээрийн
 - 21 Нууц (10-20%), хээр (10%-иас бага) бүхий умар хуурай хээрийн
 - 22 Умар хуурай хээр (10-20%), хээр (10%-иас бага) бүхий ойт хээрийн
 - 23 Ойт хээр (10%-иас бага) бүхий умар хуурай хээрийн
 - 24 Нууц (10-20%), бүхий умар хуурай хээрийн
 - 25 Хээр (20-30%), ойт хээр (20-30%), ой (10%-иас бага) бүхий умар хуурай хээрийн
 - 26 Өмнөд хуурай хээр (20-30%), нууц (10-20%), мөрс-мөрс (10%-иас бага) бүхий умар хуурай хээрийн
 - 27 Өмнөд хуурай хээр (10-20%), хээр (10%-иас бага), нууц (10%-иас бага) бүхий умар хуурай хээрийн
- I₃ Хэнтийн хөмбөн уулт өндөрлөгийн муж**
- I₃ Хэнтийн уулт өндөрлөгийн баруун хойш хэсгийн ой, талын дэд муж**
- Район:
- 1 Өмнөд талын (10%-иас бага), ойт хээр (10%-иас бага), торлог (10%-иас бага) бүхий ойн
 - 2 Дундай талын (20-30%), сарьдаг орчмын ландшафт (10%-иас бага), торлог (10%-иас бага) бүхий өмнөд талын
 - 3 Ойт хээр (10-20%), нууц (10%-иас бага) бүхий өмнөд талын
 - 4 Ойт хээр (20-30%), нууц (10%-иас бага) бүхий өмнөд талын
 - 5 Өмнөд талын (10-20%), сарьдаг орчмын ландшафт (10%-иас бага), ан сарьдаг (10%-иас бага), торлог (10%-иас бага) бүхий дундай талын
 - 6 Торлог (20-30%), ой (10%-иас бага) бүхий өмнөд талын
 - 7 Өмнөд талын (20-30%), ойт хээр (10%-иас бага) бүхий ойн
 - 8 Дундай талын (10-20%), торлог (10%-иас бага) бүхий өмнөд талын
 - 9 Сарьдаг орчмын ландшафт (20-30%), дундай талын (20-30%), торлог (10%-иас бага) бүхий ан сарьдагийн
 - 10 Умар хуурай хээр (20-30%), ойт хээр (10%-иас бага) бүхий ойт хээрийн
- I₃ Хэнтийн уулт өндөрлөгийн зүүн хэсгийн ойт хээр, умар хуурай хээрийн дэд муж**
- Район ба дэд район:
- 11 Өмнөд талын (20-30%), ойт хээр (10-20%), торлог (10%-иас бага) бүхий ойн
 - 12 Ой (20-30%), нууц-хээр (10-20%), нууц (10-20%) бүхий ойт хээрийн
 - 13 Өмнөд талын (10-20%), нугалт-хээр (10%-иас бага) бүхий ойт хээрийн
- I₄ Онон-Улз голын сав газрын хөмбөн-цүлдэм нам уул, хотгор, суурь тал бүхий хээр, хуурай хээрийн муж**
- Район:
- 1 Нууц (20-30%), мөрс (10-20%) бүхий хээрийн
 - 2 Ойт хээр (20-30%) бүхий ойн
 - 3 Ойт хээр (10%-иас бага), нууц (10%-иас бага), умар хуурай хээр (10%-иас бага) бүхий нугалт-хээрийн
 - 4 Нууц (20-30%), хээр (10-20%) бүхий умар хуурай хээрийн
 - 5 Нууц (20-30%), умар хуурай хээр (10-20%) бүхий хээрийн
 - 6 Ойт хээр (10-20%), умар хуурай хээр (10%-иас бага) бүхий нугалт-хээрийн
 - 7 Нууц (10-20%), ойт хээр (10%-иас бага), умар хуурай хээр (10%-иас бага) бүхий нугалт-хээр
 - 8 Ойт хээр (20-30%) бүхий нугалт-хээрийн
 - 9 Өмнөд хуурай хээр (10-20%), хээр (10%-иас бага) бүхий умар хуурай хээрийн
 - 10 Ойт хээр (10-20%), умар хуурай хээр (10%-иас бага) бүхий нугалт-хээрийн
 - 11 Хээр (10%-иас бага), мөрс-мөрс (10%-иас бага) бүхий умар хуурай хээрийн
 - 12 Нууц (10%-иас бага) бүхий умар хуурай хээрийн
 - 13 Умар хуурай хээр (10-20%), мөрс-мөрс (10-20%) бүхий өмнөд хуурай хээрийн
- I₅ Хангайн хөмбөн-цүлдэм уулт өндөрлөгийн муж**
- I₅ Хан Хөхийн нуурын дундаг өндөр, бэлэрхэг уул бүхий хээр, хуурай хээр, ар хажуугийн ойн дэд муж**
- Район:
- 1 Умар хуурай хээр (10-20%), ар хажуугийн ой (10-20%), өмнөд хуурай хээр (10-20%) бүхий хээрийн
 - 2 Хээр (10-20%), умар хуурай хээр (10-20%), өмнөд талын (10%-иас бага), уулын нууц (10%-иас бага) бүхий ар хажуугийн ойн
 - 3 Ар хажуугийн ой (10-20%), хээр (10-20%), өмнөд хуурай хээр (10-20%) бүхий умар хуурай хээрийн



- БАЙГАЛИЙН ИХ МУЖ**
- Хангай-Хэнтийн уулархаг их муж
 - Төв Азийн өндөрлөг мал, хотгор, уул их муж
 - Их Ханганы уулархаг их муж

- ХАМГААЛАЛТАД БАЙГАА БАЙГАЛИЙН БИЕТ НУТАГ ДЭВСГЭР**
- Ус хамгааллын бүс
 - Мой огтлохыг хориглосон газар
 - Ой
 - Зог
 - Рашаан

- ХАМГААЛАЛТАД БАЙГАА ХОВОР БА ҮНЭТ УРГАМАЛ**
- Гацуур урван тус газар
 - Шинэний тархцын өмнөд зах
 - Тоорино төлөл
 - Хуш (өмнөд захын)
 - Зог (хойт захын)
 - Долуу сөншлө
 - Чандраана
 - Нягд
 - Монгол буйлас
 - Монгол алтан хундага
 - Цэвэг
 - Лийдэр
 - Чихэр өс

- ДАРХАН ЦААЗТАЙ БА ХОВОР АМЬТД**
- | | | | |
|------------|-----------|--------|-------------|
| Хулан | Бөхөн | Миня | Балбастор |
| Тахь | Хар сүүлт | Халуу | Шор шүүвү |
| Марал буза | Янаар | Ел | Ууль |
| Цаа буза | Ареаль | Тас | Тонжуул |
| Хандгай | Ирвас | Сар | Хун |
| Хүдэр | Булкаа | Гурууа | Хотон |
| Мозолай | Суусар | Хойлог | Хилэн загас |
| Хоетгай | | | |
- Тайлбар: Олон улсын Улаан намд орсон амьтдыг улаан өнгөнд тэмдэглэж үзүүлнэ.

- УЛСААС БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТАЛААР АВЧ БАЙГАА АРГА ХЭМНЭЭ**
- Аж үйлдвэрийн газруудын ус цэвэрлэх байгууламж
 - Хүрээлэн буй орчны бохирдлыг хянах лаборатори, цаг
 - Нахан сэрээх газар
 - Хөрсний эвдрэлээс хамгаалах цэрг хэмжээ авч байгаа газар
 - Ой ба таримал урсгал үржүүлэх газар
 - Эмийн ургамал тарьгаа газар
 - Түймэр эсэргүүцэх агаарын харуулын салбар
 - Ан амьтан үржүүлэх аж ахуй
 - Ан амьтан нутагшуулан газар
 - Байгаль хамгаалыг сурталчлах музей

Харгана бүхий хазар өмс-жижиг хялганат, жижиг хялгана-хазар өмс-өвст	Зун-намрын	Хөнгөн ямаа, адуу, тамзан
Хялгана-тогтворлоо-борлооц, бадлуур-жижиг хялгана-тооцот	Зун-намрын	Хөнгөн ямаа, адуу, тамзан
Шарлагат, шарлаг-жижиг хялгана-улаан бурвсанат, жижиг хялгана-бар бурвсанат, жижиг хялгана-бурвсанат	Намар-өвлийн	Хөнгөн ямаа, адуу, тамзан
Иванч хялгана-миланат, жижиг хялгана-борлооц, шарлаг-тооцот-жижиг хялганат члуурхаг	Зун-намрын	Хөнгөн ямаа
Бар бурвсанат-жижиг хялганат, бурвсанат-жижиг хялганат, жижиг хялгана-бурвсанат	Намар-өвлийн	Хөнгөн ямаа, тамзан


210 ТАРИАЛСАН ТАЛБАЙН БҮТЭЦ

Масштаб 1:9 000 000




211 УР ТАРИА ТАРИАЛСАН ТАЛБАН

Масштаб 1:9 000 000




212 ХУРААН АВСАН НИЙТ УР ТАРИА

Масштаб 1:9 000 000




213 ТӨМС, ХҮНСНИЙ НОГОО

Масштаб 1:9 000 000




214 ТЭЖЭЭЛИЙН УРГАМАЛ


Масштаб 1:9 000 000



215 ГАЗАР ТАРИАЛАГЧИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН


Масштаб 1:9 000 000





217 100 ГА ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭДЭЛБЭРТ НОГДОХ ХӨДӨӨ АЖ АХУЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

Масштаб 1:12 000 000




100 га ХӨДӨӨ АЖ АХУЙН ЭДЭЛБЭРТ НОГДОХ ХӨДӨӨ АЖ АХУЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн байгууллагасар (млн. төгрөг)

5.0-өөс дээш	1.5-2.0
2.0-5.0	1.0-1.5
	1.0-ээс доош

218 ХӨДӨӨ АЖ АХУЙД АЖИЛЛАГА НЭГ ХҮНД НОГДОХ ХӨДӨӨ АЖ АХУЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН


Масштаб 1:12 000 000




ХӨДӨӨ АЖ АХУЙД АЖИЛЛАГА НЭГ ХҮНД НОГДОХ НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн байгууллагасар (млн. төгрөг)

15-өөс дээш	7-10
10-15	5-7
	5-өөс доош


216 ХӨДӨӨ АЖ АХУЙН МУЖЛАЛТ
Масштаб 1:3 000 000



219 ХӨДӨӨ АЖ АХУЙН МУЖИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ
Масштаб 1:12 000 000




220 АН АГНУУР
Масштаб 1:12 000 000




ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮНДСЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ БЭЛТГЭЛ


221 МАХ
Масштаб 1:12 000 000




225 БОДЫН ШИР
Масштаб 1:12 000 000




222 СҮҮ
Масштаб 1:12 000 000




226 ХОНИНЫ НООС
Масштаб 1:12 000 000




223 ҮР ТАРИА
Масштаб 1:12 000 000




227 ЯМААНЫ НООС, НООЛУУР
Масштаб 1:12 000 000



224 ХОНЬ, ЯМААНЫ АРС
Масштаб 1:12 000 000



228 ТЭМЭЭНИЙ НООС
Масштаб 1:12 000 000



АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА

Энэ бүлгийн зургууд БНМАУ-ын аж үйлдвэр, барилгын салбарыг нутаг дэвсгэр болон үйл ажиллагааны нь байдлаар тодорхойлон харуулсан юм. Аж үйлдвэрийн зургуудыг зохиоходоо аж үйлдвэрийн олон салбарыг иж бүрэн зураглах зарчмыг баримтлав. Эдгээр зурагт аж үйлдвэрийн цогцолборын үндсэн ба туслах салбар, улс ардын аж ахуйн бусад салбартай тэдгээрийн холбогдох уялдаа холбоо, уг салбаруудын түүхий эдийн бааз болон бүтээгдэхүүний хэрэглээ зэргийг аль болох бүрэн тусгаж үзүүлсэн байна. Зургуудад хавсаргасан диаграмм, графикаар аж үйлдвэрийн салбаруудын бүтэц, өсөлтийн хурд, нэг хүнд ногдох бүтээгдэхүүний хэрэглээг харуулав.

Аж үйлдвэрийн зураглалд үйлдвэрийн төвийн хэмжээг илэрхийлэх нэгдмэл үнэмлэхүй шатлал боловсруулж хэд хэдэн зурагт хэрэглэсэн нь тэдгээрийг хооронд нь жишиж болохуйц болгов. Зураглан үзүүлж буй зүйлийн бодит чанарыг хангахын үүднээс тухайн салбарын томоохон үндсэн үйлдвэрүүд бүхий аж үйлдвэрийн төвөөс гадна орон нутгийн хүн амын хэрэгцээ, юуны өмнө өргөн хэрэглээний барааны хэрэгцээг хангахад чухал үүрэгтэй жижиг үйлдвэрийн төвүүдийг ч бас хамааруулсан юм.

Энэ бүлгийн зургуудыг боловсруулахад БНМАУ-ын статистикийн тоо баримт болон БНМАУ-ын Төлөвлөгөө, эдийн засгийн улсын хороо, ШУА-ийн Эдийн засгийн хүрээлэнгээс явуулсан судалгааны материалыг гол үндэс болгов.

БНМАУ бол эрчимтэй хөгжиж буй аж үйлдвэр, их барилгын салбар бүхий орон юм. Тус орны аж үйлдвэрт одоогоор уулын олборлох салбар, түүхий эдийн анхны боловсруулалт хийх үйлдвэрийн салбар зонхилохын хамт хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах, мөн түүнчлэн түлш эрчим хүч, их барилгын салбарт эдийн засгийн интеграцын үйл явц илүү эрчимтэй, өргөн хүрээтэй явагдаж байна.

1985 оны байдлаар тус орны үндэсний орлогод аж үйлдвэрийн эзлэх хувийн жин 32,6% байв. Одоо гадаадад гаргадаг бүтээгдэхүүний 80 шахам хувь, үйлдвэрлэлийн үндсэн фондын 50 гаруй хувь аж үйлдвэрийн салбарт оногдож байна.

БНМАУ-ын аж үйлдвэрийн хөгжил нь үйлдвэрийн газруудыг бүтээгдэхүүн хэрэглэгч болон түүхий эдийн эх булагт ойр дөт байлгах үйлдвэрлэлийн социалист байршлын зарчимд үндэслэсэн юм. Таван жилийн төлөвлөгөөтэй болж эхлэх үе хүртэл бараг бүх үйлдвэрийн газрууд Улаанбаатарт төвлөрч байсан бол одоо тус оронд Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Чойбалсангийн аж үйлдвэрийн зангилаанууд бүрэлдэн хөгжиж байна. Тэдгээрийн үйлдвэрлэлийн бүтэц, тус орны аж үйлдвэрт эзлэх хувийн жин, мөн эдгээг хүртэл бүрэлдэн тогтсон аж үйлдвэрийн бүх төвийн үүрэг үйл ажиллагааг «Аж үйлдвэрийн төвүүдийн хэвшинж» гэсэн зурагт тодорхойлон харуулав.

Сүүлийн жилүүдэд тус орны аж үйлдвэрийн салбарт бүтцийн чухал дэвшил гарлаа. Тухайлбал, түлш-эрчим хүчний үйлдвэр түрүүлэнгүй хурдацтай хөгжиж, уул уурхайн үйлдвэр аж үйлдвэрийн нэг гол салбар болсны хамт мод боловсруулах болон барилгын материалын үйлдвэр өргөжиж, шинэ салбар болох металл боловсруулах (сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэх, машин тоног төхөөрөмж засварлах) үйлдвэрлэл бүрэлдэн бий боллоо.

Монгол орон түлшний аж үйлдвэрийг цаашид хөгжүүлэх таатай бааз суурьтай юм. Тус оронд чулуун ба хүрэн нүүрсний 140 гаруй орд газар илрүүлсэн бөгөөд тэдгээрийн нийт нөөц нь хэдэн арван миллиард тонноор хэмжигдэж байна. 1985 онд улсын хэмжээгээр 6 сая гаруй тонн нүүрс гаргасан нь 1940 онд олборлосон хэмжээнээс даруй 37 дахин их ажээ. Нүүрс олборлох гол үйлдвэр гэвэл Налайхын нүүрсний уурхай, Шарынголын ил уурхай юм. Түүнчлэн VII таван жилд Багануурын нүүрсний уурхай шинээр ашиглалтад орлоо. Түүний дэргэд Багануур хот цогцлон босч байна.

БНМАУ-ын эрчим хүчний үйлдвэрлэлийг аж үйлдвэрийн томоохон төвүүдэд байрласан дулааны цахилгаан станц, бусад олон дизель станц бүрэлдүүлж байна. Цахилгаан станцын нийт хүчин чадал явуулын төхөөрөмжийн хамт 1960 онд 60,9 мян. кВт байсан бол 1985 онд 758 мян. кВт болжээ. Тус оронд 1940 онд нэг хүнд 15,5 кВт цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж байсан бол 1985 онд 1474,7 кВт цаг болж өсжээ.

1978 онд БНМАУ-ын эдийн засгийн Төв мужийг хамарсан эрчим хүчний нэгдсэн систем (ЗСБНХУ-ын нутаг дахь Галуут нуурын цахилгаан станцаас Эрдэнэт хүртэлх цахилгаан дамжуулах шугамаар) Сибирийн эрчим хүчний системтэй холбогдож, улмаар ЗСБНХУ-ын эрчим хүчний нэгдсэн систем болон ЭЗХТЗ-ийн гишүүн орнуудын нэгдмэл системд багтсан билээ.

БНМАУ-ын уул уурхайн аж үйлдвэр 1970-аад оны эхнээс буюу ялангуяа улс ардын аж ахуйг хөгжүүлэх VI таван жилийн төлөвлөгөөг баталснаас хойш түргэн хурдтай хөгжиж ирсэн юм. Энэ хугацаанд монгол-зөвлөлтийн «Монгол-совцветмет» үйлдвэрлэлийн нэгдэл, уулын баяжуулах «Эрдэнэт» комбинат байгуулагдав. Түүнчлэн 1980 оноос тус оронд «Монголчехословак металл», «Монголболгар металл» зэрэг хамтын үйлдвэрүүд ажиллаж эхэллээ. Одоо уул уурхайн аж үйлдвэр зэс-молибден, хайлуур жонш олборлож баяжуулах «Эрдэнэт», «Бор-Өндөр» комбинат, мөн хайлуур жонш, өнгөт чулуу олборлох, цагаан тугалга болон бусад өнгөт металл олборлох үйлдвэрүүдээс бүрдэл болж байна. Хайлуур жонш олборлож гадаадад гаргах талаар тус орон дэлхийд тэргүүн байрын нэгийг эзлэх боллоо.

Химийн аж үйлдвэр, аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлд одоогоор ялимгүй хувийг эзэлдэг боловч тус орны улс ардын аж ахуйд чухал үүрэг гүйцэтгэж өндөр хурдтай хөгжиж байна. Химийн үйлдвэрийн бүтээгдэхүүн гаргалт 1960 оноос 1985 онд 11,1 дахин, үндсэн фонд нь 30,2 дахин өсжээ.

Металл боловсруулах аж үйлдвэрээс юуны өмнө авто засварын салбарыг дурьдвал зохино. 1968 онд Улаанбаатарт авто засварын завод барьж ашиглалтад оруулснаар авто засварын үйлдвэрийн үндсийг тавьжээ. Авто засварын газрууд мөн Чойбалсан, Ховд, Улиастай хотод бий. Улаанбаатарт илчт тэрэгний зүтгүүр болон хөдлөх бүрэлдэхүүний засварын газар, олонх аймгийн төвд хөдөө аж ахуйн машин техникийн засварын газар ажилладаг. Түүнчлэн Улаанбаатарт уурын тогоо, сэгсрэх машин, ноос угаах төхөөрөмж, тоосгоны пресс зэргийг үйлдвэрлэдэг төмрийн завод ажиллаж байна.

Аж үйлдвэрийн бусад гол салбар гэвэл хөнгөн, хүнсний үйлдвэр юм. Сүүлийн жилүүдэд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд эдгээр салбарын эзлэх хувийн жин бага зэрэг буурсан хэдий боловч хөнгөн, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үнэмлэхүй өсөлт нь ард түмний аж байдал, соёлын төвшинг байнга дээшлүүлэх зорилтыг дэс дараатай шийдвэрлэх болон улс орны экспортын потенциалыг үлэмж өргөтгөх боломж олгож байгаа юм.

1985 оны байдлаар хөнгөн үйлдвэрийн салбар, улсын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 27 хувийг үйлдвэрлэж, аж үйлдвэрт ажиллагчдын 30 гаруй хувь тус салбарт хамрагдаж байв. Тус салбарын томоохон үйлдвэрийн тоонд ноос угаах 5 фабрик, ямааны ноолуур, тэмээний ноосон эдлэл үйлдвэрлэдэг «Говь» комбинат, шир боловсруулах ба хиймэл ширний завод, түүнчлэн эрмэлзийн, нэхмэлийн, эсгий-эсгий гутлын, гутлын, оёдлын, нэхий эдлэлийн, сүлжмэлийн, хивсний үйлдвэр зэрэг газрууд орно.

Хүнсний аж үйлдвэрийн салбарт 1985 оны байдлаар улсын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн гаргалтын 16,5%, үйлдвэрлэлийн үндсэн фондын өртөгийн 11%, бүх ажиллагчдын 16,1% ногдож байв. Энэ салбар үндсэндээ хүнсний нийт бүтээгдэхүүний 80 гаруй хувийг үйлдвэрлэдэг улсын чанартай 30 шахам томоохон үйлдвэрээс бүрддэг. Хүнсний бүтээгдэхүүний бусад хувийг мал нядалгааны механикжаагүй цэг, цөцгийн тос боловсруулах болон гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх цех, мөн ихэнхдээ багсармал тэжээлийн хэсэг бүхий гурилйн үйлдвэрүүд гаргадаг юм.

Ой, мод боловсруулах аж үйлдвэр 1985 онд тус орны аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 10%-ийг гаргаж байлаа. Энэ салбарын томоохон үйлдвэрүүд болох Ерөө, Хялганатын ой мод бэлтгэлийн аж ахуй Монгол орны хойт хэсгийн ой бүхий нутагт байрладаг. Тус салбарт хамаарах гол үйлдвэрийн тоонд Сүхбаатар, Тосонцэнгэл хотын мод боловсруулах комбинат, Улаанбаатарын мебель-картоны үйлдвэр орно.

БНМАУ-д барилгын материалын аж үйлдвэр амжилттай хөгжиж байна. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүнд тус салбарын эзлэх хувийн жин 1985 онд 7% орчим байв. Энэ салбарын үндсэн үйлдвэрүүдэд Улаанбаатар, Дархан хот дахь байшин үйлдвэрлэх комбинат, керамзитын үйлдвэр, Дарханы цемент, царуц тосгоны үйлдвэр, Улаанбаатарын хөнгөн бетон, тоосгоны үйлдвэр, Улаанбаатар, Дархан, Чойбалсан, Багануур, Эрдэнэтийн барилгын үйлдвэрлэлийн томоохон баазууд, Ховд, Улиастай, Баянхонгор, Өлгий, Мандалговь, Баруун-Урт хот дахь төмөр бетон эдлэлийн үйлдвэрийн газар багтана.

БНМАУ-ын улс ардын аж ахуйн хөгжлийг илэрхийлэх нэг үзүүлэлт бол их барилгын өсөлтийн тогтвортой өндөр хурд мөн. Одоо их барилгын салбар тус улсын үндэсний орлогын 5 хувийг бий болгож байна. Хэтийн төвийг харахад хөрөнгө оруулалтын үндсэн хэсгийг (36%-ийг) аж үйлдвэрийн барилгад, юуны өмнө хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах салбарт чиглүүлэх юм.



Хөдөө аж ахуйг хөгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах Зорилтот программыг хэрэгжүүлэх нь хөдөө орон нутагт барилгын ажлыг их хэмжээгээр өргөжүүлэхийг шаардана. Тэрчлэн тээвэр, орон сууц-ахуйн барилга байгуулалтын цар хэмжээг ирээдүйд үлэмж нэмэгдүүлэх болно.

Энэ бүлгийн зургуудыг байгаль, хүн ам, хөдөө аж ахуйн болон бусад салбарын зургуудтай харьцуулан дүгнэж үзвэл тус орны үйлдвэрлэх хүчний байршилд гарсан зүй тогтол, түүний өөрчлөлтийн шинж байдлыг нарийвчлан судлах болон зарим салбарын хөгжил байршилд гарч буй тэнцвэрт бус байдлыг илрүүлэн арилгах арга замыг боловсруулах боломж олгоно. Эдгээр зургийг төлөвлөлтийн болон удирдах байгууллагууд тухайн салбарын хөгжлийн төвшин, байршлын онцлогтой танилцахад төдийгүй түүнийг хөгжүүлэх хэтийн төлөвлөгөө зохиоход ашиглаж болох юм.


Энэ бүлэгт орсноо бүх зургийн агуулга нь улс орноо хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орноос аж үйлдвэр-хөдөө аж ахуйн орон болгон хувиргах МАХН-ын Програмын чиг шугам амьдралд амжилттай хэрэгжиж аж үйлдвэр, барилгын бүх салбар давшингүй хөгжиж байгаа хийгээд монголын ард түмний материаллаг аж байдал, соёлын төвшин хэлбэрлэлтэй дээшилж байгааг илтгэн харуулж байна.

АЖ ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖИЛ


Масштаб 1:12 000 000




АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ САЛБАРЫН БҮТЭЦ, 1940 он (хувиар)




АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ САЛБАРЫН БҮТЭЦ, 1960 он (хувиар)




АЖ ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЭЛИЙН ҮНДСЭН ФОНДЫН САЛБАРЫН БҮТЭЦ, 1980 он (хувиар)




АЖ ҮЙЛДВЭРИЙН АЖИЛЧИН АЛБАН ХААГЧДЫН САЛБАРЫН БҮТЭЦ, 1980 он (хувиар)



АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ САЛБАРЫН БҮТЭЦ, 1980 он (хувиар)




АЖ ҮЙЛДВЭРИЙН ЦЭГ (нөхт бүтээгдэхүүний хэмжээгээр)




Аж үйлдвэрийн салбар

- Эрчим хүчний
- Уул уурхайн
- Нарийн ажирлах
- Түүшний
- Металл боловсруулах
- Хөмийн
- Барилгын материалын
- Ов, мод боловсруулах
- Хөнгөн
- Хүнсний
- Бусад салбар


АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨМЧИЙН ХЭЛБЭРЭЭР (1967 оны үн хөлхөх үнээр, сая төгрөг)




АЖ ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛДВЭРЭЛИЙН ҮНДСЭН ФОНД (түүхэн оны цэвэр үнээр, сая төгрөг)



Үндэсний орлогод аж үйлдвэрийн эзлэх хувь




АЖ ҮЙЛДВЭРИЙН АЖИЛЧИН, АЛБАН ХААГЧДЫН НИЛЭЙН ДУНДАМ ТОО (млн.хүн)



232 АЖ ҮЙЛДВЭРИЙН ТӨВҮҮДИЙН ХЭВШИНЖ

Масштаб 1:6 000 000




- ЭДИЙН ЗАСГИЙН МҮН
- Өрнөд
 - Төв
 - Дорнод

АЖ ҮЙЛДВЭРИЙН ТӨВ

Үйлдвэрлэлийн нутаг Баясгалийн зохион байгуулалтын хэлбэр	Бүрдэлтийн үе шат		
	Бүрдэлэн төгссөн	Бүрдэлэн буй	Хөтийн
Аж үйлдвэрийн заналдаа			
Аж үйлдвэрийн төв			
Аж үйлдвэрийн цэг			



Нутгад баясгалийн төрлийн	Мул хэрэгсэл	Мулж	Орон нутгийн
Головч салбар			
Эрчим хүчний			
Уул уурхайн			
Түүшний			
Металл боловсруулах			
Барилгын материалын			
Ов, мод боловсруулах			
Хөнгөн			
Хүнсний			

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД ЭДИЙН ЗАСГИЙН МҮНҮҮДИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, 1985 он




АЖ ҮЙЛДВЭРИЙН ЗАНГИЛААНУУДЫН САЛБАРЫН БҮТЭЦ, 1985 он (хувиар)

- Эрчим хүчний
- Уул уурхайн
- Түүшний
- Металл боловсруулах
- Хөмийн
- Барилгын материалын
- Ов, мод боловсруулах
- Хөнгөн
- Хүнсний
- Бусад салбар




233 ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ АЖ ҮЙЛДВЭР

Масштаб 1:6 000 000




234 ТҮЛШ ХЭРЭГЛЭЭ

Масштаб 1:12 000 000




235 ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧ ХЭРЭГЛЭЭ

Масштаб 1:12 000 000





236 УУЛ УУРХАЙН АЖ ҮЙЛДВЭР ХИМИЙН АЖ ҮЙЛДВЭР

Масштаб 1:12 000 000



237 МЕТАЛЛ БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭР, ЗАСВАРЫН БААЗ


Масштаб 1:6 000 000



- Металл боловсруулах үйлдвэр**
- Сэлбэж хэрэгсэлийн үйлдвэрлэл
 - Металл эдийн засгийн үйлдвэрлэл
- Засаар**
- сэлбэмшлэнэ
 - борилтын машин, механизмын
 - цахилгаан, эрчим хүчний үйлдвэрийн туслах төхөөрөмжийн
 - хөдөө аж ахуйн туслах төхөөрөмжийн
 - мод боловсруулах үйлдвэрийн туслах төхөөрөмжийн
 - усны аж ахуйн туслах төхөөрөмжийн
 - хөдөө аж ахуйн машин, парктормын
 - бусад төрлийн техникийн
- АЙМАГ ДУНДЫН БОЛОН ТОМ ҮЙЛДВЭРИЙН ЗАСВАРЫН ГАЗАР**
- уул уурхайн үйлдвэрийн
 - борилтын материалын үйлдвэрийн
 - мод боловсруулах үйлдвэрийн
 - усны аж ахуйн
 - Хөдөө аж ахуйн машин, парктормын засварын газар
- ТОМ ХУТУУМЫН АВТО ЗАСВАРЫН ЗАВОДЫН ҮЙЛЧЛЭХ БҮС**
- Улаанбаатарын
 - Чойбалсангийн
 - Хөвсгөлийн
 - Увсгайрын


238 ОЙ АШИГЛАЛТЫН МУЖУУД

Масштаб 1:12 000 000




239 ОЙ, МОД БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭР

Масштаб 1:6 000 000




240 ХӨНГӨН АЖ ҮЙЛДВЭР


Масштаб 1:6 000 000



ҮЙЛДВЭРИЙН ТӨВ, 1983 он
(нийт бүтээгдэхүүний өртөг, сая төгрөг)
1000-аас дээш



ХӨНГӨН АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЦ, 1983 он
(нийт бүтээгдэхүүний өртөг, хувиар)



ХӨНГӨН АЖ ҮЙЛДВЭРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ
(1960 он-1)



ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ
(1960 он-1)




ХӨНГӨН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРИЙН ТҮҮХҮЙ ЭДИЙН БҮС


Хөдөө аж ахуйн муж	Хөдөө аж ахуйн мужийн төрөлжилт
Хөвсгөл-Хөвсгөлийн	Мөх-сүүний үхэр, мөх-өх-шаруун ноост хоньны аж ахуй
Сэлэнгэийн	Үр тарваг, мөх-сүүний, ба сүүний үхэр, нарибартар ба шаруулар ноост хоньны аж ахуй
Булган-Хангайн	Үр тарвагны загварын салбар бүхий мөх-сүүний үхэр, нарибартар ба шаруулар ноост хоньны аж ахуй
Дорнод	Мөх-өх-шаруун шаруулар ноост хонь, малын үхэрний аж ахуй
Алтай-Их нууруудын хангаарын	Мөх-өх-шаруулар ноост хоньны аж ахуй зөнхлөх мал аж ахуй
Говьын	Мөх-өх-шаруулар ноост хонь, ямаа, ламанын аж ахуй

241 ХҮНСНИЙ АЖ ҮЙЛДВЭР


Масштаб 1:6 000 000




ҮЙЛДВЭРИЙН ТӨВ, 1983 он
(нийт бүтээгдэхүүний өртөг, сая төгрөг)
400-аас дээш




ХҮНСНИЙ АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЦ, 1983 он
(нийт бүтээгдэхүүний өртөг, хувиар)



ХҮНСНИЙ АЖ ҮЙЛДВЭРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ
(1960 он-1)



ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ
(1960 он-1)



ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

- Малыг
- Сүүний
- Гурвалын
- Арай, паваны
- Талхыг
- Чихэр, нарийн бөөс
- Бусад




ЗАГАС БАРИЛТ (жишээ тооноор)

- 150-аас дээш
- 150 хүртэл

○ Дотос олборлол
△ Цөөнхөн төрлийн үйлдвэр
* Төлөгний жижиг үйлдвэр

242 БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН АЖ ҮЙЛДВЭР

Масштаб 1:6 000 000




Үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүн	Үйлдвэрлэлийн хэмжээ
Цемент	1 км-10 млн тонн
Барилгын зуурмаг	10 км-1.0 млн м ³
Ханган бетон	1 км-1.0 млн м ³
Бетон	1 км-0.2 млн м ³
Тазар бетон	1 км-1.0 млн м ³
Бөсөө чулуу-бетонон сулбааз	1 км-50 ширхэг
Тосгоо	1 км-1.5 оял ширхэг
Шажоо	1 км-1.0 млн тонн
Вааран хамтандар	1 км-10 млн м ²
Норомжит	1 км-10 млн м ²

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭНД БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, өлсөөр, 1983 он	
18.0-аас дээш	4.0-8.0
8.0-18.0	4.0-өөс доош

АШИГЛАЖ БҮЙ ОРД ГАЗАР	
Илч бүрийн нисрэлгээтэй шажоо	Элс, эвэр-хайраан, хөлийн
Голтсгон, мөргц	Эрдсийн хөвөн үйлдвэрлэхэд хэрэглэгдэх чулуулаг
Эрдсийн хөвөн үйлдвэрлэхэд хэрэглэгдэх чулуулаг	Цемент, шажоо үйлдвэрлэхэд хэрэглэгдэх чулуулаг
Эрдсийн будаа	

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ, өлсөөр, 1981-1983 он (жилийн дундаж, сая төгрөг)



УЛС АРДЫН АЖ АХУЙН САЛБАР




Материаллаг үйлдвэрлэл	
Аж үйлдвэр	Барилга
Хөдөө аж ахуй	Тазар, халбаа
Худалдаа, бэлтгэл, нийгмийн хөөл, материал-техникийн хангамж	
Материаллаг бус үйлдвэрлэл	
Орон сууцны барилга, найз амьтан	Шинжлэх ухаан, соёл, боловсрол
Эрүүлэг хамгаалах, биеийн тамир	Удирдлага

НЭГ ХҮНД НОГДОХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ, өлсөөр (1981-1983 оны дундаж, төгрөг)


1500-аас дээш	300-1000
1000-1500	50-аас доош

243 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ


Масштаб 1:2 000 000



БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (1960 он-1)




БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЦ, 1983 он (нийт бүтээгдэхүүний өршөг, хувь)



244 БАРИЛГА

Масштаб 1:6 000 000




БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ (1960 он-1)



БАРИЛГА УГСРАЛТЫН БАЙГУУЛАГА	
Барилгын трест	Барилгын усралтын нөхөр
Зөм ашиглалтын өнгө	Усны аж ахуйн үйлдвэр газар
Нэгдсэн дундын үйлдвэр	Барилга засварын өнгө

АЙМАГ ДУНДЫН БАРИЛГА ТРЕСТИЙН ҮЙЛДЭХ БУС			
Билэ-Өвөр	Эрдэнэтийн	Дундговь	Дорнод
Завхан	Баянхонгор	Төв аймгийн	Дорнод аймгийн



ТЭЭВЭР, ХОЛБОО

Байгалийн нөхцөл, газар нутгийн хэмжээ, хүн амын олон цөөн, байгалийн нөөц баялагийн байршил, төвлөрөл, үйлдвэрлэх хүчний хөгжил, байршлын онцлог гэх мэт тодорхойлогч үндсэн хүчин зүйлийн үйлдэл нөлөөгөөр хүн ам, аж ахуйн тээврийн үйлчилгээний систем хэрхэн хөгжиж ирснийг энэ бүлгийн зургууд тусган харуулна.

Эдгээр хүчин зүйлийг тээврийн газарзүйн үүднээс авч үзсэн юм. Энэ бүлгийн зургуудыг зохиоход холбогдох яам газрын тайлан бүртгэлийн мэдээ, ном хэвлэл, эрдэм шинжилгээний баримт материалыг өргөн ашиглав.

Монгол орон хэдийгээр далайн төвшнөөс дээш өндөр өргөгдсөн уулархаг нутагтай боловч инженер-газарзүйн нөхцөлийн хувьд тээвэр хөгжүүлэн, төмөр зам, авто машины зам тавьж ашиглахад онцгой саад бэрхшээл үндсэндээ байхгүй. Томоохон нуруудаас бусад уулс нь ихэнхдээ элэгдэж мөлийсөн бөмбөгөр хэлбэртэй, гол төлөв налуу хажуутай, гадаргын хэрчигдлийн гүн ба нягтшил их биш юм. Уулс хоорондын өргөн хөндий, тал нутагт төрөл бүрийн замыг шулуун юм уу, эсвэл том радиустай муруй шугамаар тийм ч их эгц өгсүүр биш тавих боломжтой. Цөлөрхөг нутагт элсэн хунгар болон хуурай уур амьсгалын нөлөөгөөр үүсдэг геоморфологийн үйл явц замын хэвийн ажиллагаанд ямар нэг хэмжээгээр бэрхшээл учруулж болно. Агаарын тээвэр хөгжүүлэх тухайд гэвэл цаг агаарын байдлаар ч, онгоцны буудал байгуулах боломжийн хувьд ч байгалийн нөхцөл бүрэн тохиромжтой. Харин усзүйн сүлжээ сийрэг учир усан замын тээврийн үйлчилгээний хүрээ нэн хязгаарлагдмал юм. Гагцхүү Хөвсгөл нуур, Сэлэнгэ мөрөнд л хөлөг онгоц явуулах боломж бий. Бусад гол ус багатай, зөвхөн цөөн хэдэн голоор богино хугацаанд сал урсгах бололцоотой.

Байгалийн нөхцөлийн зарим онцлог, мөн түүнчлэн нийгэм-эдийн засгийн хөгжлийн хоцрогдлоос шалтгаалан тус оронд урт удаан хугацааны турш ердийн хөсгийн тээвэр дагнан үйлчилж байжээ.

Ардын хувьсгалын ялалтын дараа Монгол орны тээврийн үйлчилгээний системд үндсэн өөрчлөлт гарлаа. Энэ нь социалист нийгмийн байгууллын зүй тогтол үйл явц болон аж үйлдвэр, олон салбарт хөдөө аж ахуйн түргэн хөгжлийн үр дагавар юм. Хот, суурин, үйлдвэр, аж ахуйн газар барьж байгуулах, ашигт малтмалын орд газар эзэмших, ой болон байгалийн бусад нөөцийг ашиглахад нэвтрүүлэн өнгөрүүлэх чадал сайтай орчин үеийн төрөл бүрийн тээврийн зам харилцаа бий болгох шаардлага зүй ёсоор урган гарсан байна. Ялангуяа 1949—1955 онуудад тус улсын нутаг дэвсгэрийг хойноос урагшаа нэвт дайрч гарсан төмөр зам тавьж ашиглалтад оруулсан явдал тээврийн системийн хөгжилд онцгой чухал үйл явдал болсон билээ. Уул замыг тавьснаар гадаад орнуудтай тээвэр-эдийн засгийн харилцааг эрчимжүүлэх боломж нээгджээ. Энэхүү гол тэнхлэг төмөр замын дагуу Улаанбаатар, Дархан, Сүхбаатар, Шарынгол, Эрдэнэт, Бор-Өндөр, Хөтөл зэрэг үндэсний аж үйлдвэрийн томоохон төвүүд бүрэлдэн тогтсон юм.

1940 оноос хойш авто тээвэр нэн эрчимтэй хөгжиж ирэв. Авто тээврийн үйлдвэрлэл-техникийн баазыг бий болгон бэхжүүлж, авто замын сүлжээг өргөтгөн сайжруулсны үр дүнд авто машины тоо ихээхэн нэмэгдэж, ашигт ажиллагаа нь дээшилж, үйлчлэх хүрээ нь өргөжсөн байна. Баруунаас зүүн тийш өргөргийн дагуу оршдог Өлгий—Ховд—Алтай—Арвайхээр—Улаанбаатар—Өндөрхаан—Чойбалсангийн чиглэлийн улсын ач холбогдолтой гол авто замын ашиглалт тогтмолжжээ. Уртрагийн дагуух авто замаас төмөр замын гол тэнхлэгтэй зэрэгцээ оршдог чиглэлийн зам, ялангуяа түүний Улаанбаатар хотоос хойших хэсэг ачааллаараа бусдаас илүү юм. Тогтмол үйлчилгээтэй авто замын сүлжээ тус улсын хойт хагаст харьцангуй шигүү, өмнөд хэсгийн заримдаг цөл ба цөл нутагт таруу байдаг нь хүн амын нягт сийргийн байдал болон нутаг дэвсгэрийг хэр зэрэг эзэмшсэнтэй холбоотой.

Аж үйлдвэр, хөдөө аж ахуйн зонхилох хэсэг төвлөрсөн тус орны хойт хэсэгт авто болон төмөр замын тээвэр эрчимтэй хөгжсөний зэрэгцээ усан замын ачаа тээврийн хэмжээ нэмэгдэв. Усан онгоц гол төлөв Хөвсгөл нуурт явдаг. Энэ нуурын хойт эрэгт байдаг Ханх, өмнөд эрэгт байдаг Хатгал буудлын хооронд өвлийн улиралд ч тээврийн үйл ажиллагаа зогсохгүй нуурын мөсөн дээгүүр авто машин болон ердийн хөсгөөр ачаа тээвэрлэх ажил үргэлжилдэг юм.

Анх 1926 онд ЗСБНХУ-ын иргэний агаарын тээврийн онгоц Улаан-Үдээс Улаанбаатарын чиглэлд нисэж эхэлсэн тэр үеэс Улаанбаатар хот олон улсын чанартай онгоцны буудлын үүргийг гүйцэтгэх болжээ. Одоо тус орны бүх хот, аймгийн төв, олон сум онгоцны буудалтай болж агаарын тээврийн тогтмол үйлчилгээгээр хангагджээ. Иргэний агаарын тээврийн зорчигч, шуудан, ачаа тээвэрлэлт жилээс жилд өсөн нэмэгдсээр байна.

БНМАУ-ын тээврийн систем бүхэлдээ үйлчилгээ, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын хувьд тогтвортой шинжийг олж, түүний бүрдэл хэсгүүд нь үйлчилж буй эдийн засгийн муж, дэд мужийнхаа хүрээнд зохицон бүрэлдсээр байна.

Тус орны янз бүрийн нутаг районы аж ахуйн төрөлжилт гүнзгийрч, гадаад дотоодын тээвэр-эдийн засгийн харилцаа хөгжсөний үр дүнд ачаа тээвэрлэлийн хэмжээ өсжээ. 1985 оны байдлаар бүх төрлийн тээврийн ачаа эргэлт 7905,2 сая.тонн-километр хүрснээс 75,4% нь төмөр замын тээвэрт,

24,5% нь авто тээвэрт, 0,1% нь усан замын болон агаарын тээвэрт оногдож байна. Тээврийн зангилаанууд болон төрөл бүрийн замын ачааллын хэмжээг ачаа урсгал, ачаа эргэлтийн зураг тодорхой харуулна. Үүнд, ялангуяа ачаа үүсгэх, дамжин өнгөрүүлэх, шингээх болон орон нутгийн тээврийн зангилаа бүхий ачаа урсгалын голлох чиглэлүүд ялгаран харагдана. БНМАУ-д ачаа урсгалын гол чиглэлд төмөр замаас гадна өргөргийн дагуух авто зам, мөн уртрагийн дагуу оршдог Улиастай—Алтайн чиглэлийн авто зам, Ханх—Хатгалын усан зам хамаарагдана. Хамгийн их ачаа урсгал Улаанбаатар төмөр замын гол шугамд ногдог. Төмөр замын нэлээд олон өртөө, авто зам болон агаарын тээврийн уулзвар болж төрөл бүрийн тээврийн томоохон зангилааны чухал хэсэг нь болдог.

Эдийн засгийн муж хоорондын болон мужийн доторх ачаа солилцох үйл ажиллагаа үндсэндээ төмөр замын өртөөгөөр дамждаг бөгөөд тэгэхдээ өртөө тус бүрийн ачаа эргэлтийн хэмжээ харилцан адилгүй байдаг. Жишээлбэл, Улаанбаатар төмөр замын дагуух ачаа тээвэрлэлийн 36% нь Улаанбаатар, Толгойт, Амгалан өртөөнд, 30% нь Дархан-I, Дархан-II, Салхит өртөөнд ногдоно. Энэ өртөөнүүд нь Улаанбаатарын, Дарханы гэсэн технологийн хувьд тус бүрдээ нэгдмэл шинжтэй тээврийн хоёр том зангилааг улам бүр бүрдүүлж байна. Улаанбаатарын зангилаа нь тээврийнхээ нэгдсэн үйл ажиллагаагаар (төмөр зам, авто зам, агаарын тээвэр хосолсноороо) ялгаатай. Дарханы зангилаа нь төмөр замын тээврийн дөрвөн чиглэлийн уулзвар болдог бөгөөд Улаанбаатарын гол чиглэлийн төмөр замаас гадна өөр хоёр чиглэлийн төмөр зам эндээс салаалдаг.

Тус орны дорнод хэсэгт Чойбалсан хот нийт тээврийн чухал зангилаа болж төмөр зам, авто, агаарын тээврийн нэгдмэл үйл ажиллагааг зохицуулна. БНМАУ-ын тээврийн бусад бүх зангилаа авто болон агаарын тээврийг хослуулсан үйл ажиллагаатай бөгөөд голдуу аймгийн төвүүдэд байрладаг.

Тээврийн зангилаанууд нь улсын эдийн засгийн хөгжил, соёлын амьдралд ихээхэн нөлөө үзүүлэхийн хамт нутаг дэвсгэр-үйлдвэрлэлийн нарийн бүтэцтэй системийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь билээ. Нутаг дэвсгэр-үйлдвэрлэлийн системийн бүх бүрэлдэхүүн хэсгийн харилцан үйлчлэл нь тээврийн үйлчилгээний өвөрмөц онцлогийг үлэмж хэмжээгээр тодорхойлно. Тээврийн зангилааны үүрэг, үйлчлэх хүрээ нь зөвхөн тухайн орон нутгийн нутаг дэвсгэр-үйлдвэрлэлийн хил хязгаараар зааглагдахгүйн зэрэгцээ байр байдал нь нэгэнт нэлээд тодорхой болсон улсын тээврийн нэгдсэн системийн үндсэн хэсэг болж байдаг юм.

Тээврийн цуврал зурагт БНМАУ-ын тээврийн нэгдсэн системийн үүсэл хөгжлийн явц, нутаг дэвсгэрийн ялгаа, техникийн төвшин, ачаа тээвэрлэлийн ажлын гүйцэтгэлийн хэмжээ ба одоогийн байдлыг тусган үзүүлсэн юм. Энэ бүхнийг нийгэм-эдийн засгийн бусад зургуудтай харьцуулан дүгнэж үзвэл тус улсын тээврийн хөгжлийн үндсэн чиглэлийг зөв тодорхойлох боломжийг олгоно.


БНМАУ-д холбооны бүх салбарыг багтаасан улсын холбооны нэгдсэн сүлжээний үндэс суурь тавигдсан юм. Тус орны улс ардын аж ахуй, хүн амын өдөр тутам өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг улсын холбоо үндсэнд нь хангаж байна. Холбооны материал-техникийн баазыг бэхжүүлсний дүнд сүүлийн жилүүдэд холбоогоор үйлчлэх цар хэмжээг нэмэгдүүлж, хэрэглэгчдэд улам ойртуулах боломж бүрдлээ. Улаанбаатар болон бусад томоохон хот, аймгийн төвүүдийн хооронд цахилгаан мэдээний 20-иод суваг үйлчилж байна. Одоогийн байдлаар бүх сумын төв, суурин газар аймгийнхаа төвтэй телефоноор холбогджээ. Хөдөө аж ахуйн нэгдлийн бригад, сангийн аж ахуйн тасаг, фермийн 80 гаруй хувь нь аж ахуйн төвтэйгөө телефон болон радио холбоогоор харилцдаг.

Радиоогийн үндэсний нэвтрүүлгийг Улаанбаатар, Чойбалсан, Алтай, Даланзадгад, Мөрөн, Өлгий, Сайншанд хотын радио өргөн нэвтрүүлгийн станц дамжуулж байна. Бүх хот, аймаг, сумын төв радио зангилаатай болжээ. Улаанбаатар хотод телевизийн төв байдаг бөгөөд бүх аймгийн төв, хот, түүнчлэн хөдөөгийн 220 гаруй суурин газарт телевизийн нэвтрүүлгийг хүлээн авч дамжуулдаг цэгүүд ажиллаж, БНМАУ-д одоо нийт өрхийн 60,8% нь телевизийн нэвтрүүлэг үзэх боломжоор хангагджээ. Радиорелейны шугамд ойр оршдог хот, суурингууд үндэсний телевизийн программыг радиорелейны шугамаар дамжуулан үздэг бөгөөд бусад хот, суурин газарт Зөвлөлт Холбоот Улсын төв телевизийн программыг сансрын холбооны «Экран» системээр дамжуулан хүлээн авч байна.


1960 оноос 1985 онд телефон-цахилгаан мэдээний шугамын урт 68,1 хувиар, телефон сувгийн урт 10,9 дахин, телефон станцын багтаамж 2,3 дахин, радио нэвтрүүлгийн станцын хүчин чадал 9 дахин нэмэгджээ.

Тус улсад нутаг дэвсгэр-үйлдвэрлэлийн бүрдлүүд (муж, цогцолбор, зангилаа, төвүүд) үүсч буй давшингүй явцыг чиг баримжаа болгон төрөл бүрийн тээвэр, холбооны системийн одоогийн байдал хийгээд түүнийг улам боловсронгуй болгох арга замыг зөв тодорхойлоход энэ бүлгийн зургуудыг ашиглаж болох бөгөөд үүнд эдгээр зургийн шинжлэх ухаан, практикийн ач холбогдол оршино.


245 ЗАМ ХАРИЛЦАА, 1985 он
Масштаб 1:4 500 000




246 ЗАМ ХАРИЛЦАА, 1940 он
Масштаб 1:2 000 000




ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ (сая хүн)



247 АЧАА УРСГАЛ, АЧАА ЭРГЭЛТ
Масштаб 1:4 500 000




А Ч А А Э Р Г Э Л Т
(сая тонн-км)




УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН



А Ч А А Т Э Э В Э Р Л Э Л Т
(сая тонн)








УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН



248 АГААРЫН ТЭЭВЭР

Масштаб 1:6 000 000



НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ

- Олон улсын
- Улсын
- Орон нутгийн

АГААРЫН ЗАМ

- Олон улсын
- Дотоодын улсын ач холбогдолтой
- орон нутгийн ач холбогдолтой








1:56 — Агаарын замын урт, километрээр

АГААРЫН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРЧИМ
(Волово хонгор ногдох нислэгийн өлс)

- 0-12
- 0-9
- 3-6
- 3-өөс доош

249 ХОЛБОО

Масштаб 1:6 000 000



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ

- Хотын телефон холбоо
- Хот хоорондын телефон холбоо
- Цахилгаан мэдээ
- Шуудан холбоо

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААН, СОЁЛ. ХУДАЛДАА. ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ

Атласын энэ бүлэгт орсон зургууд БНМАУ-ын ардын боловсрол, шинжлэх ухаан, соёл, эрүүлийг хамгаалах салбарын хөгжлийн төвшин, хүн амын үйлчилгээний хүрээний нутаг дэвсгэрийн зохион байгуулалтыг тусган үзүүлнэ. Эдгээр зурагт ерөнхий боловсролын сургууль, дээд, тусгай дунд боловсролын сургууль, техник мэргэжлийн сургуулийн байршил, төрөлжилтийг харуулснаас гадна зарим зураг нь шинжлэх ухааны байгууллага, соёл гэгээрийн газар, номын сангийн байршил, хэвлэл, радио, телевизийн хөгжил, худалдаа, нийтийн хоол, нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний хөгжлийг илэрхийлсэн байна.

Эрүүлийг хамгаалах салбарын зургууд тус орны хөдөлмөрчдийн эрүүл мэндийг хамгаалах талаар олсон ололтыг тусгаж, хүн амыг эмнэлгийн бүх төрлийн тусламжаар хангах явдал байнга сайжирч ирснийг илтгэн харуулна.

Хувьсгалын өмнөх Монгол орон нийт хүн амын боловсролын байдлаар Азийн хоцрогдсон орны нэг байжээ. Зөвхөн 1921 онд ялсан Ардын хувьсгал соёлын хувьсгал явуулах бодит нөхцөлийг бүрдүүлж, бичиг үсэг үл мэдэх явдлыг устгах, ерөнхий боловсролын сургууль байгуулж өргөжүүлэх, багш нарын анхны боловсон хүчин бэлтгэх ажлыг эхлэх бололцоог бий болгож өгсөн юм. Ардын хувьсгал ялснаас нэг сарын хойно 1921 оны 8-р сард ардын засгийн газар БНМАУ-д бага сургууль байгуулах тухай түүхт шийдвэр гаргасны дагуу 1921 оны 11-р сард Улаанбаатар хотод анхны бага сургуулийг 47 сурагчидтай нээжээ. Энэ нь өнөөгийн Монгол орон бүх нийтээрээ бичиг үсэгтэй орон болж хувирсан их өөрчлөн байгуулалтын эхлэл болсон юм.

Бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах, хөдөлмөрчдийн ерөнхий боловсролын төвшинг дээшлүүлэхэд ярианы хэлнээс нэлээд зөрөөтэй байсан хуучин монгол бичгийг кириллээр сольсон нь ач холбогдолтой болжээ. БНМАУ-д 1955—1958 онд бүх нийтээрээ анхан шатны боловсролтой болох зорилтыг хэрэгжүүлж, цаашид бүх нийтээрээ хөдөөд бүрэн бус дунд, хотод бүрэн дунд боловсрол заавал эзэмших системд шилжиж орсон билээ. 1985 онд тус оронд ерөнхий боловсролын 911 сургуульд 436,0 мянган хүн суралцаж байв.

1963 оноос мэргэжилтэй ажилчин бэлтгэх техник мэргэжлийн боловсролын систем бий болж эхлэв. Сүүлийн арав гаруй жилд техник мэргэжлийн сургуулийн тоо ихээхэн нэмэгдэж материаллаг бааз нь бэхжэв. 1970—1985 онд техник мэргэжлийн сургууль улс ардын аж ахуйд 60 мянга гаруй мэргэжилтэй ажилчин бэлтгэж өгчээ. 1985 онд техник мэргэжлийн 40 сургуульд 27 мянга гаруй сурагч тус орны улс ардын аж ахуйд зайлшгүй шаардлагатай 80 гаруй мэргэжлээр суралцаж байв.

Тусгай дунд боловсролын систем 1924 оноос бий болж эхэлсэн юм. Тэр үед багш нарыг бэлтгэх курсийн үндсэн дээр оюутны сургуулийг байгуулж улмаар 1928 онд багшийн сургууль болгон өргөтгөсөн билээ. 1985 онд тусгай мэргэжлийн 28 дунд сургуульд 23 мянга гаруй хүн суралцаж байв. Тусгай мэргэжлийн дунд сургууль улс ардын аж ахуйг мэргэжилтэй боловсон хүчнээр хангахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Монгол улсын их сургуулийг 1942 онд нээсэн явдал БНМАУ-ын соёлын амьдралд чухал үйл явдал болсон юм. 1950-иад оны эцсээр хөдөө аж ахуй, эдийн засгийн дээд сургуулиуд байгуулав. Одоо БНМАУ-д их сургууль, анагаах ухаан, хөдөө аж ахуй, политехник, орос хэлний дээд сургууль, 2 багшийн дээд сургууль ажиллаж тэдгээрт 24,6 мянган оюутан суралцаж байна.

Монголын ард түмний чухал ололт амжилтын нэг бол орчин үеийн шинжлэх ухааныг үүсгэн хөгжүүлсэн явдал мөн. Ардын хувьсгалын эхний жилд бий болсон эрдэм шинжилгээний анхны байгууллага болох Шинжлэх ухааны хүрээлэнгийн суурь дээр 1961 онд байгуулсан БНМАУ-ын Шинжлэх Ухааны Академи шинжлэх ухааны нэн чухал онолын асуудал, практик зорилтыг шийдвэрлэхэд эрдэм шинжилгээний боловсон хүчнийг нэгтгэн төвлөрүүлсэн юм. Сүүлийн арав гаруй жилд салбарын олон хүрээлэн шинээр байгуулагдлаа.

Манай нам засаг Ардын хувьсгалын бүр анхны өдрөөс эхлэн үндэсний соёлыг хөгжүүлэх талаар ихээхэн анхаарал тавьж ирсэн юм. 1924 онд Улаанбаатар хотод анх Д.Сүхбаатарын нэрэмжит клуб байгуулсны дараа 1925 онд зарим аймагт клуб байгуулагджээ. 1926 оноос хошуудад улаан булан байгуулж эхэлсэн байна. 1926 онд ардын цэнгэлдэх хүрээлэн, 1931 онд Улсын төв театр нээгдсэн нь үндэсний театрын түүхэнд чухал үйл явдал болсон юм. 1930-аад онд урлагийн шинэ төрөл-кино бий болов. 1934 онд Улаанбаатар хотод «Ард» кино театр нээгдсэн бол 1962 оноос кино үйлдвэрлэл хөгжиж эхлэв. «Монгол кино» үйлдвэр сүүлийн хорь гаруй жилд уран сайхны 70 гаруй кино бүтээжээ. 1941 онд мэргэжлийн циркийн урлаг бий болж 1971 онд Улаанбаатар хотод 2100 хүний суудалтай циркийн шинэ барилга ашиглалтад оров. 1985 онд тус улсад аймаг хотын соёлын ордон, клуб 449, улаан булан 1262, мэргэжлийн театр 21, кино театр 27, суурин кино 33, нүүдлийн кино 502 ажиллаж байв. Үзвэр үзэгчдийн тоо 1960 онд 5,4 сая байсан бол 1985 онд 28,6 сая болж өслөө. Одоо 1 хүн жилд дунджаар 15-аас доошгүй удаа ямар нэг үзвэр үзэж байна.

Нийтийн номын сангийн тоо түргэн өсөж ирлээ. Бүр 1921 онд байгуулсан багахан номын сан одоогийн улсын нийтийн номын сангийн үндэс суурь болсон юм. 1960 оноос 1985 он хүртэл номын сангийн тоо 33-аас 985 болж эрс нэмэгдсэн бөгөөд тэдгээрт 13,6 сая богь ном төвлөрч байна. Одоо сумын төв болгонд номын сан байгаагаас гадна бригада, суурьд нүүдлийн номын сан үйлчилж байна.

Хэвлэл буй ном, сонин, сэтгүүлийн тоо сүүлийн жилүүдэд улам нэмэгдлээ. 1985 онд БНМАУ-д 36 нэрийн сонинг жилд 121,8 сая хувиар, 38 төрлийн сэтгүүлийг жилд 6,2 сая хувиар хэвлэн гаргаж байв.

Тус улсын хүн амын үйлчилгээнд худалдаа чухал үүрэг гүйцэтгэдэг. 1921 оны 12-р сард Ардын харилцан туслалцах хоршоог 70 гишүүн, 15 мянган төгрөгийн хувь хөрөнгөтэйгээр байгуулсан нь тус орны социалист худалдааны эх үндэс болсон юм. Худалдаа 1940 оноос эхлэн улс ардын аж ахуйн биеэ даасан салбар болон хөгжиж ирлээ. 1985 онд жижиглэн худалдааны 5 мянга орчим цэг, түүний дотор дэлгүүр 1344, нийтийн хоолны газар 599 ажиллаж байв. 1924 онд бүхэл жилд борлуулснаас илүү барааг одоо нэг өдөрт борлуулж байна. 1985 онд нэг хүнд дунджаар 2198 төгрөгийн бараа борлуулсан нь 1960 оныхоос 2,1 дахин их юм.

Жижиглэн худалдаалах бараа гүйлгээний бүтэц сайжирсаар байна. Энэ нь хүнсний биш барааны худалдаалалт ба хэрэгцээний өсөлт түүрүүлэнгүй хурдтай байгаагаар тодорхой илэрч байна. Тус орны нийт жижиглэн худалдаалах бараа гүйлгээнд хүнсний биш барааны эзлэх хувийн жин 1970 онд 44,8 хувь байсан бол 1985 онд 50,6 хувьд хүрчээ. Одоо суурин газар бүхэн дэлгүүртэйгээс гадна бригадын төв, малчдын суурьт явуулын автомухлагийн худалдаа өргөн үйлчилж байна.

Ардын засаг, социалист өөрчлөлт хийж эхэлсэн анхны өдрөөс эхлээд хөдөлмөрчдийн эрүүл мэндийг хамгаалахын төлөө эрчимтэй тэмцэл явуулж ирлээ. 1921 онд Улаанбаатар хотод хүн эмнэлгийн газар анх байгуулж, 1930-аад онд аймгуудад хүн эмнэлгийн салбар байгуулж эхэлсэн байна. Тус орны хүн амын эмнэлгийн үйлчилгээ жилээс жилд сайжирч бүх нутаг даяар эмнэлгийн цэг, салбарууд байгуулагдлаа. Аймаг, хот бүхэнд поликлиник бүхий нэгдсэн эмнэлэг, хүүхдийн больниц, мэргэжлийн диспансер, ариун цэвэр-халдвар судлалын станц болон эмнэлгийн бусад байгууллага ажиллаж байна. Хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй бүрд сум дундын болон сумын эмнэлэг ажиллаж, үйлдвэр, албан газар, сургуулиудад их, бага эмчийн салбар үйлчилдэг.

БНМАУ-ын эрүүлийг хамгаалах салбарын нэг томоохон амжилт бол хүн амын нас баралтыг багасгаж хүний наслалтыг уртасгаж чадсан явдал мөн.

Манай нам засаг биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар их анхаарал тавьдаг юм. Монголын ард түмний уламжлалт спортын төрөл болох хурдан морин уралдаан, үндэсний бөхийн барилдаан, сур харвалтын зэрэгцээ орчин үеийн спортын олон төрөл өргөн дэлгэрч байна. Хүүхэд багачуудын бие бялдрын хүмүүжил, биеийн тамир, спортын хөдөлгөөнийг хөгжүүлэх талаар олсон амжилт нь тал бүрийн боловсролтой шинэ хүнийг төлөвшүүлэх болон хүн амын эрүүл мэндийг сайжруулахад чухал үр нөлөө үзүүлж байна. Одоо тус орон 80,3 мянга гаруй тамирчинтай, тэдний дотор нэг мянга гаруй нь спортын мастерын зэрэгтэй.

Нам засгаас хөдөлмөрчдийн эрүүл мэндийг сахин хамгаалах талаар авч явуулж буй олон талт арга хэмжээний нэг хэсэг нь амралт сувилал байгуулж, аялал жуулчлалыг хөгжүүлж байгаа явдал юм. Манай орон нарлаг өдөр олонтой, уулын цэвэр агаар, ой модоор баялаг, эмчилгээний шавар, рашаан ус элбэгтэй зэрэг нь рашаан сувилал, амралтын газар олноор байгуулах байгалийн таатай нөхцөлийг бүрдүүлдэг билээ. 1985 онд улс, орон нутгийн чанартай амралт, сувилал, пионерийн зуслан 130 байсан бөгөөд тэнд жилдээ 175 мянга гаруй насанд хүрэгчид ба хүүхэд сурагчид амарч сувилуулжээ. Монгол орон эртний түүх соёлын дурсгал, хувьсгалт тэмцлийн болон хөдөлмөрийн алдрын дурсгалт газар, байгалийн гайхам сонин зүйл ихтэй учраас дотоод гадаадын жуулчид, тойрон аялагчдын сонирхлыг татдаг юм. Сүүлийн арав гаруй жилд тойрон аяллын маршрутыг олон болгож, жуулчдын бааз, амралтын газар, гадаадын анчдад зориулсан ангийн нөөц газар зэргийг байгуулав.

Атласт орсон боловсрол, шинжлэх ухаан, соёл, худалдаа, эрүүлийг хамгаалахын зургууд нь хүн амын үйлчилгээний нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, төлөвлөлтөд ач холбогдолтой юм. Эдгээр зургийг суурин болон явуулын үйлчилгээний хөгжил, байршлыг төлөвлөхөд ашиглаж болно. Тухайлбал, хүн амын зургуудтай харьцуулан дүгнэж үзвэл хүн амын үйлчилгээний төвшин, цар хэмжээ нутаг нутагт ямар ялгаатайг бодитойгоор үнэлж, тэр үндсэн дээр тус орны янз бүрийн муж нутаг дахь үйлчилгээний ажлыг жигдрүүлэх арга замыг тодорхойлох боломж олгох юм.


250 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

Масштаб 1:6 000 000




251 ДЭЭД СУРГУУЛЬ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА

Масштаб 1:12 000 000




252 ТУСТАЙ МЭРГЭЖЛИЙН ДҮНД СУРГУУЛЬ, ТЕХНИК МЭРГЭЖЛИЙН СУРГУУЛЬ

Масштаб 1:12 000 000




253 СУРГУУЛИЙН ӨМНӨХ НАСНЫ ХҮҮХДИЙН БАЙГУУЛЛАГА

Масштаб 1:6 000 000




254 СОЁЛ УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГА

Масштаб 1:6 000 000




255 РАДИО, ТЕЛЕВИЗ

Масштаб 1:12 000 000




256 ХЭВЛЭЛ

Масштаб 1:12 000 000




257 НОМЫН САН

Масштаб 1:6 000 000




258 ХҮН АМЫН ХУДАЛДААНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

Масштаб 1:6 000 000




259 ХУДАЛДААНЫ БАЙГУУЛАГА

Масштаб 1:12 000 000




260 ХҮН АМЫН АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Масштаб 1:12 000 000




261 НИЙТИЙН ХООЛ

Масштаб 1:6 000 000




262 ХҮН АМЫН ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Масштаб 1:6 000 000




263 ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНЭЭР ХАНГАГДСАН БАЙДАЛ

Масштаб 1:12 000 000




264 АМРАЛТ, СУВИЛАП









Масштаб 1:12 000 000



265 БИЕИЙН ТАМИР, СПОРТ

Масштаб 1:6 000 000





АЖ АХУЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН БҮТЭЦ. ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА

Энэ бүлэг тус орны эдийн засгийн ерөнхий төлөв, олон улсын харилцааны өнөөгийн байдлыг тусган харуулна. Ерөнхий эдийн засгийн зураг нь БНМАУ-ын үйлдвэрлэх хүчний хөгжлийн одоогийн байдал, хэтийн төлвийг илтгэн харуулахын хамт байгаль, хүн ам, аж ахуйн талаарх материалыг нэгтгэсний хувьд нэгэнт бүрэлдэн тогтсон аж ахуйн цогцолбор хийгээд түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн харилцан үйлчлэлийн тухай тодорхой төсөөлөл өгч, нутаг дэвсгэр-үйлдвэрлэлийн бүтцүүд хэтдээ өөрчлөгдөх угтвар нөхцөл, тэдгээрийн нутаг дэвсгэрийн уялдаа холбоо, эдийн засгийн интеграцлалыг илэрхийлнэ. Түүнчлэн эдийн засгийн төвүүдийг янз бүрийн төвшний нутаг дэвсгэр-эдийн засгийн систем бүрэлдэн тогтоход оролцох байдал, нөлөөлөх ач холбогдлоор нь шатлан харуулж, нэгэнт бүрэлдэн тогтсон үйлдвэрлэлийн нутаг дэвсгэрийн системийн бүтцийг тодорхойлсон юм.

Ерөнхий эдийн засгийн зурагт БНМАУ-ын нутагт одоогоор бүрэлдэн тогтсон эдийн засгийн муж, төвүүдийг хэвшинжээр нь тодорхойлон үзүүлэв. Уг зурагт мөн зам харилцаа, тээвэр-эдийн засгийн уялдаа холбооны үндсэн чиглэл, ашигт малтмалын орд, хөдөө аж ахуй, ой ба усны аж ахуйн газруудыг үзүүлсэн байна.

Ерөнхий эдийн засгийн зургийн агуулгаас өнөөгийн БНМАУ бол улс ардын аж ахуйн цогцолбор нь эрчимтэй бүрэлдэн тогтох үе шатандаа яаа хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн орон мөнгийг харж болно.

Олон улсын харилцааны зурагт тус улсаас гадаад орнуудтай тогтоосон дипломат, соёл, эдийн засгийн харилцааг тусган үзүүлжээ. Хувьсгалын өмнөх Монгол оронд феодалын үйлдвэрлэлийн харилцаа ноёрхож байжээ. Хүн амын 90 орчим хувь нь бүдүүлэг арга ажиллагаатай нүүдлийн мал аж ахуй эрхэлж байсан ба хүн амын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хэрэгцээний 2/3-оос илүүг хувийн аж ахуйгаас, зөвхөн 1/3-ийг зах зээлээс хангаж байв. Аж үйлдвэр үнэн хэрэгтэй байхгүй байлаа. Дотоод, гадаад худалдаа бараг бүхэлдээ гадаадын капиталын гарт төвлөрч, тус улсад үндэсний валют, банк гэж байсангүй. Улсын төсвийн эх үүсвэрийн 80 гаруй хувь нь төрийн аппарат, сүм хийдэд зориулагдаж байсан билээ.

1921 онд ялсан Ардын хувьсгал монголын ард түмний амьдралд эргэлтийн үе шат болж үйлдвэрлэх хүчнийг бүх талаар хөгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлсэн юм. Ардын хувьсгалын жилүүдэд Монгол орон олон зууны хоцрогдлыг даван туулаад зогсоогүй феодализмаас социализмд шилжих их үсрэлт хийсэн билээ. БНМАУ өнөөдөр аж үйлдвэрийн олон салбар, социалист хөдөө аж ахуй, орчин үеийн тээвэр, холбоо бүхий эрчимтэй хөгжиж буй орон боллоо. 1985 оны байдлаар тус улсын нийт үндэсний орлогын бүтцэд аж үйлдвэр 32,6%, хөдөө аж ахуй 16,2%, барилга 5,0%, тээвэр, холбоо 11,5%, худалдаа, материал-техникийн хангамж 33,0%, бусад салбар 1,7%-ийг тус тус эзэлж байв. Улс ардын аж ахуйн бүх салбарын өсөлт өндөр хурдтай явж байна. Тухайлбал, 1940 оноос 1985 оны хооронд нийгмийн нийт бүтээгдэхүүн 16,2 дахин, үйлдвэрлэсэн үндэсний орлого 12,2 дахин, улс ардын аж ахуйн үндсэн фонд (мал ороод) 25,9 дахин, аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 50,4 дахин, хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүн 2,9 дахин, үүний дотор газар тариалан 241,4 дахин, бүх төрлийн тээврийн ачаа эргэлт 594,4 дахин нэмэгджээ.

БНМАУ-ын эдийн засгийн үндэс нь олон салбарт хөдөө аж ахуй (юуны өмнө мал аж ахуй), хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр төрөлжсөн аж үйлдвэрийн салбарууд юм. Мөн улс орны эдийн засгийн хөгжилд түлш, цахилгаан-эрчим хүч, уул уурхайн үйлдвэр, металл боловсруулах, барилгын материалын үйлдвэрлэл болон барилга, тээврийн салбарууд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Геологи-хайгуулын ажил эрчимжиж байгаагийн ачаар улс орны эрдэс түүхий эдийн бааз жилээс жилд бэхжиж, түүнийг дагалдан уул уурхайн аж үйлдвэрийн салбар түргэн хөгжиж байна. Зөвхөн сүүлийн арван жилд Эрдэнэтийн зэс-молибдены, Багануурын нүүрсний, Бор-Өндөрийн хайлуур жоншны зэрэг томоохон ордуудыг ашиглалтад орууллаа.

Тус оронд хөдөлмөрийн нөөц түргэн хурдтай өсөж, түүний ашиглалтын төвшин дээшилж байна. Улс орны байгаль, эдийн засаг, хөдөлмөрийн потенциал нэмэгдэхийн хэрээр эдийн засгийг цаашид хөгжүүлэх, улс ардын аж ахуйн цогцолборын оновчтой бүтцийг бүрдүүлэх шинэ өргөн боломж бий болж байна.

Ардын хувьсгалын жилүүдэд үйлдвэрлэлийн нутаг дэвсгэрийн бүтцэд ч ихээхэн өөрчлөлт гарлаа. Эдүгээ тус оронд олон салбарт аж үйлдвэрийн хэдэн арван төв, аж үйлдвэрийн зангилаанууд байгуулагдан, нутаг дэвсгэр-үйлдвэрлэлийн цогцолборууд бүрэлдэж байгаа бөгөөд аймгийн төвүүдийг уг чанартаа аймгуудын үйлдвэрлэлийн системийн нутаг дэвсгэр-интеграцийн цөм гэж нэрлэж болох юм.

БНМАУ-ын аж ахуйн нутаг дэвсгэрийн байршилд бодитой хөгжиж буй хоёр чиглэл байгаа юм. Үүнд нэг талаас, аж үйлдвэрийн шинэ томоохон төв, зангилаанууд бүрэлдэн тогтож, хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн цогцолбор үүсэх нөхцөл аажмаар бий болж, нөгөө талаас, гол төлөв орон нутгийн түүхий эд, хөдөлмөрийн нөөцийг бүрэн дүүрэн ашиглах чиглэлтэй түлш, эрчим хүч, хүнс, барилгын материалын үйлдвэрийн газрууд тус орны бүх нутагт харьцангуй жигд байршилтай байна.

1960-аад оноос эхлэн БНМАУ-д эдийн засгийн Төв, Дорнод, Өрнөд гэсэн гурван муж бүрэлдэн тогтож байгаа бөгөөд тэдгээр нь хөдөлмөрийн нутаг

дэвсгэрийн хуваарилалтын систем дэх аж ахуйн хөгжлийн чиглэл, нийгмийн үйлдвэрлэлд татан оруулж буй байгаль, эдийн засгийн нөөц боломжийн онцлог, үйлдвэрлэлд үйлчлэх тээвэр, барилга, нийгмийн хүрээний үйлчилгээний салбаруудын шинж байдлаар хоорондоо ялгаатай юм.

Эдийн засгийн Төв муж тус улсын нутаг дэвсгэрийн 55,3%-ийг хамрах бөгөөд бүх хүн амын 69,4% нь энд оршин суудаг. Тус мужид улсын хүн амын ба эдийн засгийн потенциалын зонхилох хэсэг нь төвлөрсөн явдал үйлдвэрлэх хүчнийг цаашид хөгжүүлэх хамгийн тохиромжтой угтвар нөхцөлийг бүрдүүлнэ.

Одоогийн байдлаар Төв мужийн эдийн засгийн төрөлжсөн үндсэн салбар бол уул уурхай, түлш-эрчим хүч, ой модны үйлдвэр, хөнгөн үйлдвэр, барилгын материалын үйлдвэрлэл болон газар тариалан юм. Энэ мужид БНМАУ-ын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 90 орчим хувь, газар тариалангийн бүтээгдэхүүний 60 шахам хувь оногдоно.

Төв мужийн аж ахуйн цогцолборын үндсэн цөмүүд болох Улаанбаатар, Дархан, шинээр бүрэлдсэн Эрдэнэтийн аж үйлдвэрийн зангилаануудад тус улсын томоохон үйлдвэрүүд байрлаж, шинжлэх ухаан, соёлын болон мэргэжилтэй боловсон хүчний гол потенциал төвлөрчээ.

Тус орны эдийн засаг болон үйлдвэрлэх хүчний нутаг дэвсгэрийн зохион байгуулалтад Төв мужийн энэхүү зонхилох роль ирээдүйд ч хэвээр байх болно. Ойрын хэдэн таван жилд Төв мужид нэгэнт бий болсон эдийн засгийн потенциалд тулгуурлан, эрдэс, ой, усны баялаг, материалын болон хөдөлмөрийн нөөцийг аль болох үр дүнтэй иж бүрэн ашиглах замаар БНМАУ-ын эдийн засгийн потенциалыг цаашид улам нэмэгдүүлэх, эдийн засгийн бүтцийг боловсронгуй болгох, энэ үндсэн дээр нийгмийн үйлдвэрлэлийн үр ашиг, ард түмний аж байдлыг дээшлүүлэхтэй холбогдсон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх улс ардын аж ахуйн томоохон зорилгыг шийдвэрлэх юм.

Эдийн засгийн Дорнод муж улсын бүх нутгийн 18,2%-ийг эзлэх бөгөөд нийт хүн амын 10% нь энд оршин суудаг. Тус мужийн эдийн засагт хөдөө аж ахуй, уул уурхай, хөнгөн, хүнсний үйлдвэрийн салбар чухал суурийг эзэлнэ. Хөдөө аж ахуй нь мах-сүүний үхрийн аж ахуй, хонины аж ахуй, үр тарианы үйлдвэрлэлээр төрөлжиж байгаа юм. Энд хөдөө аж ахуйн бүх эдэлбэр газрын 20 орчим хувь нь оногддог бөгөөд улсын ноосны 15,5%, махны 16%-ийг үйлдвэрлэж байна.

Сүүлийн жилүүдэд хүнсний болон уул уурхайн үйлдвэрийн хөгжлийг голлон түшиглэж тус мужийн аж үйлдвэрийн потенциал ихээхэн нэмэгдлээ. Дорнод мужийн аж ахуйн цогцолборын хөгжилд Чойбалсан хотын аж үйлдвэрийн зангилаа онцгой үүрэг гүйцэтгэнэ. Энэ зангилаа тус мужийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний тэн хагасыг үйлдвэрлэдэг бөгөөд хөнгөн, хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүн, нүүрс олборлол, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлээр төрөлжиж байгаа юм.


Үр тарианы үйлдвэрлэлийг цаашид бэхжүүлэх, тэжээлийн нөөцийг бүрэн дүүрэн ашиглах явдал ирээдүйд Дорнод мужийн хөдөө аж ахуйн хөгжлийн нэн чухал зорилт хэвээр байх болно. Энэ зорилгоор Халх гол орчмын атар газрыг эрчимтэй эзэмшиж, тэнд хөдөө аж ахуй-аж үйлдвэрийн томоохон цогцолбор бий болгоход онцлон анхаарч байна. ЗСБНХУ-ын хил залгаа нутагтай аж ахуйн хэлхээ харилцааг цаашид гүнзгийрүүлэх явдал тус мужийн эдийн засгийг түргэн хурдтай хөгжүүлэх нэг чухал чиглэл мөн.

Эдийн засгийн Өрнөд муж улсын бүх нутгийн 26,5%-ийг эзлэх бөгөөд нийт хүн амын 20,6% нь энд оршин суудаг. Энэ мужийн эдийн засагт бэлчээрийн мал аж ахуй зонхилсон хөдөө аж ахуй голлох суурийг эзэлнэ. Энд тус улсын бэлчээрийн бүх талбайн 30%, малын тоо толгойн 32% нь төвлөрдөг. Сүүлийн жилүүдэд орон нутгийн нөөцийг бүрэн дүүрэн ашиглах, хүн амын хэрэгцээг хангах шаардлагатай уялдаж барилгын болон хүнсний үйлдвэр түргэн хөгжиж байна.


